20000-50000, аж ахуйн нэгж байгууллагыг 100000-250000
дахь заалтын "25000 хүртэл" гэснийг "250000 хүртэл", 8 д
заалтын "15000-25000" гэснийг "150000-250000", 9 дэх заал
"15000-25000" гэснийг "150000-250000", 10 дахь заал
"15000-25000" гэснийг "иргэнийг 30000-50000, аж ах
нэгж, байгууллагыг 100000-250000" гэж тус тус өөрчилсүгэ

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 1-ний өдр
эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаат
хот

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн ту
хуулийн 43 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалтын "100(
гэснийг "иргэнийг 20000 хүртэл, аж ахуйн нэгж, байгуулла
100000", 2 дахь заалтын "1000-10000" гэснийг "иргэнийг 20(
20000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000", 3 д
заалтын "5000-20000" гэснийг "иргэнийг 10000-20000,
ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000" 4 дэх заалтын "50(
25000" гэснийг "иргэнийг 5000-25000, аж ахуйн нэ

йгууллагыг 50000-100000", 5 дахь заалтын "10000-25000" снийг "иргэнийг 10000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг)000-250000" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс лэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 4 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 2 дахь :гийн 1 дэх заалтын "1000" гэснийг "2000" 2 дахь заалтын)00" гэснийг "6000", 3 дахь заалтын "5000 хүртэл" гэснийг гэнийг 10000 хүртэл, байгууллага, аж ахуйн нэгжийг 75000)тэл", 4 дэх заалтын "10000 хүртэл" гэснийг "иргэнийг 20000)тэл, байгууллага, аж ахуйн нэгжийг 95000 хүртэл", 5 дахь лтын "1000-15000" гэснийг "иргэнийг 2000-30000, гууллага, аж ахуйн нэгжийг 75000-100000", 6 дахь заалтын)00-15000" гэснийг "иргэнийг 6000-30000, байгууллага, аж йн нэгжийг 95000-125000", 7 дахь заалтын "2000-20000" нийг "иргэнийг 4000-40000, байгуулага, аж ахуйн нэгжийг)00-150000", 8 дахь заалтын "25000" гэснийг "иргэнийг)00 хүртэл, байгууллага, аж ахуйн нэгжийг 250000", 9 дэх лтын "3000-25000" гэснийг "иргэнийг 6000-50000, гууллага, аж ахуйн нэгжийг 100000 -250000", 10 дахь лтын "5000-25000" гэснийг "иргэнийг 10000-50000, гууллага, аж ахуйн нэгжийг 150000-250000" гэж тус тус чилсүгэй.

дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ДАМПУУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн дампуурлын тухай хуулийн 1 дугаар зүйлийн "1500-3000" гэснийг "3000-10000" гэх өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 1-ний өдрөө эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулий 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "50000 хүртэл гэснийг "50000-100000", 2 дахь заалтын "холбогдох аж ахуй нэгж, байгууллагыг 100000 хүртэл" гэснийг "иргэнийг 5000 10000, албан тушаалтныг 10000-20000, аж ахуйн нэгж байгууллагыг 50000-100000" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 1-ний өдрөө эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨНИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай уулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1,2 дахь заалтыг дор урдсанаар өөрчилсүгэй:

"1/Энэ хуулийн 4,5,7,8 дугаар зүйлийг зөрчсөн нь эрүүгийн ариуцлага хүлээлгэхээргүй бол аж ахуйн нэгжийн эзэн буюу эрх ригч этгээдийг 50000 хүртэл, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000 хүртэл төгрөгөөр торгох;

2/Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад асан шийдвэр гарснаас хойш шүүхээс тогтоосон хугацаанд уг ийдвэрийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй буюу елүүлэхэд саад учруулсан бол шүүгч гэм буруутай албан ушаалтныг 20000 хүртэл, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000 ртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна."

2 дугаар зүйл. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай уулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтын "10000" снийг "20000" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс лэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Патентын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх сгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1. Патентын тухай хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч зөрчил гаргасан иргэнийг 50000 хүртэл, ажахуйн нэгж, байгууллагыг 250000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "этгээдэд" гэснийг "үйлдвэрлэгч, худалдагчид", 1 дэх заалтын "үйлдвэрлэгч, худалдагчид тавин мянга хүртэл" гэснийг "иргэнд 50000 хүртэл, байгууллага, аж ахуйн нэгжид 200000 хүртэл", 2 дахь заалтын "үйлдвэрлэгч, худалдагчид хорин мянга хүртэл" гэснийг "иргэнд 40000 хүртэл, байгууллага,аж ахуйн нэгжид 140000 хүртэл", 3 дахь заалтын "үйлдвэрлэгч, худалдагчид арван мянга хүртэл" гэснийг иргэнд 30000 хүртэл, байгууллага, аж ахуйн нэгжид100000 хүртэл" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 3 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж

1.Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулиар хамгаалах объект, түүнтэй холбогдсон нэр томьёо

1. Энэ хуулиар байгалийн дор дурдсан объектыг байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалж, байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлнэ:

1/газар, түүний хөлс;

2/газрын хэвлий, түүний баялаг;

3/ус;

4/ургамал;

5/амьтан;

6/агаар;

2. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/"байгаль орчин" гэдэгт хүний амьдрал, үйлажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг Монгол Улсын нутаг дэвсгэрийн чулуун мандал, усан мандал, шим мандал, агаар мандлын харилцан шүтэлцээт хүрээлэл хамаарна;

2/"ус" гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэр дэх мөрөн, гол, горхи, булаг, шанд, рашаан, мөнх цас, мөс, мөсөн гол, байгалийн болон хиймэл нуур, цөөрөм зэрэг газрын гадаргын болон газрын доорхи ус хамаарна;

3/"ургамал" гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт ургадаг байгалийн болон таримал ой, мод, бүх төрлийн дээд, доод ургамал, хамаарна;

4/"амьтан" гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавьж, зөөлөн биетэн, эгэл биетэн хамаарна;

5/"агаар" гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрийн хийн бүрхэвч хамаарна;

6/"байгаль орчинд хортой нөлөөлөх" гэдэгт байгаль орчин, түүний баялгийг бохирдуулах, муутгах, гэмтээх, сүйтгэх, сөнөөж мөхөөх үйлдэл /эс үйлдэхүй/ хамаарна.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан обьект тэдгээрийн баялгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг

1. Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахь эрхийг эдэлнэ:

1/гэм буруутай этгээд байгаль орчинд хортой нөлөөлснөөс эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлыг түүгээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;

2/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах;

3/байгаль орчныг хамгаалах олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх;

4/холбогдох байгууллагаас байгаль орчны тухай үнэн, зөв мэдээлэл авах;

5/байгаль орчинд хортой нөлөөлөх аливаа үйл ажиллагаан хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргахыг болон байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагы

шинээр байгуулах зөвшөөрөл олгохгүй байхыг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах.

2. Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ:

1/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

2/байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил эзэмшиж хэрэглэх, үр хүүхэддээ экологийн хүмүүжил олгох;

3/байгаль орчинд хортой нөлөөлөхөөс сэргийлэх, өөрийн буруугаас учруулсан хортой нөлөөлөл, түүний хохирлыг арилгах буюу нөхөн төлөх.

5 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаархи төрийн чиг үүрэг, зарчим

1. Төр нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор байгаль орчинд хортой нөлөөлөхөөс болон байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлэн хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2. Төр нь байгаль орчныг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараахь зарчим баримтална:

1/хүний амьдрах, хөдөлмөрлөх, амрах байгаль орчны тааламжтай нөхцөл бүрдүүлэх;

2/экологийн баримжаатай эдийн засгийг хөгжүүлж байгаль орчны тэнцлийг хангах;

3/байгалийн баялгийг шинжлэх ухааны үндэслэлтэй зохистой ашиглах нөхцөлийг хангах;

4/байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах явцдаа, үйл ажиллагаа ил тод байх.

6 дугаар зүйл. Байгалийн баялгийг өмчлөх

1. Газар, түүний хэвлий, ой, ус амьтан, ургамал болон байгалийн усад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх өгөөд Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд байгалийн баялгийг зохих төлбөр, хураамжийг төлж, гэрээ, тусгай зөвшөөрөл авсан эрхийн бичгийн дагуу ашиглаж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЛИЙН САН, СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

7 дугаар зүйл. Байгаль орчны үнэлгээ

1. Байгаль орчны унаган төрхийг хадгалах, түүний тэнцэл алдагдахаас сэргийлэх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх, байгалийн баялгийн ашиглалтыг зохицуулах зорилгоор байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг тус тус хийнэ.

2. Байгалийн баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хүсч байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үнэлгээг өөрийн зардлаар хийлгэх буюу үнэлгээг урьд нь тогтоосон бол түүнийг гүйцэтгэсний зардлыг төлнө.

3. Байгаль орчны үнэлгээг энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу эрх олгосон аж ахуйн нэгж, байгууллага хийж тухайн төрлийн байгалийн баялгийг хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

4.Аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөцийн үнэлгээ хийх эрхийг тухайн төрлийн байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ олгоно.

5. Дараахь шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны үнэлгээ хийх эрх олгоно:

1/мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байх;

2/хэмжилт, судалгааны багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх;

3/байгаль орчны үнэлгээ хийх батлагдсан арга зүйтэй байх;

4/үнэлгээ хийх асуудлаархи мэдээллийн сантай байх.

6.Аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны үнэлгээ хийх эрх олгох, байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх журмыг Засгийн газар тогтооно.

8 дугаар зүйл. Байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ

1.Байгалийн тодорхой төрлийн баялгийн хэмжээг тоо, чанар болон мөнгөн үзүүлэлтээр тодорхойлсныг байгалийн баялгийн

нөөцийн үнэлгээ гэнэ.

2. Үнэлгээгээр байгалийн баялгийн нөөцийн хэмжээ, тухайн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээх арга хэмжээг тогтоож, байгаль орчны улсын нэдээллийн төв санд бүртгэнэ.

3.Байгалийн баялгийн нөөцийн мөнгөн үнэлгээг экологи, эдийн асгийн ач холбогдлыг харгалзан төрийн захиргааны төв айгууллага холбогдох бусад байгууллагатай хамтран тогтооно.

4.Нөөцийн мөнгөн үнэлгээг тухайн баялгийн нөөц ашигласны өлбөр, хураамж, байгальд учруулсан хортой нөлөөлөл, шууд охирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох үндэс болгоно.

9 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх
байдлын үнэлгээ

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага явуулж байгаа йлдвэрлэл, үйлчилгээний явцад хүн амын эрүүл мэнд, байгаль рчинд учирч болзошгүй хортой нөлөөлөлийг урьдчилан одорхойлж түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тогтоохыг айгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ /цаашид "нөлөөллийн нэлгээ" гэх/ гэнэ.

2. Байгаль орчинд хортой нөлөөлөх үйлдвэрлэл, үйлчилгээ рхлэх, шинээр байгуулах, өргөтгөх төсөл, хөтөлбөр оловсруулах, гэрээ байгуулах бүрт нөлөөллийн үнэлгээ ийлгэнэ.

3. Нөлөөллийн үнэлгээний зардлыг захиалагч этгээд анхүүжүүлнэ.

4. Нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон шаардлагыг төсөл, этөлбөр, гэрээг хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага елүүлэх үүрэгтэй.

10 дугаар зүйл. Байгаль орчны төлөв байдлын
хяналт-шинжилгээ

1. Байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээнд байгаль рчны төлөв байдал, түүний хувьсал өөрчлөлтөд байнгын киглалт, хэмжилт, судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, эрсэн сөрөг өөрчлөлтийг зогсоох, арилгах арга хэмжээ оловсруулах үйл ажиллагаа хамаарна.

2. Төрийн захиргааны төв байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсэгт асан ажлыг хэрэгжүүлэх зорилгоор байгаль орчны төлөв йдлын хяналт-шинжилгээний сүлжээ /цаашид "хяналт-шинилгээний сүлжээ" гэх/-г зохион байгуулж ажиллуулна.

3.Хяналт-шинжилгээний сүлжээгээр дараахь ажлыг хэрэгжүүлнэ:

1/байгаль орчинд гарах физик, хими, биологийн хувьсал өөрчлөлт, бохирдолтын түвшинд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа хийж байгаль орчны төлөв байдлын өөрчлөлтийг тогтоох, үнэлгээ өгөх;

2/байгаль орчин, түүний баялгийн талаар хүн ам, сонирхогч аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр хангах;

3/хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах хортой нөлөө, байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах арга хэмжээний төсөл боловсруулах.

11 дүгээр зүйл. Байгаль орчны судалгаа, шинжилгээ, түүний санхүүжилт

1. Улсын болон бүс нутгийн хөгжлийн баримжааг тодорхойлох, нэн ховордсон амьтан, ургамлыг нөхөн сэргээх, өсгөн үржүүлэх, хөрс, ус, агаарыг хамгаалах болон хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах талаархи судалгаа, шинжилгээний ажлыг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

2. Төрийн захиргааны төв байгууллага, зохих шатны Засаг дарга нь эрдэм шинжилгээний болон холбогдох мэргэжлийн байгууллагад байгаль орчны судалгаа, шинжилгээний ажил хийх, төсөл боловсруулах захиалга өгч, шинжлэх ухаан, технологийн сангийн болон зохих төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээс гадна сонирхогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өөрийн хөрөнгөөр судалгаа, шинжилгээ хийхэд нь дэмжлэг үзүүлнэ.

12 дугаар зүйл. Байгаль орчны мэдээллийн сан

1. Байгаль орчны мэдээллийн улсын нэгдсэн сан /цаашид "мэдээллийн сан" гэх/ нь:

1/сумын мэдээллийн сан;

2/аймаг, нийслэлийн мэдээллийн сан;

3/ улсын мэдээллийн төв сангаас бүрдэнэ.

2. Улсын мэдээллийн төв сан нь төрийн захиргааны төв байгууллага болон судалгаа, шинжилгээний байгууллагын гүйцэтгэсэн газар, газрын хэвлий, тэдгээрийн баялаг, ой, ус, амьтан, ургамал, агаарт хийсэн ажиглалт, хэмжилт, судалгаа, шинжилгээний ажлын тайлан, мэдээ, нөлөөллийн үнэлгээ болон аймаг, нийслэлийн мэдээллийн сангийн мэдээ, баримтаас бүрдэнэ.

3. Сум, аймаг, нийслэлийн мэдээллийн сан тухайн нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан ажлын тайлан, мэдээ

баримтаас бүрдэнэ.

4. Сум, аймаг, нийслэлийн мэдээллийн санг тухайн шатны Засаг дарга, улсын мэдээллийн төв санг төрийн захиргааны төв байгууллага гүс тус эрхэлнэ.

5. Улсын мэдээллийн төв санг бүрдүүлэх журмыг Засгийн газар тогтооно.

6. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн судалгаа, шинжилгээний ажлын тайлан, мэдээ, баримтыг мэдээллийн зохих санд үнэ төлбөргүй шилжүүлнэ.

7. Иргэн, төрийн өмчийн бус аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр гүйцэтгэсэн судалгаа, шинжилгээний тайлан, зураг төсөл, бусад мэдээллийг төрийн захиргааны төв байгууллага болон зохих шатны Засаг дарга худалдан авч болно.

8. Мэдээллийн сангийн тайланг сумын Засаг дарга жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрөөр тасалбар болгон 12 дугаар сарын 01-ний дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга 12 дугаар сарын 31-ний дотор төрийн захиргааны төв байгууллагад, төрийн захиргааны төв байгууллага нь улсын нэгдсэн тайланг дараа оны 1 дүгээр сарын 31-ний дотор Засгийн газарт тус тус ирүүлнэ.

9. Засгийн газар байгаль орчны төлөв байдлын талаархи тайланг Улсын Их Хурлын жил бүрийн хаврын чуулганд өргөн мэдүүлэх бөгөөд түүнд дараахь асуудлыг тусгана:

1/байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээхэд зориулсан улсын төсвийн ба төсвийн бус хөрөнгийн зарцуулалт;

2/байгаль орчны төлөв байдлын болон байгалийн баялгийн нөөцийн хувьсал өөрчлөлт;

3/байгалийн баялгийн нөөцийн ашиглалт, нөхөн сэргээлт;

4/орчны бохирдлын эх үүсвэр, түвшин, түүнийг бууруулах талаар авсан арга хэмжээ, үр дүн.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТАЛААРХИ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

13 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

Улсын Их Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн

эрхийг хэрэгжүүлнэ:

1/байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлогыг тодорхойлох;

2/ Засгийн газрын өргөн мэдүүлснээр байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлах;

3/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг батлах тэдгээрийн биелэлтэд хяналт тавих;

4/байгалийн баялгийн нөөцийг ашигласны болон орчныг бохирдуулсны төлбөр, хураамжийн дээд, доод хэмжээг тогтоох;

5/устах аюулд орсон амьтан, ургамлын жагсаалтыг батлах, өөрчлөх, байгалийн зарим объектыг улсын тусгай хамгаалалтад авах;

6/хуульд заасан бусад бүрэн эрх.

14 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх

Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2/байгалийн баялгийг ашиглах, импортлох, экспортлох хэмжээг хуульд заасан үндэслэлээр хязгаарлах;

3/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хортой нөлөөлөл бүхий үйлдвэрлэлийн болон бусад үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг харгалзан өмчийнх нь хэлбэрийг үл харгалзан зогсоох;

4/амьтан, ургамал, түүнчлэн байгалийн гаралтай түүхий эд экспортлох, импортлоход хил, гааль, хорио цээрийн хяналтыг зохион байгуулах;

5/байгаль хамгаалах сан байгуулах, зарцуулах журам тогтоох;

6/иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг зохион байгуулах;

7/хуульд заасан бусад бүрэн эрх.

15 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2/байгаль орчныг хамгаалах тодорхой асуудлаар төрийн захиргааны бусад төв байгууллага, аймаг, нийслэлийн хэмжээнд өөрөх шийдвэр, дүрэм, журам баталж биелэлтийг хангуулах;

3/байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар салбар дундын болон бүс нутаг хоорондын зохицуулалт хийх, байгаль орчны чадавхийн хэм хэмжээ, стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах буюу төрийн захиргааны холбогдох төв байгууллагатай хамтран баталж, биелэлтийг зохион байгуулах;

4/хууль тогтоомжийн дагуу жил бүр ашиглаж болох ой, ургамал, амьтны тоо хэмжээг тодорхойлж, экологийн шаардлага, өөцийг харгалзан тухайн бүс нутагт байгалийн зарим төрлийн баялгийн ашиглалтыг хязгаарлах;

5/байгаль орчныг хамгаалах талаар улсын захиалга өгч удалгаа, шинжилгээ, зураг төслийн ажил гүйцэтгүүлэх, өөрийн харьяа судалгаа, шинжилгээ, зураг төслийн болон мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг удирдах;

6/байгаль орчны тухай мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах;

7/байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад аргачилсан туслалцаа үзүүлэх;

8/байгаль орчныг хамгаалах асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

9/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хууль тогтоомжийг зөрчсөний улмаас байгаль орчинд учирсан хохирлыг арилгуулах ажлыг зохион байгуулах;

10/байгаль орчны улсын ерөнхий байцаагч, төрийн захиргаа нь өв байгууллагад ажиллах улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар ангах;

11/хуульд заасан бусад бүрэн эрх.

2.Төрийн захиргааны бусад төв байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/салбарынхаа хөгжлийн чиг баримтлалд байгаль орчны хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг тухайлан тусгаж хэрэгжүүлэх;

2/салбартаа байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж үр дүнг жил бүр Засгийн газарт тайлагнах.

16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж биелэлтэд хяналт тавих;

2/нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоох;

3/байгаль орчны улсын тусгай хамгаалалтад ороогүй объектын орон нутгийн хамгаалалтад авах шийдвэр гаргаж, түүний хилийг зааг, хамгаалалтын дэглэм тогтоомж, биелэлтэд нь хяналт тавих;

4/хот, тосгон, бусад суурин болон амралт, сувиллын газар, голмөрний эх, нуур, рашаан, булаг, шанд, уст цэгийн орчинг хамгаалах эрүүлжүүлэхийн шаардлагыг хангах тусгай бүсийн заагийг тогтоох;

5/байгаль орчны төлөв байдал, мэдээллийн сангийн тухай Засаг даргын мэдээлэл, тайланг хэлэлцэх.

2.Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

3/байгаль орчны мэдээллийн сангийн мэдээ, баримтыг төрийн захиргааны төв байгууллагад хугацаанд нь ирүүлэх;

4/нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж бу

үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

5/байгаль орчныг хамгаалах талаар төрийн хяналт тавих байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах, нутаг дэвсгэртээ ажиллах байгаль орчны улсын ахлах болон улсын байцаагчийг энэ хуульд заасны дагуу ялгах тэмдэг, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах.

17 дугаар зүйл. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх

1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;

2/нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн хэмжээг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу тогтоох;

4/байгаль орчныг хамгаалах талаар Засаг даргын ажлын тайлан хэлэлцэх.

2.Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг хууль тогтоомжийн дагуу олгох;

3/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын байгалийн баялгийн ашиглалтад хяналт тавьж, тэдний ургуулсан ой, ургамал, өсгөн үржүүлсэн амьтан, сэргээн сайжруулсан, засаж тохижуулсан газар, уст цэгийг хүлээн авах;

4/нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

5/байгаль хамгаалагчийн ажлыг удирдан чиглүүлэх, албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах ялгах тэмдэг, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар орон нутгийн төсөвтөө тусган хангах, шаардлагатай бусад туслалцаа үзүүлэх;

6/аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын цэг тогтоох, бохирдлыг багасгах арга хэмжээ авах.

18 дугаар зүйл. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал болон Засаг даргын бүрэн эрх

1.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлан, бэлчээр, уст цэгийг хамгаалах, ашиглах хуваарь гаргаж зохицуулах;

2/нийтийн ашиглалтын байгалийн баялгийн хамгаалалт, ашиглалтад хяналт тавих;

3/байгаль орчныг хамгаалах талаархи Засаг даргын ажлын тайлан сонсох.

2.Баг, хорооны Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/байгаль орчныг хамгаалах талаархи хууль тогтоомж, иргэдийн Нийтийн Хурал болон дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

2/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах ажлыг удирдан чиглүүлж орчны бохирдол, хог хаягдлыг цэвэрлэх жил бүрийн ажилд иргэдийг татан оролцуулах;

3/хууль тогтоомжид заасан тохиолдолд байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгох;

4/нутаг дэвсгэртээ орчны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулах, нийтийн хог хаягдлын цэг тогтоох.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, БАЙГАЛИЙН БАЯЛГИЙГ АШИГЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ НИЙТЛЭГ АРГА ХЭМЖЭЭ

19 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах нийтлэг арга хэлбэр

1.Монгол Улс санхүүгийн баталгаа бүхий "Байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөл-

бөр"-тэй байна.

2.Төр, түүний байгууллага, албан тушаалтан дараахь нийтлэг арга хэлбэрээр байгаль орчныг хамгаална:

1/нэн ховор амьтныг агнах, барих, ургамлыг бэлтгэж ашиглахыг хориглох;

2/нэн ховор, ховор амьтан ургамлыг Монгол Улсын улаан номонд бүртгэж хамгаалах;

3/байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийн хэм хэмжээ, стандарт тогтоож мөрдүүлэх;

4/хүн амд экологийн боловсрол, хүмүүжил олгох, үндэсний өв уламжлалыг эзэмшүүлэх;

5/хоргүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлэн ашиглахыг урамшуулах;

6/хот, тосгон, бусад суурин газрын орчинд болон гол, мөрөн нуур, рашаан, булаг, шандын эх, ундаргын орчныг хамгаалах, эрүүл ахуйн бүс тогтоох.

20 дугаар зүйл. Байгаль орчны чадавхийн хэм хэмжээ

1.Хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, байгаль орчныг хамгаалах зорилгоор байгаль орчинд гаргах хорт бодисын агууламж, үзүүлэх хортой нөлөөллийн түвшний хэм хэмжээ /цаашид "байгаль орчны чадавхийн хэм хэмжээ" гэх/ -г дараахь үзүүлэлтээр тогтооно:

1/агаар, ус, хөрс дэх хими, биологийн хортой бодисын хүлцэх хэм хэмжээ;

2/байгаль орчинд хаяж болох хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;

3/чимээ, шуугиан, чичиргээ, цахилгаан соронзон талбай болон физикийн бусад хортой нөлөөллийн хүлцэх хэм хэмжээ;

4/цацраг идэвхжлийн хүлцэх хэм хэмжээ;

5/газар тариалан, бэлчээр хамгаалахад хэрэглэх агрохимийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;

6/хүнсний бүтээгдэхүүн дэх химийн бодисын зөвшөөрөх дээд агууламж;

7/байгаль орчны даацын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 3, 4, 6-д заасан хэм хэмжээг стандартчиллын байгууллага тогтооно.

3.Байгаль орчны чадавхийн тогтоосон хэм хэмжээг хэтрүүлэн байгаль орчинд хорт бодис гаргасан, хортой нөлөөлөл үзүүлсэн

иргэн, аж ахуйн нэгж, байгууллага шаардлагатай бол байгаль орчинд учруулсан хохирлыг өөрөө арилгах буюу мэргэжлийн байгууллагаар арилгуулж гарсан зардлыг нөхөн төлнө.

21 дүгээр зүйл. Байгаль орчныг бохирдохоос хамгаалах

1. Байгаль орчны чадавхийн тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлж үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдал хаяхыг байгаль орчныг бохирдуулах гэнэ.

2. Бохирдуулах эх үүсвэрийн улсын нэгдсэн бүртгэлийг төрийн захиргааны төв байгууллага хөтөлнө.

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулахгүй байх талаар дараахь үүрэгтэй:

1/хортой, галын аюултай бодис болон хог хаягдлыг гагцхүү тусгайлан тогтоосон зориулалтын газар зөвшөөрөгдсөн аргаар булах, устгах;

2/хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан, тусгайлан тоноглогдсон тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаях;

3/оршин суугаа /оршин байгаа/ орчноо болон нүүхдээ бууцаа цэвэрлэж, шаардлагатай бол ариутгаж байх;

4/хашаа, байрныхаа орчны хог хаягдлыг тогтмол цэвэрлэх,

4.Цацраг идэвхт болон химийн хорт бодис үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах хуулиар, үйлдвэрлэл, ахуйн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хоргүйжүүлэх, халдваргүйжүүлэх, боловсруулах, булах, устгах журмыг Засгийн газар тус тус тогтооно.

22 дугаар зүйл. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул бүхий газар нутаг

1. Хүний үйл ажиллагаа болон байгалийн үйл явцаас шалтгаалан байгаль орчин, хүн ам, мал, амьтан ургамал, тэдгээрийн удмын санд хөнөөл учруулахуйц хортой нөлөөлөл, өөрчлөлт үүссэн нутаг дэвсгэрийг байгалийн гамшиг, гэнэтийн аюул бүхий газар нутаг гэнэ.

2.Байгалийн гамшиг, гэнэтийн аюул бүхий газар нутагт хамрах бүсийн заагийг төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

3. Байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас сэргийлэх, түүний эх үүсвэрийг хязгаарлах, хор уршгийг арилгах, байгаль орчныг засаж сайжруулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээг

төрийн захиргааны төв байгууллага, иргэний хамгаалалтын алба, бүх шатны Засаг дарга, холбогдох бусад байгууллага хамтран авч хэрэгжүүлнэ.

4.Байгалийн гамшиг, гэнэтийн аюулын хор уршгийг арилгах зардлыг улсын төсвөөс гаргаж, учруулсан хохирлын шалтгааныг тогтоосны дараа түүнийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

23 дугаар зүйл. Онц байдал тогтоосон үед
байгаль орчныг хамгаалах

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар онц байдал тогтоосон нутаг дэвсгэрт байгалийн гамшиг, гэнэтийн аюулыг сааруулах, түүний хор уршгийг арилгах, байгаль орчин, түүний баялгийг хамгаалах арга хэмжээг онц байдлын тухай болон онц байдал зарласан хуульд заасан үндэслэл, журмын дагуу авч хэрэгжүүлнэ.

24 дүгээр зүйл. Байгалийн баялгийн нөөцийн
ашиглалтын дээд хэмжээ

1.Байгалийн баялгийн нөөцийг түүний даац, нөхөн сэргэх чадварыг харгалзан тодорхой хугацаанд ашиглаж болох хэмжээг байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын дээд хэмжээ гэнэ.

2.Байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын дээд хэмжээг байгалийн тухайн баялгийг хамгаалах, зохистой ашиглах тухай хуульд заасны дагуу тогтооно.

25 дугаар зүйл. Байгалийн баялгийг
нөхөн сэргээх

1.Байгалийн баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчны тэнцлийг хангах зорилгоор дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

1/ховордсон амьтан, ургамлын ашиглалтыг хязгаарлах, тэдгээрийг үржүүлэх, нутагшуулах тэжээлээр хангах зэргээр нөөцийг нь нэмэгдүүлэх;

2/байгалийн баялаг ашигласан газар, орчныг засаж сайжруулах, тохижуулах.

2.Монгол Улсын нутаг дэвсгэрт байдаггүй амьтныг үржүүлэх, нуташуулах ургамлыг тарималжуулах, эгэл биетнийг өсгөвөрлөх ажлыг төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий бусад байгууллагын зөвшөөрөл, хяналтын дор гүйцэтгэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ

26 дугаар зүйл. Байгаль орчны хяналт

1.Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангана.

2.Хил, гааль, мал эмнэлэг, эрүүл ахуй, халдвар судлал, уул уурхайн зэрэг хяналтын байцаагч буюу хуульд зааснаар энэхүү хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтанд байгаль орчны сайдын тушаалаар байгаль орчны улсын байцаагчийн эрх олгож, хяналтын үүрэг гүйцэтгүүлж болно.

3.Төрийн захиргааны төв байгууллагад байгаль орчны улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, аймаг нийслэлд улсын ахлах байцаагч, улсын байцаагч, сум, дүүрэгт улсын байцаагч /цаашид "улсын байцаагч" гэх/ болон байгаль хамгаалагч тус тус ажиллана.

4.Улсын байцаагчийг дараахь байдлаар томилж, чөлөөлнө:

1/улсын ерөнхий байцаагчийг Байгаль орчны сайдын санал болгосноор Засгийн газар;

2/улсын ахлах байцаагч, төрийн захиргааны төв байгууллагад ажиллах болон аймаг, нийслэлийн улсын байцаагчийг Байгаль орчны сайд;

3/сум, дүүргийн улсын байцаагчийг улсын ахлах байцаагчийн санал болгосноор аймаг, нийслэлийн Засаг дарга;

4/байгаль хамгаалагчийг Засгийн газраас тогтоосон нормативын дагуу сум, дүүргийн Засаг дарга.

27 дугаар зүйл. Улсын байцаагчийн эрх, үүрэг

1.Улсын байцаагч дараахь эрхтэй байна:

1/иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад харьяалал харгалзахгүйгээр хянан шалгах;

2/хяналтад шаардагдах мэдээ, баримтыг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар гаргуулах;

3/хууль тогтоомж, стандарт, зөвшөөрөгдөх дээд хэмжээг зөрчиж байгаль орчинд хортой нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уг зөрчлийг арилгахыг шаардах, тодорхой хугацаагаар үйл ажиллагааг нь түдгэлзүүлэн зогсоох;

4/хяналт, шалгалт хийхээр аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, сорьц, дээж авах, тэдгээрийг өөрийн хяналтын дор шинжлүүлэх;

5/байгалийн гамшиг, гэнэтийн аюулын үед шаардлагатай бол нийтийн тээврийн хэрэгслээр дараалал харгалзахгүйгээр зорчих, бусад тээврийн хэрэгслийг дайчилж хөлсийг нь төлөх;

6/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн иргэний бичиг баримтыг шалгах, хууль бусаар агнасан, түүсэн, бэлтгэсэн зүйл, зэвсэг, хэрэгслийг хураан авах, шаардлагатай бол тээврийн хэрэгсэлд нь үзлэг хийх, бичиг баримтыг түр хураах;

7/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хуульд заасан захиргааны шийтгэл ногдуулах;

8/байгаль хамгаалагчийн ажлыг шалгах, заавар өгөх.

2.Улсын байцаагч дараахь үүрэгтэй байна:

1/байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлэхдээ хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг чанд сахин биелүүлэх;

2/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчлийн шинж байдал /зөрчил гаргагчийн нэр, хаяг, үйлдлийн шинж байдал, учруулсан хохирол, хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл/-ын тухай тэмдэглэл хөтлөн зөрчил гаргагчийн гарын үсэг зуруулах буюу зурахаас татгалзсан бол энэ тухай тайлбар тэмдэглэл хийх;

3/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад захиргааны шийтгэл ногдуулах, тэдгээрийн хууль бус үйл ажиллагааг түдгэлзүүлэн зогсоохдоо түүний үндэслэл, шалтгааныг хууль тогтоомжийн зүйл, заалтын дагуу тодорхойлж, баталсан загвараар үйлдсэн акт буюу торгуулийн хуудаст тэмдэглэх;

4/илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авахдаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, үйлдвэрлэлийн нууцыг хадгалах;

5/зөрчил гаргагчаас хуульд заасан үндэслэлээр хураан авсан зүйл, зэвсэг, хэрэгсэл, түр хураасан бичиг баримтын бүртгэлийг үйлдэж эзэнд нь үлдээж, зэвсэг, хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж эрх бүхий байгууллагад хугацаанд нь шилжүүлэх.

28 дугаар зүйл. Байгаль хамгаалагчийн эрх, үүрэг

1.Байгаль хамгаалагч дараахь эрхтэй байна:

1/нутаг дэвсгэртээ энэ хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3,4,5-д заасан улсын байцаагчийн эрхийг хэрэгжүүлэх;

2/нутаг дэвсгэртээ энэ хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6,7-д заасан улсын байцаагчийн эрхийг хууль д тусгайлан заасан тохиолдолд хэрэгжүүлэх.

2.Байгаль хамгаалагч энэ хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна дараахь үүрэгтэй байна:

1/хариуцсан нутаг дэвсгэртээ байгаль орчинд учирч болзошгүй аюулаас сэргийлэх, байгалийн баялгийг хамгаалах арга хэмжээ авах;

2/хууль тогтоомжид заасан тохиолдолд байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгох;

3/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн дагуу тухайн баялгийн ашиглах газрыг зааж өгөх;

4/хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн баялгийн өөрчлөлтийн ажиглалт хийж, мэдээг мэдээллийн санд тусгуулах;

5/байгалийн гамшиг, гэнэтийн аюул гарсан даруйд зохих шатны Засаг даргад мэдээлж, хор уршгийг арилгах арга хэмжээ авах;

6/хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн баялгийг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах.

29 дүгээр зүйл. Улсын байцаагч, байгаль хамгаалагч галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх

1.Улсын байцаагч, байгаль хамгаалагч хээрийн нөхцөлд хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үедээ галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл биедээ авч явах эрхтэй.

2.Улсын байцаагч, байгаль хамгаалагч хээрийн нөхцөлд хяналт шалгалт хийх үедээ илэрсэн зөрчил, гадны халдлагыг өөр арга хэрэгслээр таслан зогсоох боломжгүй бол дараахь тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно:

1/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээд хууль ёсны шаардлагыг нь илт эсэргүүцэн зэвсэг хэрэглэх буюу өөр аргаар хүч хэрэглэн амь насанд нь халдсан;

2/зэрлэг амьтан довтолж амь насанд аюул учруулахад хүрсэн.

3.Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээд улсын байцаагч, байгаль хамгаалагчийн хууль ёсны шаардлагыг хүч хэрэглэн эсэргүүцвэл резинэн болон цахилгаан бороохой, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу зэрэг нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж болно.

4.Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан Улсын ерөнхий

прокурортой зөвшилцөн цагдаагийн төрийн захиргааны төв байгууллага батална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

БАЙГАЛЬ ОРЧИН, БАЙГАЛИЙН БАЯЛГИЙГ ХАМГААЛАХ ТАЛААРХИ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ

ЗО дугаар зүйл. Мэргэжлийн байгууллага

1.Ой, амьтан, ус, ашигт малтмал зэрэг байгалийн баялаг хамгаалах, зохистой ашиглах асуудлыг хуулиар болон төрийн захиргааны төв байгууллагаас олгосон эрхийн дагуу эрхлэн зохицуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн байгууллага гэнэ.

2.Мэргэжлийн байгууллага хариуцсан нутаг дэвсгэртээ дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1/төрийн захиргааны төв байгууллага, Засаг даргын шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгалийн баялгийг ашиглах гэрээ байгуулах, уг гэрээний дагуу байгалийн баялгийг ашиглах газрыг зааж өгөх;

2/байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх төсөл, төлөвлөгөө боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, эрх олгосон тохиолдолд нөлөөллийн үнэлгээ хийх;

3/байгалийн нөөцийн судалгаа хийлгэх захиалга өгөх;

4/байгалийн баялгийг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж, түймэр зэрэг байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэдгээртэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

5/байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад технологийн хяналт тавих, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

6/хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн баялгийн өөрчлөлтийн ажиглалт хийж, мэдээг мэдээллийн санд тусгуулах;

7/байгалийн баялгийг судлах, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх, шаардлагатай бол төрийн захиргааны төв байгууллагад уламжлах;

8/байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах, арчлах, тэдгээрийг ашиглан хууль тогтоомжид заасан журмын дагуу үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх.

31 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

Аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараахь үүрэгтэй байна:

1/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын шийдвэр, улсын байцаагч, байгаль хамгаалагчийн шаардлагыг биелүүлэх;

2/эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны холбогдолтой стандарт, хэм хэмжээ, дүрэм, журмыг чанд сахин биелүүлж дотоодын хяналтыг хэрэгжүүлэх;

3/үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх явцад байгаль орчинд гаргах байгаа хорт бодис, физикийн хортой нөлөөлөл, хог хаягдлын хэмжээг бүртгэж, тэдгээрийг багасгах, цэвэрлэх талаар авсан арга хэмжээ, хянах төхөөрөмжийн ажиллагааны тухай тайлан мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад өгөх;

4/байгаль орчинд хортой нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага эвдэрсэн газар, хордож бохирдсон хөрс, усыг цэвэршүүлэх, ургамал амьтныг нөхөн үржүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх;

5/гэрээний дагуу тарьж ургуулсан ой, ургамал, үржүүлсэн амьтан, сэргээн сайжруулсан усны ундарга, засаж тохижуулсан газрыг сум, дүүргийн Засаг даргад хугацаанд нь хүлээлгэн өгөх;

6/төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу экологийн паспорт хөтлөх.

32 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалахад олон нийтийн байгууллага оролцох

1.Байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилгыг бүхий олон нийтийн байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:

1/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

2/байгаль орчныг хамгаалах талаархи саналаа төрийн захиргааны төв байгууллага болон зохих шатны Хурал, Засаг даргад уламжлах;

3/экологийн сургалт, хүмүүжлийн ажлыг өөрөө болон холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

4/байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, зөвлөмж, аргачлал боловсруулж холбогдох байгууллагад танилцуулж шийдвэр гаргуулах.

2.Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаархи төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий олон нийтийн байгууллагад шилжүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно.

ДОЛДУГААР ЗҮЙЛ

БУСАД ЗҮЙЛ

33 дугаар зүйл. Санхүүжилт

1.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавихад шаардагдах зардлыг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

2.Хуульд өөрөөр заагаагүй бол байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөр, хураамжийн орлого орон нутгийн төсөвт орно.

34 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах эдийн засгийн хөшүүрэг

1.Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг багасгах дэвшилт арга, хоргүй бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулна.

2.Төрийн захиргааны төв байгууллага нь байгаль орчныг бохирдуулсны болон бусад хортой нөлөөлөл үзүүлсний төлбөрийн зохих хэсэг, тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал, жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны хураамж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж, орлогын бусад эх үүсвэрээс бүрдсэн байгаль хамгаалах сан байгуулж, түүний хөрөнгийг

экологийн боловсрол, хүмүүжил олгох, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх ажлыг дэмжихэд зарцуулна.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах болон байгаль хамгаалах сан байгуулах журмыг Засгийн газар тогтооно.

35 дугаар зүйл. Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөр, хураамж

1.Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөр, хураамжид байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгосны хураамж, нөөц ашигласны төлбөр, зөвшөөрсөн хэмжээнд хог хаягдал, бохирдуулах бодис гаргасны төлбөр хамаарна.

2.Эрхийн бичиг, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан байгалийн баялаг болон зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн хог хаягдал, бусад бодис гаргахад нөхөн төлбөр ногдуулна.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхөн төлбөрийн 90 хувийг байгаль хамгаалах санд, 10 хувийг орон нутгийн төсөвт оруулна.

4.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан төлбөр, хураамжийн дээд, доод хэмжээ, төлөх журмыг хуулиар тогтооно.

36 дугаар зүйл. Экологийн боловсрол, хүмүүжил

1.Засгийн газар албан болон албан бус боловсролын тогтолцооны хүрээнд иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил, байгаль орчныг хамгаалах арга, дадал олгох хөтөлбөрийг батлаж биелэлтийг зохион байгуулна.

2.Экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг дараахь байдлаар зохион байгуулна:

1/сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуульд байгаль орчныг хамгаалах анхны мэдлэг, хүмүүжил олгох;

2/коллеж, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалтын байгууллагад мэргэжлийн чиг баримжааг харгалзан байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах шинжлэх ухааны үндэс, эрх зүйн мэдлэг олгох;

3/хэвлэл, мэдээллийн хэрэгслээр экологийн мэдлэг, байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил, хуулийг тогтоомж сурталчлах.

37 дугаар зүйл. Байгаль орчинд учруулсан
хохирлыг нөхөн төлөх

1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хууль бус үйл ажиллагаагаараа байгаль орчин, түүний баялагт учруулсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас байгаль орчны алдагдсан тэнцлийг болон байгалийн баялгийг нөхөн сэргээх, хүн амыг нүүлгэх, мал, амьтныг гухайн нутаг дэвсгэрээс шилжүүлэхэд гарсан зардлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжилж болно.

3.Гэм буруутай этгээд энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан хохирлыг нөхөн төлсөн нь түүнд зохих хууль тогтоомжийн дагуу эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хууль
тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1.Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд зөрчлийн шинж байдал, хохирлын хэмжээг харгалзан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

2.Шүүгч буюу улсын байцаагч байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг дараахь байдлаар зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурьдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1/энэ хуулийн 31 дүгээр зүйлийн 3,4,5,6-д заасан үүргийг биелүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 өгрөгөөр торгох;

2/байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд төөрөөс төлөвлөн олгосон хөрөнгийг өөр зориулалтаар ашигласан бол тухайн тушаалтныг 10000-20000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 75000-150000 төгрөгөөр торгох;

3/энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 1 дахь хэсэгт заасан шаардлагыг биелүүлээгүй иргэнийг 10000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-200000 өгрөгөөр торгох.

39 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж өрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 3 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

АГААРЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, байгаль орчны тэнцлийг хангах өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхолд нийцүүлэн хийн мандлын агаар (цаашид "агаар" гэх)-ыг хамгаалах, түүнийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Агаарын тухай хууль тогтоомж

Агаарын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

АГААРЫГ ХАМГААЛАХ АЖЛЫН УДИРДЛАГА, ЧАНАРЫН ХЯНАЛТ, МЭДЭЭЛЭЛ

3 дугаар зүйл. Агаарыг хамгаалах ажлын удирдлага

1.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага агаарыг хамгаалах талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1)агаарыг хамгаалах хөтөлбөр боловсруулан Засгийн газраар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2)агаарын чанарын хяналт-шинжилгээний ажлыг зохион байгуулах;

3)агаарыг хамгаалахтай холбогдсон дүрэм, журам батлах, стандартын төсөл боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулах.

2.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага агаарыг хамгаалах талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1)агаар бохирдуулах бодисын хүлцэх агууламж, агаарт үзүүлэх физикийн хортой нөлөөллийн түвшний стандартын төслийг боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулах;

2)агаарын бохирдол, физикийн хортой нөлөөлөл хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдалд хяналт тавих.

3.Иргэн, аж ахуйн нэгж,байгууллагын агаарт гаргаж буй бохирдуулах бодис, физикийн хортой нөлөөллийн байдалд тавих мэргэжлийн хяналтыг тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны улсын байцаагч хэрэгжүүлнэ.

4 дүгээр зүйл. Агаарын чанарын алба

1.Агаарын чанарыг тодорхойлох, хяналт-шинжилгээ хийх, холбогдох мэдээ гаргах үүрэг бүхий агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн алба (цаашид "мэргэжлийн алба" гэх)-ыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулж ажиллуулна.

2.Мэргэжлийн албаны орон нутаг дахь салбар байгуулах асуудлыг тухайн нутаг дэвсгэрийн байгаль, цаг уурын онцлог, үйлдвэржилтийн түвшинтэй уялдуулан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэж тэдгээрийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

3. Мэргэжлийн албаны орон нутаг дахь салбар нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан дүрмийн дагуу Засаг даргын удирдлага дор ажиллана.

5 дугаар зүйл. Агаарын чанарын хяналт-шинжилгээ

1.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь агаарын бохирдол, физикийн хортой нөлөөлөл, гүүнчлэн агаар дахь озон, нүүрс хүчлийн хий зэрэг бага хольцийн агууламжийн өөрчлөлтөд байнгын хяналт тавих зорилго бүхий хяналт-шинжилгээний сүлжээг зохион байгуулна.

2.Хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээ нь дараахь хэсгээс бүрдэнэ:

1)улсын хяналт-шинжилгээний цэг;

2)олон улсын хяналт-шинжилгээний сүлжээний Монгол Улс дахь цэг;

3)агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын хяналтын цэг.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан цэгийг хот, тосгон, бусад суурины хэмжээ, хүн амын нягтрал, газар нутгийн тогтоц, үйлдвэржилтийн түвшин зэргийг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

6 дугаар зүйл. Агаарын чанарын тухай мэдээлэл

1.Мэргэжлийн албаны орон нутаг дахь салбар нь агаарын чанарын тухай мэдээг зохих шатны Засаг дарга болон мэргэжлийн төв албанд өгнө.

2.Мэргэжлийн төв алба нь агаарын чанарын тухай мэдээг нэгтгэн дүгнэж төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгнө.

3.Мэргэжлийн алба нь агаарын бохирдол, физикийн хортой нөлөөллийн түвшин стандарт заасан хэм хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд холбогдох байгууллага, олон нийтэд шуурхай мэдээлнэ.

4.Аж ахуйн нэгж, байгууллага нь агаарын чанарт нөлөөлж буй өөрийн үйл ажиллагааны тухай болон дотоод хяналтын мэдээг мэргэжлийн албаны орон нутгийн салбарт тогтоосон хугацаанд өгнө.

5.Агаарын чанарын мэдээлэл гаргах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

АГААРЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

7 дугаар зүйл. Агаарыг бохирдуулах бодис, физикийн хортой нөлөөллийн хэмжээ

1.Агаар бохирдуулах бодисын хүлцэх агууламж, агаарт үзүүлэх физикийн хортой нөлөөллийн түвшний хэм хэмжээ, түүнчлэн хөдөлгөөнт эх үүсвэрийн төрөл бүрээс агаарт гаргах бохирдуулах бодисын хүлцэх агууламж, физикийн хортой нөлөөллийн түвшний хэм хэмжээ, тэдгээрийг тодорхойлох аргыг стандартаар тогтооно.

2.Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын суурин эх үүсвэр нэг бүрээс агаарт гаргах бохирдуулах бодис, үзүүлэх физикийн хортой нөлөөллийн зөвшөөрөгдөх хэмжээг мэргэжлийн алба тогтооно.

3.Бүх эх үүсвэрээс агаарт гаргах бохирдуулах бодис, үзүүлэх физикийн хортой нөлөөллийн нийлбэр хэмжээ нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэм хэмжээнээс хэтрэхгүй байна.

4.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөвшөөрөх хэмжээг тогтоох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

8 дугаар зүйл. Агаарт бохирдуулах бодис гаргах, физикийн хортой нөлөөлөл үзүүлэх зөвшөөрөл

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхэлж суурин эх үүсвэр ашиглахдаа мэргэжлийн албаар дүгнэлт гаргуулан сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авна.

2.Зөвшөөрөлд тухайн суурин эх үүсвэрээс агаарт гаргах бохирдуулах бодис, үзүүлэх физикийн хортой нөлөөллийн хэмжээг энэ хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан шаардлагыг үндэслэн зааж, агаарыг бохирдуулах бодис, физикийн хортой нөлөөллөөс хамгаалах талаар авах арга хэмжээ, хууль тогтоомжид заасан бусад шаардлагыг тусгана.

3.Стандартаар хүлцэх хэм хэмжээг нь тогтоогоогүй бохирдуулах бодис агаарт гаргах, физикийн хортой нөлөөлөл үзүүлэх зайлшгүй тохиолдолд бодисын шинж чанар, хэмжээ, хүний эрүүл мэнд, байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран олгож болно.

4.Түр зөвшөөрөл авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн зөвшөөрөлд заасан хугацаанд багтаан агаарт гаргах бохирдуулах бодис, үзүүлэх физикийн хортой нөлөөллийн хэм хэмжээний стандартыг эрх бүхий байгууллагаар батлуулна.

9 дүгээр зүйл. Агаарын бохирдол, физикийн хортой нөлөөлөл ноцтой нэмэгдсэн үед авах арга хэмжээ

1.Гэнэтийн аюул, үйлдвэрлэлийн осол болон бусад шалтгаанаар гаар дахь бохирдуулах бодисын агууламж, физикийн хортой нөлөөллийн түвшин ноцтой нэмэгдэж, стандартын хэм хэмжээнээс этэрч хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулахаар олсон бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, эргэжлийн албан энэ тухай аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг арга, хүн амд шуурхай мэдэгдэнэ.

2.Агаарын бохирдол, физикийн хортой нөлөөлөл ноцтой эмэгдсэн шалтгааныг тогтоох, хохирлыг арилгах арга хэмжээг аж

ахуйн нэгж, байгууллагын удирдлага, мэргэжлийн алба, Засаг дарга, холбогдох бусад байгууллага хамтран яаралтай авна.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан агаарын бохирдол, физикийн хортой нөлөөллийг багасгах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагын ажилд тусгай горим тогтоох, тэдгээрийн үйл ажиллагааг түр зогсоох, шаардлагатай тохиолдолд хүн амыг хамгаалах, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг Иргэний хамгаалалтын тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.

10 дугаар зүйл. Агаарт бохирдуулах бодис гаргах, физикийн хортой нөлөөлөл үзүүлэхийг хязгаарлах

1. Аж ахуйн нэгж, байгууллага байгаль цаг уурын нөхцөлөөс шалтгаалан агаарын бохирдол ихэсч болзошгүй тухай мэдээг мэргэжлийн албанаас хүлээн авмагц суурин эх үүсвэрээс агаарт гаргах бохирдуулах бодис, үзүүлэх физикийн хортой нөлөөллөө багасгах талаар энэ хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2. Аж ахуйн нэгж, байгууллагын суурин эх үүсвэрээс агаарт гаргаж байгаа бохирдуулах бодис, үзүүлж байгаа физикийн хортой нөлөөлөл нь тогтоосон хэмжээнээс хэтэрсэн, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулах нөхцөл байдал бий болсон нь тогтоогдсон тохиолдолд байгаль орчны болон эрүүл ахуйн улсын байцаагч уг зөрчлийг арилгах хүртэл тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг хязгаарлаж буюу түр зогсоож болно.

3. Агаарт тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн бохирдуулах бодис гаргаж, физикийн хортой нөлөөлөл үзүүлж байгаа тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт бусад эх үүсвэрийн ашиглалтыг байгаль орчны байцаагч болон цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох байгууллагатай хамтран тогтоосон журмын дагуу хязгаарлаж болно.

4. Агаар бохирдуулах бодис, физикийн хортой нөлөөллийн зөвшөөрсөн хэмжээ, зөвшөөрөлд заасан нөхцөл, шаардлагыг удаа дараа зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрмөсөн зогсоох буюу үйлдвэрлэлийн чиглэлийг нь өөрчлөх саналыг байгаль орчны болон эрүүл ахуйн байцаагч эрх бүхий байгууллагад тавина. Энэхүү саналыг эрх бүхий байгууллага 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

5.Агаарыг хамгаалах зорилгоор амралт, сувилал, жуулчлалын газар, хотын гудамж, орон сууцны хороололд тодорхой төрлийн үйлдвэрээр хориглож буюу хязгаарлаж болно.

6.Суурин газрын агаарыг хортой, халдвартай, эвгүй үнэртэй бодис, хаягдлаар бохирдуулах, хог хаягдлыг ил задгай, зориулалтын бус газарт хаях, шатаахыг хориглоно.

11 дүгээр зүйл. Барилга байгууламж барихад агаарыг хамгаалах талаар тавих шаардлага

1.Үйлдвэрлэл, үйлчилгээний болон бусад зориулалттай барилга байгууламжийн байршлыг сонгох, зураг төсөл зохиох, тэдгээрийг барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, технологи, тоног төхөөрөмжийг нь өөрчлөх, шинэчлэхэд агаар бохирдуулах бодисын хүлцэх агууламж, физикийн хортой нөлөөллийн түвшний стандартыг үндэслэнэ.

2.Агаарт онцгой хортойгоор нөлөөлж болзошгүй үйлдвэр, үйлчилгээний газар барих асуудлыг зохих шатны иргэдийн төлөөлөгчдийн Хурлын санал, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.

3.Агаарт бохирдуулах бодис гаргах, физикийн хортой нөлөөлөл үзүүлэх ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагыг барьж байгуулахад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэнэ.

12 дугаар зүйл. Суурин газар барьж байгуулахад агаарыг хамгаалах талаар тавих шаардлага

1.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь хот, тосгон, бусад суурин газрын байршил, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг агаарын өлөв байдалд гарч болох өөрчлөлт, хортой нөлөөллийг харгалзан боловсруулна.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан төлөвлөгөөг байгаль орчны суудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулан өвшөөрөл авна.

13 дугаар зүйл. Эх үүсвэрийг тоноглох

1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ашиглалтад орсон угацааг харгалзахгүйгээр агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг эх үүсвэр ашиглаж йлдвэрлэл эрхлэхдээ эх үүсвэр нэг бүрээ хянах, агаар охирдуулах бодисыг цэвэрлэх, физикийн хортой нөлөөллийг уруулах тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр тоноглоно.

2.Агаар бохирдуулах бодисыг цэвэрлэх, физикийн хорто нөлөөллийг бууруулах, эх үүсвэр бүрийг хяналтын тонс төхөөрөмж, багаж хэрэгслээр тоноглох, тэдгээрийн ашиглалты байдалд тухайн салбарыг харьяалах төрийн захиргааны т байгууллага, сум, дүүргийн Засаг дарга, байгаль орчны байцаа хяналт тавина.

14 дүгээр зүйл. Хүлэмжийн хийн ялгаралтыг багасгах арга хэмжээ

1.Аж ахуйн нэгж, байгууллага нь үйлдвэрлэл, үйлчилгэ шинээр зохион байгуулах, өргөтгөн шинэчлэхдээ нүүрс хүчлий хий, шивтрийн хий, азотын дутуу исэл зэрэг хүлэмжийн хий ялгаралтын хэмжээ нь олон улсын жишигт нийцсэн, дэвшилт техник, технологийг хэрэглэнэ.

2.Хүлэмжийн хийн ялгаралт тухайн жилд өссөн нь тогтоогдс бол засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон холбогдох а ахуйн нэгж, байгууллагын удирдлага хүлэмжийн хийн ялгаралт багасгах арга хэмжээ авна.

3.Хүлэмжийн хийн хэмжээ ихэссэний улмаас байгаль орчи хортой нөлөөлөх нөхцөл байдал бий болсон бол тухайн аж ахуй нэгж, байгууллагын хүлэмжийн хий ялгаруулах үйл ажиллага байгаль орчны байцаагч зогсоож болно.

15 дугаар зүйл. Озоны давхрагыг хамгаалах

1.Озоны давхаргыг хамгаалах, түүнд үзүүлэх хортой нөлөөлө сэргийлэх зорилгоор озоны давхаргын төлөв байдал, нарны х ягаан туяаны эрчмийн өөрчлөлтөд тавих хяналт-шинжилгэ мэргэжлийн алба болон байгаль орчны асуудал эрхэлсэн төри захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллага гүйцэ гэнэ.

2.Озоны давхаргад хортой нөлөөлөл үзүүлэх бодис жагсаалтыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргаа төв байгууллага батална.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан жагсаалтад орсон бодис импорт, үйлдвэрлэлийн тухай мэдээллийг гаалийн бол үйлдвэрлэл үйлчилгээ явуулж буй иргэн, аж ахуйн нэг байгууллага энэ хуулийн 6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заас журмын дагуу мэргэжлийн төв албанд өгч байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ.

16 дугаар зүйл. Агаар бохирдуулах бодис, физикийн хортой нөлөөлөл, тэдгээрийн эх үүсвэрийн улсын тоо бүртгэл

1.Агаар бохирдуулах бодис, физикийн хортой нөлөөлөл, тэдгээрийн эх үүсвэрийн төрөл, тоо, хэмжээг улсын бүртгэлд хамруулна.

2.Улсын нэгдсэн тоо бүртгэл, хүлэмжийн хийн эх үүсвэр болон шингээгчийн улсын тооллогыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу мэргэжлийн алба гүйцэтгэнэ.

17 дугаар зүйл. Агаарыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахад тавих шаардлага

Аж ахуйн нэгж, байгууллага агаарыг савлах болон бусад аргаар үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах бол байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авна.

18 дугаар зүйл. Агаарын төлөв байдал, цаг уурын үзэгдэлд зориуд нөлөөлөх үзэгдэл

1.Агаарын төлөв байдал, цаг уурын үзэгдэлд зориуд нөлөөлөх шаардлага гарсан тохиолдолд уг ажиллагааг гүйцэтгэх байгууллага байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагад мэргэжлийн албаны дүгнэлтийг үндэслэн зөвшөөрөл олгоно.

2.Зориудын нөлөөлөл нь агаарын төлөв байдал, уур амьсгалд хортой нөлөөлөхгүй байвал зохино.

19 дүгээр зүйл. Төлбөр

1.Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг болон агаарыг савлах, бусад аргаар үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төлбөр төлнө.

2.Төлбөрийн хэмжээ, түүнийг төлөх журмыг хуулиар тогтооно.

2О дугаар зүйл. Агаарын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Шүүгч, байгаль орчны буюу эрүүл ахуйн байцаагч агаарын тухай хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал дор дурдсан захиргааны

шийтгэл ногдуулна:

1)агаарын чанарт нөлөөлж буй өөрийн үйл ажиллагааны тухай болон озоны давхаргын төлөө байдалд хортой нөлөөлөх бодисын импорт, үйлдвэрлэл, агаарын чанарын тухай мэдээг тогтоосон хугацаанд мэдээлээгүй буюу зориуд буруу мэдээлсэн, мөн суурин газар энэ хуулийн 10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт хориглосон үйл ажиллагаа явуулсан иргэнийг 1000-5000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-75000 төгрөгөөр торгох;

2)зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэн бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт бусад эх үүсвэр ашиглан агаар бохирдуулж байгаа иргэнийг 500-5000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;

3)агаарыг хамгаалах шаардлага хангаагүй аж ахуйн нэгж, байгууллагыг ашиглалтанд оруулсан, тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлсэн албан тушаалтныг 10000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 75000-150000 төгрөгөөр торгох;

4)агаарт бохирдуулах бодис гаргах, физикийн хортой нөлөөлөл үзүүлэх талаар зөвшөөрөлд заасан хэмжээ, нөхцөл, шаардлагыг зөрчсөн, эсхүл агаарт гаргах бохирдуулах бодис, физикийн хортой нөлөөллийг багасгах, цэвэрлэх, хянах төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах журам зөрчсөн иргэнийг 15000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 75000-200000 төгрөгөөр торгох;

5)эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг суурин эх үүсвэр ашиглан агаар бохирдуулсан, эсхүл агаарыг зөвшөөрөлгүйгээр савлаж үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан бол хууль бусаар олсон орлогыг хурааж зөрчил гаргасан иргэнийг 25000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-200000 төгрөгөөр торгох.

21 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хууль 1995 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 3 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

ОЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Ойн тухай хууль тогтоомж

Ойн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Ойг өмчлөх, ашиглах

1.Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу ойн нөөц төрийн өмч мөн.

2.Төр нь ойн нөөцийг аймаг, нийслэл, сумын эзэмшилд олгож, тэдгээрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ой, түүний дагалт баялгийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой хугацаа, төлбөр, болзолтойгоор гэрээ, эрхийн бичгийн үндсэн дээр ашиглуулж болно.

3.Хууль тогтоомж болон гэрээ, эрхийн бичгийн дагуу зохих төлбөр төлсний дараа бэлтгэсэн мод, ойн дагалт баялаг, түүнчлэн гэрээний дагуу эзэмшиж, ашиглаж байгаа газартаа өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан ой, мод нь тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмч болно.

4 дүгээр зүйл. Ойн сан, түүний ангилал, ойн сан бүхий газар

1.Ойн сан нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ургадаг бүх төрлийн мод, заг, сөөг, таримал ойгоос бүрдэнэ.

2.Ойн санг экологи-эдийн засгийн ач холбогдлоор нь дараахь байдлаар ангилна:

1/онцгой бүсийн ой;

2/хамгаалалтын бүсийн ой;

3/ашиглалтын бүсийн ой.

3.Ой бүхий газар, ойн цоорхой, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавьж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, ойн захаас гадагш 100 метр хүртэлх газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын эзлэх талбай нь ойн сан бүхий газарт хамаарна.

5 дугаар зүйл. Ойн мэдээллийн сан

1.Ойн мэдээллийн санд ойн төлөв байдал, ойн талбайн хэмжээ, нөөц, бүрэлдэхүүн, чанар, үнэлгээ, ойг гэрээний дагуу ашиглагчдад хувиарласан байдал, ойг хамгаалах ашиглах, нөхөн сэргээх, ойжуулах арга хэмжээний үзүүлэлтийг сум, аймаг, нийслэл, улсын хэмжээгээр тусгана.

2.Мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ батална.

3.Ойн мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

6 дугаар зүйл. Ой зохион байгуулалт, түүний санхүүжилт

1.Ойн талбай, нөөц, тархац бүрэлдэхүүний хэмжээ, чанар, төлөв байдал, өөрчлөлтийг судлан тогтоож, ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх үндэслэлийг тодорхойлох ажлыг ой зохион байгуулалт гэнэ.

2.Ой зохион байгуулалтыг төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

3.Ойн сангийн нөөцийг шинэчлэн тогтоох ой зохион байгуулалтыг 10 жил тутам давтан хийнэ.

4.Ой зохион байгуулалтыг дараахь байдлаар санхүүжүүлнэ:

1/ойн сангийн нөөцийг тогтоох, бүс нутгийн хөгжлийн төлөвийг тодорхойлохтой холбогдсон болон онцгой, хамгаалалтын бүсийн ойд хийх ой зохион байгуулалтыг улсын төвлөрсөн төсвөөс;

2/хамгаалалтын бүс тогтоох болон ашиглалтын бүсийн ойд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр хийх ой зохион байгуулалтыг орон нутгийн төсвөөс;

3/иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гэрээний дагуу ашиглаж байгаа ойдоо хийх ой зохион байгуулалтыг өөрийн хөрөнгөөр

5.Ой зохион байгуулалт хийх журмыг Засгийн газар тогтооно.

7 дугаар зүйл. Ойн нөөц ашигласны төлбөр

1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ойн мод, ойн дагалт баялаг ашиглахад нөөц ашигласны төлбөр төлнө.

2.Ойн нөөц ашигласны төлбөрийн дээд, доод хэмжээ, төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх, түүнээс чөлөөлөх журмыг хуулиар тогтооно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ОНЦГОЙ БҮСИЙН ОЙ, ТҮҮНИЙ ХАМГААЛАЛТЫН ДЭГЛЭМ

8 дугаар зүйл. Онцгой бүсийн ой

1.Онцгой бүсийн ойд цармын бүслүүрийн ой, дархан цаазтай газрын онгон бүс, хамгаалалтын бүс, байгалийн цогцолборт газрын онцгой бүсийн ой хамаарна.

2.Усны хагалбар дахь байгаль орчны тэнцлийг хангах, хөрсний эвдрэлээс сэргийлэх зорилгоор цармын бүслүүрийн ойн заагийг төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

9 дүгээр зүйл. Онцгой бүсийн ойн хамгаалалтын дэглэм

1.Онцгой бүсийн ойд зөвхөн түүний унаган төрх, байгаль орчны тэнцлийг хангах, ойг гал түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.Онцгой бүсийн цармын бүслүүрийн ойд унанги, гишүү бэлтгэх, төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жагсаалтын дагуу тодорхой төрлийн ойн дагалт баялаг ашиглахаас бусад төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

3.Дархан цаазтай газрын онгон бүс, хамгаалалтын бүс, байгалийн цогцолборт газрын онцгой бүсийн ойн хамгаалалтын дэглэмийг Тусгай хамгаалалтай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХАМГААЛАЛТЫН БҮСИЙН ОЙ, ТҮҮНИЙ ХАМГААЛАЛТ, АШИГЛАЛТЫН ДЭГЛЭМ

10 дугаар зүйл. Хамгаалалтын бүсийн ой

Хамгаалалтын бүсийн ойд энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тусгай хамгаалалттай газрын ой, ногоон бүс, хориотой зурвасын ой, заган ой, баян бүрд, 100 га хүртэлх хэмжээ-

ний төгөл мод, зураа, сөөг, ширэнгэ, уулын өвөр энгэрийн төгөл ой, 30 хэмээс дээш налуу газрын ой хамаарна.

11 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газрын ой

Энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан тусгай хамгаалалттай газрын ойн хамгаалалтын дэглэмийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.

12 дугаар зүйл. Ногоон бүсийн ой

1.Байгаль орчны тэнцэл, хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг хангах зорилгоор хот, тосгоны эргэн тойрны ойд ногоон бүс тогтооно.

2.Нийслэлийн эргэн тойрны ногоон бүсэд хамаарах ойн заагийг Засгийн газар тогтооно.

3.Нийслэлээс бусад хот, тосгоны эргэн тойрны 30 хүртэл километрийн доторх ногоон бүсэд хамаарах ойн заагийг төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

13 дугаар зүйл. Хориотой зурвасын ой

Хөрсний эвдрэлээс сэргийлэх, гадаргын болон газар доорх усны горимыг зохицуулахад ач холбогдол бүхий дараахь ой хориотой зурвасын ойд хамаарна:

1/гол, горхины эх болон нуурын эргэн тойрны 5 километрийн доторх ой;

2/голын урсгалын дагуу эргээс хоёр тийш болон рашаан, булаг, шандын ундаргын эргэн тойрны 3 километрийн доторх ой;

3/улсын чанартай авто болон төмөр замын дагуу хоёр тийш 1 километрийн доторх ой,

14 дүгээр зүйл. Хамгаалалтын бүсийн ой

Энэ хуулийн 11, 12, 13 дугаар зүйлд зааснаас бусад хамгаалалтын бүсийн ойн заагийг төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

15 дугаар зүйл. Хамгаалалтын бүсийн ойн дэглэм

1.Хамгаалалтын бүсийн ойд түүнийг хамгаалах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг сайжруулах зорилгоор арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.Хамгаалалтын бүсийн ойд энэ хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу ахуйн зориулалтаар түлээ бэлтгэх, 29 дүгээр зүйлд заасны дагуу ойн дагалт баялгийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

АШИГЛАЛТЫН БҮСИЙН ОЙ, ТҮҮНИЙ АШИГЛАЛТЫН ДЭГЛЭМ

16 дугаар зүйл. Ашиглалтын бүсийн ой

Энэ хуулийн 8,10 дугаар зүйлд зааснаас бусад ой ашиглалтын бүсийн ойд хамаарна.

17 дугаар зүйл. Ашиглалтын бүсийн ойн дэглэм

1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хууль тогтоомж, гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу зохих төлбөр, хугацаатайгаар үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглалтын бүсийн ойд хэрэглээний мод, түлээ бэлтгэн ашиглаж болно.

2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь зохих эрхийн бичгийн дагуу ахуйн зориулалтаар ашиглалтын бүсийн ойд хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ойн дагалт баялгийг ашиглаж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

ОЙГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ

18 дугаар зүйл. Ойг хамгаалах арга хэмжээ

1.Ойг хамгаалах арга хэмжээнд ойг гал түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг хангах, удмын санг хамгаалах ажил багтана.

2.Аймаг, нийслэл, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өөрийн нутаг дэвсгэр дэх ойн мод, ойн дагалт баялгийн ашиглалтыг 3 хүртэл жилийн хугацаагаар хориглож болно.

19 дүгээр зүйл. Ойг гал түймрээс хамгаалах

1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ойн гал түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх талаар хөтөлбөр боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр орон нутгийн төсөвт тусгана.

2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ойг гэрээний дагуу ашиглахдаа түүнийг гал түймрээс хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.

3. Ойд гал түймэр гарсан шалтгаан, учирсан хохирол, гал түйм-

рийг унтраахад гарсан зардлын хэмжээг тодорхойлох ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр томилсон ажлын хэсэг гүйцэтгэнэ.

4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ойн гал түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэхэд дараахь шаардлагыг биелүүлнэ:

1/гал түймрийн аюултай үе болох жил бүрийн 3 дугаар сарын 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдөр, 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд ил задгай гал түлэх гүй байх, зайлшгүй тохиолдлоор түлсэн гал, асаасан шүдэнз, татсан тамхины гал, цог, нурмыг бүрэн унтраах;

2/ гал түймрийн аюултай үед ойд мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах, аялал, зугаалгаар явах, бусад ажлыг гүйцэтгэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагчид мэдэгдэж гал түймэр гаргахгүй байх талаар зохих арга хэмжээ авах тухай баталгаа өгөх;

3/ ойд ажиллах, дамжин өнгөрөх бүх төрлийн тээврийн болон өөрөө явагч бусад хэрэгслийн тэжээлийн систем, утааны янданг гал түймрийн аюулгүй байдлыг хангах шаардлагын дагуу тоноглох;

4/ тэсрэх, галын аюултай бодис, тослох материалыг хэрэглэх, хадгалах журам, горимыг мөрдөх;

5/ ойн гал түймрийг илрүүлсэн, гал түймрийн тухай мэдээ хүлээн авсан бол өөрийн хүч хэрэгслийг зохион байгуулан гаргаж, гал түймэр унтраах арга хэмжээ авч сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, бусад холбогдох байгууллагад яаралтай мэдээлэх.

5. Бүх шатны Засаг дарга өөрийн бүрэн эрхийн хүрээнд хүн хүч, техник хэрэгслийг дайчлан гал түймэр унтраах ажлыг шуурхай зохион байгуулах бөгөөд түүнтэй холбогдсон Засаг даргын шаардлагыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага биелүүлэх үүрэгтэй.

6. Ойг гал түймрээс хамгаалах дүрмийг Засгийн газар батална.

20 дугаар зүйл. Ойг хөнөөлт шавьж, өвчнөөс хамгаалах

1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ойг хөнөөлт шавьж, өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх хөтөлбөр боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр орон нутгийн төсөвт тусгана.

2. Хөнөөлт шавьж, өвчний тархалтын голомт нэгээс дээш аймгийн хэд хэдэн сумын нутаг дэвсгэрийг хамарсан тохиолдолд түүнтэй тэмцэх ажлыг мэргэжлийн байгууллага улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэнэ.

3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гэрээний дагуу ашигла

байгаа ойг хөнөөлт шавьж, өвчнөөс хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.

4.Хөнөөлт шавьж, өвчний судалгаа явуулах, тэдгээрээс сэргийлэх, тэмцэх ажлыг мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

5.Ойд хөнөөлт шавьжтай тэмцэхэд төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрснөөс бусад химийн бодис ашиглахыг хориглоно.

21 дүгээр зүйл. Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх

1.Ойн өсөлтийг сайжруулах, гал түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс сэргийлэх зорилгоор ойд хийх арчилгаа, цэвэрлэгээг ойн мэргэжлийн байгууллага орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэнэ.

2.Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх журмыг төрийн захиргааны төв байгууллага батлана.

22 дугаар зүйл. Ойд хориглох үйл ажиллагаа

1.Ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг хангах, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс ойг хамгаалах зорилгоор дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1/насны 5 дугаар ангиа хүртэлх ой, бүх төрлийн өсвөр мод, түүнчлэн жодоо, яшил, тоорой, жигд, яргай, сухай, гандигар, тас болон нацаргана зэрэг бүх төрлийн жимсний мод, бутыг огтлох, хугалж гэмтээх;

2/төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр хуш, нацуур, хайлаасыг бэлтгэн ашиглах;

3/ойд нэлэнхүйд нь огтлох аргаар мод бэлтгэх;

4/ойн сан бүхий газарт зөвшөөрөлгүйгээр өвс хадах;

5/тарьц суулгац ургуулсан талбайд мод бэлтгэх, мал бэлчээх.

23 дугаар зүйл. Ойг нөхөн сэргээх

1.Ойн нөөцийг арвижуулах, ойн удмын санг хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх зорилгоор гал түймэр, хөнөөлт шавьж, өвчинд нэрвэгдсэн болон мод бэлтгэсэн талбайд мод тарьж ургуулах, нөхөн сэргээх ажлыг улсын захиалга, төслийн дагуу улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, сан, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын санаачлага, хөрөнгөөр гүйцэтгэнэ.

2.Үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглээний мод бэлтгэж ашигласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр мод бэлтгэсэн талбайгаа ойжуулж ойн мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан 2-оос доошгүй настай таримал ойг сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгнө. Огтолсон нэг модны оронд 3-5 суулгац тарьсан байвал зохино.

3.Төрийн захиргааны төв байгууллага ойн сангийн ойгүй талбай, тал хээр, говийн бүс болон гол, горхи, булаг, шандын эхийг ойжуулах, бэлчээр, тариалангийн талбайг хөрсний элэгдэл, эвдрэлээс хамгаалах ойн зурвас байгуулах зорилгоор ойг тарьж ургуулах хөтөлбөр, төсөл боловсруулж, түүнийг улсын төвлөрсөн төсөв, бусад эх үүсвэрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.

4.Ойг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээ нь тухайн жилд мод бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын 70 хувиас багагүй байна.

24 дүгээр зүйл. Мод тарьж ургуулах ажлыг зохион байгуулах

1.Аймаг, нийслэлийн Засаг дарга өөрийн нутаг дэвсгэрт тухайн жилд бүх нийтээр мод тарих өдрийг тогтоож ойжуулах ажлыг зохион байгуулна.

2.Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга ойн мэргэжлийн байгууллагатай хамтран мод суулгах талбайг сонгох, хөрс боловсруулах, тарьц суулгацаар хангах, тэдгээрийг услах, арчлах ажлыг зохион байгуулж, энэ ажилд иргэдийг татан оролцуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ОЙГ АШИГЛАХ

25 дугаар зүйл. Бэлтгэж ашиглах модны хэмжээ тогтоох

1.Төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд ашиглалтын бүсийн ойгоос бэлтгэж болох модны дээд хэмжээг аймаг, нийслэлээр тогтооно.

2.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэмжээнд багтаан нутаг дэвсгэртээ бэлтгэх модны хэмжээг тогтооно.

3.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон тухайн сумд бэлтгэж болох модны дээд хэмжээнд багтаан өөрийн нутаг дэвсгэрт бэлтгэх модны хэмжээг тогтооно.

26 дугаар зүйл. Мод бэлтгэх гэрээ байгуулах

1.Үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглээний мод, түлээ бэлтгэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хүсэлтээ сумын буюу нийслэлийн Засаг даргад гаргана.

2.Сумын буюу нийслэлийн Засаг дарга хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны эдийн засгийн үр ашиг, мод бэлтгэх, боловсруулах техник, технологийн болон мод ашиглалтын түвшин, ой хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах хөрөнгийн хэмжээ, ойн мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг харгалзан тухайн нутаг дэвсгэрийн нэгжид бэлтгэх модны хэмжээнд багтаан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мод, түлээ бэлтгүүлэх тухай шийдвэр гаргана.

3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэрийг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн ойн мэргэжлийн байгууллагатай мод бэлтгэх тухай гэрээ байгуулна.

4.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мод бэлтгэх гэрээнд дараахь зүйлийг тусгана:

1/мод бэлтгэх үндэслэл/зохих шийдвэр/;

2/мод бэлтгэх зориулалт, модны төрөл, хэмжээ, хугацаа;

3/ой зохион байгуулалтын тухай, мод бэлтгэлийн талбай тусгаарласан тухай болон ойн нөөцийн тодорхойлолт;

4/мод бэлтгэх арга ажиллагааны бүдүүвч зураг, төсөл, түүнийг хэрэгжүүлэх хугацаа;

5/мод бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээ, төлөх хугацаа;

6/ойг гал түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс хамгаалах, нөхөн сэргээх төлбөр, түүнийг хэрэгжүүлэх зардлын хэмжээ;

7/мод бэлтгэсэн талбайг хүлээлгэн өгөх нөхцөл;

8/гэрээ байгуулагч талуудын эрх, үүрэг, хариуцлага.

5.Мод бэлтгэх гэрээний биелэлтийг талууд жил бүр дүгнэнэ.

6.Гэрээгээр ашиглаж байгаа ой бүхий газрыг улсын болон орон нутгийн хамгаалалтад авсан, эсхүл энэ хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу ойн ашиглалтыг хориглосон бол ой ашиглагчид анхдагч гэрээнд заасан хэмжээний модыг бэлтгэх өөр газрыг тогтоож өгнө.

27 дугаар зүйл. Мод бэлтгэх эрхийн бичиг олгох

1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ахуйн зориулалтаар хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичгийг баг, хорооны Засаг дарга, түлээ бэлтгэх эрхийн бичгийг тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч тус тус олгоно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэглээний мод, түлээ бэлтгэх эрхийн бичигт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, бэлтгэх модны төрөл, хэмжээ, бэлтгэх, тээвэрлэх хугацаа, газрын нэрийг заана.

3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мод бэлтгэх эрхийн бичгийг бусдад шилжүүлэн ашиглуулахыг хориглоно.

28 дугаар зүйл. Ой ашиглагчийн үүрэг

Ой ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

1/ойн тухай хууль тогтоомжийг биелүүлэх;

2/гэрээ, эрхийн бичигт заасан нөхцөл, болзлын дагуу ойн мод, ойн дагалт баялгийг ашиглах;

3/ойн нөөц ашигласны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх;

4/гэрээ, эрхийн бичигт заасан хугацаанд модоо бэлтгэж тээвэрлэх;

5/мод бэлтгэсэн талбайг тогтоосон журмын дагуу цэвэрлэж мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөх;

6/модыг огтолж бэлтгэхдээ түүний бүдүүний гуравны нэгийг хэмжээнээс өндөргүй хожуул үлдээх.

29 дүгээр зүйл. Ойн дагалт баялаг ашиглах

1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ойн дагалт баялаг ашиглахдаа тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагчаас эрхийн бичиг авна.

2.Ойн дагалт баялаг ашиглах эрхийн бичигт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, түүж бэлтгэх дагалт баялгийн төрөл, хэмжээ, бэлтгэх хугацаа, газрын нэрийг заана.

3.Иргэн оршин суугаа сумын нутаг дэвсгэрт төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэмжээнд багтаан ойн дагалт баялгийг ахуйн хэрэгцээндээ төлбөргүйгээр ашиглаж болно.

30 дугаар зүйл. Өөр аймаг, сумын нутагт мод бэлтгэх

1.Ойгүй буюу ойн нөөц багатай аймаг, сумын болон нийслэлийн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын модны хэрэгцээг хангах зорилгоор ойн нөөцтэй аймаг, сумын нутагт мод бэлтгэх асуудлыг зохих шатны Засаг дарга нар урьдчилан тохиролцож, холбогдох аж ахуйн нэгж, байгууллага мод бэлтгэх гэрээг энэ хуулийн 26 дугаар зүйлийн дагуу байгуулна.

2.Аймаг, нийслэлийн Засаг дарга нар тохиролцоонд хүрч чадаагүй, эсхүл улсын чухал хэрэгцээг хангах шаардлагын дагуу мод бэлтгэх асуудлыг төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

31 дүгээр зүйл. Ойн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1.Шүүгч, байгаль орчны байцаагч буюу байгаль хамгаалагч ойн тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1/мод бэлтгэсэн талбайгаа цэвэрлээгүй, эсхүл мод огтлох, ойн дагалт баялаг ашиглахдаа технологийн горимыг зөрчсөн иргэнийг 500-5000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000 төгрөгөөр торгох;

2/гэрээний дагуу ашиглаж байгаа ойдоо гал түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс хамгаалах арга хэмжээ аваагүй болаж ахуйн нэгж, байгууллагыг 50000 төгрөгөөр торгох;

3/энэ хуулийн 19 дүгээр зүйлийн 4,5 дахь хэсэгт заасан гал түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх шаардлагыг биелүүлээгүй, эсхүл 22 дугаар зүйлд заасан ойд явуулахыг хориглосон үйл ажиллагааг явуулсан иргэнийг 1000-10000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-75000 төгрөгөөр торгох;

4/зохих эрхийн бичиггүйгээр хэрэглээний мод, түлээ бэлтгэсэн, ойн дагалт баялаг ашигласан, эсхүл эрхийн бичигт заасан нөхцөл, болзлыг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар бэлтгэсэн зүйл, олсон орлогыг хурааж зөрчил гаргасан иргэнийг 3000-10000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-75000 төгрөгөөр торгох;

5/зохих гэрээ байгуулахгүйгээр ойд үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглээний мод, түлээ бэлтгэсэн, эсхүл гэрээний нөхцөл, болзлыг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар бэлтгэсэн зүйл, олсон орлогыг хурааж зөрчил гаргасан иргэнийг 5000-20000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-150000 төгрөгөөр торгох;

6/энэ хуулийн 12, 13, 14 дүгээр зүйлд заасан ойд хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар бэлтгэсэн зүйл, олсон орлогыг хурааж зөрчил гаргасан иргэнийг 5000-20000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-200000 төгрөгөөр торгох;

7/онцгой бүсийн цармын бүслүүрийн ойд хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар бэлтгэсэн зүйл, олсон орлогыг

хурааж зөрчил гаргасан иргэнийг 10000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгох.

2.Ойн тухай хууль тогтоомж зөрчиж модыг хууль бусаар огтолсон, гэмтээсний улмаас их хэмжээний хохирол учруулсан бол гэм буруутай этгээдэд зохих хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

32 дугаар зүйл. Ойн санд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх

1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас ойн санд учруулсан гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

2.Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо мод бэлтгэж ашигласны төлбөрийг үндэс болгон түүнийг 5 нугалж, ойн дагалт баялгийн нөхөн төлбөрийг түүний мөнгөн үнэлгээгээр тогтооно.

33 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

АН АГНУУРЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь ан агнуурын ач холбогдол бүхий хөхтөн амьтан, шувуу, загас /цаашид "ан амьтан" гэх/-ыг хамгаалах, зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Ан агнуурын тухай хууль тогтоомж

1.Ан агнуурын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгалах тухай хууль, энэ хууль болон

тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.Агнуурын ач хөлбогдол бүхий ан амьтнаас бусад амьтныг хамгаалах, зохистой ашиглах харилцааг тусгай хуулиар зохицуулна.

3 дугаар зүйл. Ан амьтны сан, түүний ангилал

1.Ан амьтны сан нь Монгол Улсын нутаг дэвсгэрт түр буюу байнга нутагшиж байршдаг ан амьтнаас бүрдэнэ.

2.Ан амьтныг нөөц, нөхөн сэргэх чадвар, экологийн ач холбогдлоор нь дараахь байдлаар ангилна:

1/нэн ховор;

2/ховор;

3/элбэг.

4 дүгээр зүйл. Нэн ховор ан амьтан

1.Нэн ховор ан амьтанд байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар мөхөс, тархац хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон ан амьтан хамаарна.

2.Нэн ховор ан амьтанд тахь, хавтгай, мазаалай, хар мөрний хандгай, цаа буга, хүдэр, минж, халиу, ирвэс, цөөвөр чоно, бөхөн, жороо тоодог, гургуул, гангар хун, цэн тогоруу, хар тогоруу, цагаан тогоруу, хилэм загас хамаарна.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан ан амьтныг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ -ын зөвшөөрлөөр зөвхөн судалгаа, шинжилгээний зориулалтаар агнаж, барьж болох бөгөөд бусад зориулалтаар агнах, барих, тэдгээрийн нарьс, үс, бусад түүхий эдийг худалдахыг хориглоно.

5 дугаар зүйл. Ховор ан амьтан

1.Ховор ан амьтанд нөхөн сэргэх чадвар, тархац хязгаарлагдмал, нөөц багатай, устах аюулд орж болзошгүй ан амьтан хамаарна.

2.Ховор ан амьтныг зөвхөн тусгай зориулалтаар агнаж, барьж болох бөгөөд бусад зориулалтаар агнах, барихыг хориглоно.

3.Ховор ан амьтны жагсаалтыг Засгийн газар батална.

6 дугаар зүйл. Элбэг ан амьтан

1.Элбэг ан амьтанд нөхөн сэргэх чадвар сайтай, нөөц ихтэй, түгээмэл тархацтай ан амьтан хамаарна.

2.Элбэг ан амьтныг үйлдвэрлэлийн, ахуйн болон тусгай зориулалтаар агнаж, барьж болно.

7 дугаар зүйл. Ан амьтны байршил нутаг

1. Ан амьтны байршил нутагт ан амьтан амьдрах нөхцөл бүрдсэн газар, ой, ус хамаарна.

2. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ан амьтны байршил нутагт үйлдвэрлэлийн, ахуйн болон тусгай зориулалтаар ан амьтан агнах, барих бүс тогтоож болно.

3.Ан амьтны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, ангийн гаралтай түүхий эд бэлтгэх зорилгоор ан амьтны байршил нутгийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж, ашиглуулж болно.

8 дугаар зүйл. Ан амьтныг өмчлөх

1.Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу ан амьтан нь төрийн өмч мөн.

2.Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол төлбөрийг бүрэн төлж ан агнах, барих эрхийн бичиг, гэрээ, тусгай зөвшөөрөлд заасан тоо хэмжээнд багтаан бэлтгэсэн ангийн түүхий эд нь бэлтгэгч этгээдийн өмч болно.

3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төрөөс худалдан авч зориудаар гаршуулан үржүүлсэн ан амьтан тэдгээрийн өмчид байна.

9 дүгээр зүйл. Ан амьтныг тэжээвэр болгох

1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, ан амьтны гаралтай эмийн болон бусад түүхий эдийн зүйл бэлтгэх зорилгоор ан амьтныг тэжээвэр болгон эзэмшилдээ байлгаж үйлдвэрлэл эрхэлж болно.

2.Ан амьтныг тэжээж үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлийг энэ хуульд заасан тухайн ан амьтныг агнах, барих зөвшөөрлийг олгох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олгоно.

10 дугаар зүйл. Ан амьтны мэдээллийн сан

1.Ан амьтны тархац, тоо толгой, нөөц, сүргийн бүтэц, нөхөн үржил, жилийн цэвэр өсөлтийн хэмжээ, жилд агнасан амьтны нэр төрөл, тоо хэмжээ болон экологи, эдийн засгийн ач холбогдлыг тусгасан тайлан, мэдээ, баримтаас ан амьтны мэдээллийн сан бүрдэнэ.

2.Ан амьтны мэдээллийн санг сум, аймаг, нийслэлээр гаргаж ан амьтны тархац, тоо толгойн нягтшил, байршлыг харуулсан зургийг хавсаргасан байна.

3.Ан амьтны мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

11 дүгээр зүйл. Агнуур зохион байгуулалт, түүний санхүүжилт

1.Ан амьтны тархац, байршил, тоо толгой, сүргийн бүтэц, нөхөн үржил, агнуурын нөөцийг судлан тогтоож, түүний үндсэн дээр тухайн газар нутгийн ан амьтны нөөцийг зохистой ашиглах,

хамгаалах, өсгөн үржүүлэх үндэслэл боловсруулах ажлыг агнуур зохион байгуулалт гэнэ.

2.Агнуур зохион байгуулалтын тайлан, дүгнэлт нь амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаарх төрийн бодлогын үндэс болно.

3.Агнуур зохион байгуулалтыг төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

4.Агнуур зохион байгуулалтыг дараахь байдлаар санхүүжүүлнэ:

1/нэн ховор ан амьтны нөөц, тархацыг тогтоох ажлын зардлыг улсын төвлөрсөн төсвөөс;

2/сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэр дэх энэ хэсгийн -д зааснаас бусад ан амьтны нөөц, тархацыг тогтоох ажлын зардлыг орон нутгийн төсвөөс;

3/иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гэрээгээр эзэмшиж, ашиглаж байгаа газартаа болон үйлдвэрлэлийн зориулалтаар ангийн үүхий эд бэлтгэх зорилгоор хийлгэх агнуур зохион байгуулалтын ажлын зардлыг өөрийн хөрөнгөөр.

5.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нутаг дэвсгэртээ агнуур зохион байгуулалтыг 4 жил тутамд нэгээс доошгүй удаа хийлгэнэ.

12 дугаар зүйл. Ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээ, түүний санхүүжилт

1.Ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээнд ан амьтан, тэдгээрийн үр төл, удмын санг хамгаалах, амьдрах орчны нөхөл, хэвийн өсөлт, үржилтийг хангах, нутагшуулах, байгалийн цаг уурын бэрхшээл, гамшигт нэрвэгдсэн ан амьтныг тэжээж арчлах, үүлгэн шилжүүлэх, тоолж бүртгэх, судлан шинжлэхтэй холбогдсон үйл ажиллагаа хамаарна.

2.Ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга зохион байгуулж мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

3.Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэхтэй холбогдсон арга хэмжээг орон нутгийн төсөв, аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөр санхүүжүүлнэ.

13 дугаар зүйл. Ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах ажиллагааны удирдлага, хяналт

1.Ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах

ажиллагааны удирдлага, хяналтыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

2.Засгийн газар зарим ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг гадаад улсад гаргахыг хязгаарлаж болно.

3.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нутаг дэвсгэртээ бүхэлд нь буюу тодорхой газарт зарим ан амьтны агналтыг 3 хүртэл жилийн хугацаагаар хориглож болно.

14 дүгээр зүйл. Ан амьтныг агнах, барих, ашиглах төлбөр

1.Ан амьтныг агнах, барих, ашиглахад төлбөр төлнө.

2.Ан амьтныг агнах, барих, ашиглах төлбөрийн хэмжээ, түүнийг төлөх, төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийн орлогыг зарцуулах журмыг хуулиар тогтооно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

АН АМЬТАН АГНАХ, БАРИХ

15 дугаар зүйл. Ан амьтан агнах, барих эрх, зориулалт

1.Ан амьтан агнах, барих арга барил, дадлага эзэмшсэн, холбогдох хууль тогтоомжийг судалсан, ангийн буу эзэмших болон ан амьтан агнах эрхийн үнэмлэхтэй, зохих журмын дагуу зөвшөөрөл авсан иргэн ан амьтан агнах, барих эрхтэй.

2.Иргэнд ан амьтан агнах эрхийн үнэмлэхийг зохих журмын дагуу сум, дүүргийн Засаг дарга олгоно.

3.Ан амьтныг дараахь зориулалтаар агнаж, барина:

1/үйлдвэрлэлийн;

2/ахуйн;

3/тусгай.

16 дугаар зүйл. Ан амьтан агнах, барих зөвшөөрөл

1.Иргэн ахуйн зориулалтаар ан амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тусгай зориулалтаар ан амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл тус тус авч, үйлдвэрлэлийн зориулалтаар ан агнах, барихад гэрээ байгуулна.

2.Ан амьтан агнах, барих гэрээ, эрхийн бичиг, тусгай зөвшөөрлийн загварыг төрийн захиргааны төв байгууллага батална.

17 дугаар зүйл. Агнах, барих ан амьтны тоо хэмжээг тогтоох

1.Төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд үйлдвэрлэ-

ийн болон ахуйн зориулалтаар агнаж, барьж болох ан амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг ан амьтны нөөц, хэрэгцээг харгалзан аймаг, нийслэлээр тогтооно.

2.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан дээд хязгаарт багтаан өөрийн нутаг дэвсгэрт агнах, барих ан амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг сумдаар тогтооно.

3.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн суманд агнаж, барьж болох ан амьтны тоо хэмжээний дээд хязгаарт багтаан өөрийн нутаг дэвсгэрт тухайн жилд агнах, барих ан амьтны тоо хэмжээг тогтооно.

4.Тухайн жилд тусгай зориулалтаар агнах, барих ан амьтны нэр, тоог төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн багасгийн газар тогтооно.

18 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн зориулалтаар ан агнах, барих

1.Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх бүхий этгэн, агнуурын ажил эрхэлдэг аж ахуйн нэгж нь ангийн арьс, үс, ах, бусад түүхий эд бэлтгэх зэрэг үйлдвэрлэлийн зориулалтаар олбэг ан амьтныг агнах, барихдаа сумын Засаг даргын шийдвэрийг ндэслэн ангийн мэргэжлийн байгууллагатай ан амьтныг агнах, арих гэрээ байгуулна.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдвэрлэлийн зориулалтаар н амьтан агнах, барих гэрээнд агнах, барих ан амьтны нэр, тоо эмжээ, агнах хугацаа, газар, бэлтгэх түүхий эдийн нэр төрөл, тоо эмжээг тусгана.

19 дүгээр зүйл. Ахуйн зориулалтаар ан амьтан агнах, барих

1.Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх бүхий этгэн өөрийн ам бүлийн хүнсний болон бусад хэрэгцээнд зохих элбэр төлж сум, дүүргийн буюу баг, хорооны Засаг даргаас авсан рхийн бичгийн дагуу элбэг ан амьтныг агнаж, барьж болно.

2.Ахуйн зориулалтаар ан амьтан агнах, барих эрхийн бичигт гнах, барих ан амьтны нэр, тоо, агнах, барих хугацаа, газрыг заана.

3.Хот, тосгоны оршин суугч иргэнд олгох ахуйн зориулалтаар увуу агнах, загас барих нэг удаагийн эрхийн бичгийн хугацаа 2 үртэл хоног, бусад ан амьтан агнах хугацаа 7 хүртэл хоног байна.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан иргэнд нэг удаагийн эрхийн ичгээр агнах, барихыг зөвшөөрөх ан амьтны тоо хэмжээ нь туу-

райтан амьтан 1, тарвага 3, бусад үслэг амьтан 1, хөтүү, ятуу ногтруу тус бүр 10, бусад шувуу 5, тул загас 2, бусад загас 10 ширхэгээс илүүгүй байна.

20 дугаар зүйл. Тусгай зориулалтаар ан амьтан агнах, барих

1.Нэн ховор ан амьтныг зөвхөн судалгаа, шинжилгээний зориулалтаар, ховор ан амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлагийн зориулалтаар төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрлөөр тус тус агнаж, барьж болно.

2.Ховор ан амьтныг тусгай төлбөртэйгээр төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрлөөр агнаж, барьж болно.

3.Элбэг ан амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эрүүл мэндийн зэрэг зориулалтаар сум, дүүргийн Засаг даргын тусгай зөвшөөрлийн дагуу агнаж, барина.

21 дүгээр зүйл. Гадаадын иргэн ан амьтан агнах, барих

1.Монгол Улсын түр буюу байнга оршин суугаа гадаадын иргэн Монгол Улсын иргэний адил хэмжээний төлбөр төлж зөвхөн ахуйн зориулалтаар загас барьж болно.

2.Ан амьтан агнах, барих зорилгоор Монгол Улсад ирж буй гадаадын иргэн ховор болон элбэг ан амьтныг тусгай төлбөртэйгээр төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн дагуу агнаж, барьж болно.

22 дугаар зүйл. Ан амьтныг гадаад улсад гаргах

1.Нэн ховор ан амьтныг судалгаа, шинжилгээний зориулалтаар гадаад улсад гаргах асуудлыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

2.Нэн ховор болон ан амьтныг гадаад улсад гаргах тусгай зөвшөөрлийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн Засгийн газар, элбэг ан амьтныг гадаад улсад гаргах тусгай зөвшөөрлийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага тус тус олгоно.

3.Ан амьтны гаралтай түүхий эд, ан амьтны холбогдолтой судалгааны ажлын сорьц, дээжийг гадаад улсад гаргах тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

4.Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, ан амьтны холбогдолтой судалгааны ажлын сорьц, дээжийг гадаад улсад гаргах журмыг төрийн захиргааны төв байгууллага гаалийн байгууллага, холбогдох бусад захиргааны төв байгууллагатай хамтран тогтооно.

23 дугаар зүйл. Ан амьтан агнахыг хориглох хугацаа

1.Дор дурдсан хугацаанд ан амьтан агнахыг хориглоно:

1/бор гөрөөс, цагаан зээр, гахайг 12 дугаар сарын 1-ний өдрөөс дараа оны 9 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл;

2/баавгайг 11 дүгээр сарын 16-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 1-ний өдөр хүртэл;

3/ойн булга, хадны суусар, элбэнх, шилүүс, нохой зээх, үнэг, хярс, хэрэм, ойн солонго, чандага, бор туулайг 2 дугаар сарын 16-ны өдрөөс 10 дугаар сарын 21-ний өдөр хүртэл;

4/тарвагыг 10 дугаар сарын 16-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 10-ны өдөр хүртэл;

5/заарт хархыг 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 10 дугаар сарын 16-ны өдөр хүртэл;

6/доргыг 11 дүгээр сарын 1-ний өдрөөс дараа оны 9 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл.

2.Дор дурдсан хугацаанд шувуу агнах, загас барихыг хориглоно:

1/хөтүү, ятуу, хахилга, ногтруу, хур сойрыг 3 дугаар сарын 16-ны өдрөөс 9 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл;

2/галуу, нугас болон ус, намгийн бусад шувууг 5 дугаар сарын 1-ний өдрөөс 9 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл, 10 дугаар сарын 21-ны өдрөөс дараа оны 4 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл;

3/дархадын цагаан загасыг 8 дугаар сарын 1-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэл;

4/Буйр нуурын загасыг 5 дугаар сарын 16-ны өдрөөс 8 дугаар сарын 1-ний өдөр хүртэл;

5/омоль загасыг 12 дугаар сарын 1-ний өдрөөс дараа оны 9 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл;

6/зарам загасыг 8 дугаар сарын 1-ний өдрөөс 11 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл:

7/алтайн сугас загасыг 4 дүгээр сарын 16-ны өдрөөс 8 дугаар сарын 1-ний өдөр хүртэл;

8/энэ хэсгийн 3-7-д зааснаас бусад загасыг 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл.

3.Энэ зүйлийн 1,2 дахь хэсэгт зааснаасбусад ан амьтан агнах, барихыг хориглох хугацааг төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

24 дүгээр зүйл. Ан амьтан агнах, барихад хориглох арга, зэвсэг хэрэгсэл

Дор дурдсан арга, зэвсэг хэрэгслээр ан амьтан агнах, барихыг

хориглоно:

1/химийн бодис, тэсрэх, дэлбэрэх зүйл, хэрэгсэл ашиглах;

2/ан амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих;

3/туурайтан амьтныг агнахад цасанд умбуулах, мөсөнд хальтиргах, хясаа, эрэг, ганга руу нисгэх, хавх тавих;

4/тарвагыг нүхэнд нь утах, ус цутгах, урхи тавих, нохойгоор зориудаар бариулах;

5/ан амьтныг тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, утах;

6/загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, сэрээ, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх;

7/ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх;

8/ ан агнах зориулалтын бус буугаар ан амьтан агнах.

25 дугаар зүйл. Ан амьтныг агнах, барихтай холбогдсон зарим үйл ажиллагааг хориглох

Ан амьтан агнах, барихтай холбогдсон дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1/шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг байгалийн гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон ан амьтныг агнах, барих;

2/булаг, шанд, хужир мараанд ирж буй амьтныг отож агнах;

3/өөр нутагт шилжин байршиж байгаа ан амьтныг агнах, барих;

4/ан амьтны үүр, ичээ ухах, гэмтээх;

5/ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх зорилго бүхий байр, саравч, тэжээл, мараа, бусад байгууламжийг эвдэж гэмтээх, устгах;

6/ан амьтныг сайн танилгүй буюу анир чимээгээр таамаглаж буудах;

7/ан амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах;

8/ангийн буу, ан амьтан агнах тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлэх;

9/тарваганы түүхий мах, нойтон арьсыг хот, тосгонд оруулах;

10/хот, тосгоны ногоон бүсэд ан амьтны тоо толгойг зохицуулах зааслалт хийх, халдварт өвчний голомт устгах, судалгаа шинжилгээнийхээс бусад зорилгоор ан амьтан агнах, барих.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

26 дугаар зүйл. Ан агнуурын тухай хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1.Шүүгч, байгаль орчны байцаагч буюу байгаль хамгаалагч ан агнуурын тухай хууль тогтоомжийг дараахь байдлаар зөрчсөн этгээдэд зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1/хугацаа нь дууссан зөвшөөрлөөр ан амьтан агнасан, барьсан эсхүл ангийн буу, ан амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн иргэнийг 500-3000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000 төгрөгөөр торгох;

2/энэ хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу тогтоосон журмыг зөрчсөн, эсхүл 25 дугаар зүйлийн 10-т заасныг зөрчсөн иргэнийг 1000-5000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-75000 төгрөгөөр торгох;

3/энэ хуулийн 24 дүгээр зүйлийн 2,3,4,6, 25 дугаар зүйлийн 1,2,3,5,6,7-д заасныг зөрчсөн иргэнийг 2000- 5000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;

4/энэ хуулийн 23 дугаар зүйлд заасан хугацааг зөрчиж ан амьтан агнасан, барьсан, эсхүл ан амьтныг зохих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичигт зааснаас хэтрүүлэн агнасан, барьсан иргэнийг 3000-15000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;

5/энэ хуулийн 24 дүгээр зүйлийн 1,5,7,8, 25 дугаар зүйлийн 4,9-д заасныг зөрчсөн иргэнийг 10000-20000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 75000-150000 төгрөгөөр торгох;

6/зохих эрхийн бичиг, тусгай зөвшөөрөлгүйгээр ахуйн болон тусгай зориулалтаар ан амьтан агнасан, барьсан иргэнийг 10000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-200000 төгрөгөөр торгох;

7/зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар ан амьтан агнасан, барьсан иргэнийг 15000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2-7-д заасан зөрчлийг давтан үйлдсэн эсхүл энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5 дугаар

зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчсөн гэм буруутай этгээдэд зохих хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

3.Байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч хууль бусаар ан амьтан агнасан, барьсан этгээдийн ангийн зэвсэг, хэрэгсэл, агнасан, барьсан ан амьтан тэдгээрийн арьс, үс, мах, эвэр, заар, бусад түүхий эд болон олсон орлогыг хураана.

4.Гэм буруутай этгээдийн хууль бусаар ан амьтныг агнах, барихад ашигласан автомашин, мотоцикл, тээврийн өөрөө явагч бусад хэрэгслийг жолоодох эрхийг энэхүү эрхийг олгосон эрх бүхий байгууллага байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагчийн мэдүүлснээр 2 хүртэл жилийн хугацаагаар хасч болно.

27 дугаар зүйл. Ан амьтны санд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх

1.Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас ан амьтны санд учруулсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

2.Нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газраас тогтоосон ан амьтны мөнгөн үнэлгээг 2 нугалж тогтооно.

28 дугаар зүйл. Зөрчлийг илрүүлэгч, мэдээлэгчийг урамшуулах

Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэлнь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 15 хувиар тооцож мөнгөн шагналыг сум, дүүргийн Засаг дарга олгоно.

29 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь ой болон таримал ургамлаас бусад ургамал /цаашид "ургамал" гэх/-ыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Ургамлын тухай хууль тогтоомж

Ургамлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Ургамлын сан, түүний ангилал

1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хуурай газар, усны бүх зүйлийн гуурст ургамал, хөвд, замаг, хаг, мөөг болон бичил биетнээс ургамлын сан бүрдэнэ.

2. Ургамлыг түүний нөөц, нөхөн сэргэх чадварыг нь харгалзан дараахь байдлаар ангилна:

1/ нэн ховор;

2/ ховор;

3/ элбэг.

3. Нэн ховор ургамалд байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон /энэ хуулийн хавсралтаар тогтоосон/ ургамал хамаарна.

4. Ховор ургамалд байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац, нөөц багатай, устаж болзошгүй ургамал хамаарна. Ховор ургамлын жагсаалтыг Засгийн газар батална.

5. Элбэг ургамалд байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар сайн, түгээмэл тархацтай, нөөц ихтэй ургамал хамаарна. Элбэг ургамлын жагсаалтыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллага /цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ батална.

4 дүгээр зүйл. Ургамлыг хамгаалах үйл ажиллагааны удирдлага

Ургамлыг хамгаалах үйл ажиллагааны удирдлагыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

5 дугаар зүйл. Ургамлын нөөцийн мэдээллийн сан

1. Ургамлын нөөцийн мэдээллийн сан дараахь үзүүлэлтээс бүрдэнэ:

1/ ургамлын тархац, нөөцийн хэмжээ, түүний үнэлгээ;

2/ ургамлын хатаамал, бэлдмэл, үрийн цуглуулга;

3/ ургамлын судалгааны тайлан, мэдээ баримт;

4/ ургамлын хяналт-шинжилгээний ажиглалт, хэмжилтийн мэдээ баримт;

5/ ургамал хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний мэдээ.

2. Ургамлын мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

6 дугаар зүйл. Ургамал ашигласны төлбөр

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төрийн өмчийн газар дахь ургамлыг ашиглахдаа хууль тогтоомжид заасны дагуу төлбөр төлнө.

2. Ургамал ашигласны төлбөрийн дээд, доод хэмжээ, төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх журмыг хуулиар тогтооно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

УРГАМЛЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ

7 дугаар зүйл. Ургамлыг хамгаалах

1. Ургамлыг гал түймэр, өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах ажлыг бүх шатны Засаг дарга улсын төсвийн хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.

2. Нэн ховор, унаган буюу үлдвэр ургамлын удмын санг хамгаалах зорилгоор ургамлыг тарималжуулах, нутагшуулах ажлыг төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

3. Ургамлыг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж, хими, биологийн бодисын хортой нөлөөллөөс хамгаалах, хорио цээр тогтоох журмыг хуулиар тогтооно.

4. Ургамлыг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьжаас хамгаалахад төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөс бусад химийн бодис хэрэглэхийг хориглоно.

5. Нэн ховор ургамал бүхий газрыг тухайн ургамал хамгаалах, нөхөн сэргээхээс бусад зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэхийг хориглоно.

8 дугаар зүйл. Ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглох газар

1. Байгаль орчны тэнцлийг хангах ач холбогдол бүхий дараахь газар нутагт ургамлыг нөөцийнх нь хэмжээг үл харгалзан үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглоно:

1/ хот, тосгон, бусад суурины ногоон бүс;

2/ гол, горхины эх болон нуур, цөөрмийн эргээс 2 километрийн доторхи газар;

3/ нэн ховор амьтны байршил газар;

4/ баянбүрд;

5/ ургамлын бүрхэвч нь талхлагдсан газар;

6/ элсний нүүлтээс хамгаалах ач холбогдол бүхий газар;

7/ хөрсний элэгдлээс хамгаалах зурвас газар.

2. Сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4, 6, 7-д заасан газар, түүний заагийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтооно.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-4-т заасан газар мал бэлчээж болно.

9 дүгээр зүйл. Ургамлыг нөхөн сэргээх

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ургамлыг нь үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан газраа зохих журмын дагуу өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээх буюу нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлсний дараа сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

УРГАМЛЫГ АШИГЛАХ

10 дугаар зүйл. Ургамлыг ашиглах зориулалт

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нэн ховор ургамлыг зөвхөн судалгаа, шинжилгээний, ховор ургамлыг ахуйн болон судалгаа,

шинжилгээний, элбэг ургамлыг судалгаа, шинжилгээний, ахуйн, үйлдвэрлэлийн зориулалтаар тус тус ашиглаж болно.

11 дүгээр зүйл. Ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нэн ховор ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага, ховор ургамал ашиглах зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга тус тус олгоно.

2. Судалгаа шинжилгээний зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор бусдад борлуулахыг хориглоно.

12 дугаар зүйл. Ургамлыг ахуйн зориулалтаар ашиглах

Иргэн ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлөөр ашиглаж болно.

13 дугаар зүйл. Ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага элбэг ургамлыг хүнсний, техникийн болон ургамлын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах зориулалтаар ашиглаж болно.

2. Эм бэлтгэн найруулах ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага ховор болон элбэг ургамлыг эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж болно.

3. Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга, ховор ургамлыг эм үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

14 дүгээр зүйл. Бэлчээр, хадлангийн ургамлыг мал тэжээх зориулалтаар ашиглах

1. Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оршин суугаа /оршин байгаа/ сум, дүүргийн газар нутагт мал бэлчээх, хадлан авах зэргээр бэлчээр, хадлангийн газар дахь ургамлыг ашиглахдаа Газрын тухай хуулийн 51, 52 дугаар зүйлийг баримтална.

2. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нэн ховор ургамлыг хамгаалах зорилгоор түүний ургадаг газар мал бэлчээх, хадлан авахыг 2 хүртэл жилийн хугацаагаар хориглож болно.

3. Ургамлыг нөхөн сэргээх буюу нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах зорилгоор бэлчээр, хадлангийн газрыг хуваарьтай, даацад нь тохируулж ашиглуулах асуудлыг сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга шийдвэрлэнэ.

15 дугаар зүйл. Ургамлыг ашиглах зөвшөөрөл олгох журам

1. Үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал ашиглах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг өөрийн зардлаар хийлгэж, тухайн ургамлын нөөцийн хэмжээг тогтоолгож, ашиглахыг хүсч буй ургамлын зүйлийн нэр, эрхтэн, ашиглах зориулалт, хэмжээ, хугацаа, нөхөн сэргээх арга хэмжээг тусгасан төсөл боловсруулан холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулж ургамлыг ашиглах зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага буюу албан тушаалтанд өгнө.

2. Ургамлыг ашиглах зөвшөөрөл олгох байгууллага буюу албан тушаалтан нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ургамал ашиглах тухай хүсэлтийг тухайн этгээдийн боловсруулсан төсөл, түүний талаархи мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн хүсэлт хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

3. Ургамлыг ашиглах зөвшөөрлийг эрхийн бичгээр олгоно. Эрхийн бичгийг бусдад шилжүүлэн ашиглуулахыг хориглоно.

4. Эрхийн бичигт ургамлыг түүж бэлтгэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, ургамлын зүйлийн нэр, эрхтэн, түүж бэлтгэх хэмжээ, хугацаа, газрыг заана.

5. Тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч ургамал ашиглах эрхийн бичгийг үндэслэн ургамлыг түүж бэлтгэх газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зааж өгнө.

16 дугаар зүйл. Ургамлыг түүж бэлтгэх журам, хэмжээ, хугацаа

1. Ургамал ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ургамлыг түүж бэлтгэх журам, ашиглахыг зөвшөөрсөн хэмжээ, хугацааг баримтлан түүж бэлтгэнэ.

2. Ургамлыг түүж бэлтгэх журам, хэмжээ, хугацааг мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

17 дугаар зүйл. Ургамлыг гадаад улсад гаргах, гадаадын иргэн түүж бэлтгэх

1. Ургамлыг гадаад улсад гаргах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

2. Гадаад улсын иргэн нэн ховор, ховор ургамлыг түүж бэлтгэхийг хориглоно.

18 дугаар зүйл. Ургамлыг ашиглах зорилгоор газар эзэмшүүлэх, ашиглуулах

1. Сум, дүүргийн Засаг дарга ургамлыг нь үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зорилгоор түүний тархац газрыг иргэн аж ахуйн нэгж, байгууллагад төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн тодорхой хугацаатайгаар Газрын тухай хуульд заасан журмын дагуу гэрээ байгуулан эзэмшүүлж, ашиглуулж болно.

2. Ургамал ашиглах зорилгоор түүний тархац газрыг эзэмшиж ашиглах тухай гэрээнд Газрын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна дараахь зүйлийг тусгана:

1/ тухайн газарт ашиглах ургамлын нэр, ашиглах хэмжээ;

2/ ургамлыг ашиглах нөхцөл, болзол;

3/ гэрээ байгуулагч талуудын тухайн ургамлыг ашиглах хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон эрх, үүрэг, хариуцлага.

3. Ургамлыг ашиглах зорилгоор түүний тархац газрыг эзэмшигч ашиглагч нь тухайн ургамлыг болон түүний ургах орчинг хамгаалах, нөхөн сэргээх үүрэг хүлээхээс гадна Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан эрх, үүрэгтэй байна.

4. Ургамлыг нь ашиглахаас өөр зориулалтаар газрыг гэрээний дагуу эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эзэмшил, ашиглалтын газар дахь ургамлыг зохих журмын дагуу зөвшөөрөл авч үйлдвэрлэлийн зориулалтаар бо. төлбөртэйгээр, ахуйн зориулалтаар бол төлбөргүйгээр ашиглана

19 дүгээр зүйл. Ургамал ашиглагчийн үүрэг

Ургамал ашиглагч нь дараахь үүрэгтэй байна:

1/ ургамлын тухай хууль тогтоомжийг биелүүлэх;

2/ ургамлыг түүж бэлтгэх, нөхөн сэргээх журмыг баримтлах

3/ журам, зөвшөөролд заасан хэмжээ, хугацаанд ургамлыг түүж бэлтгэх;

4/ нэг наст ургамлыг түүний үр боловсорсны дараа түүж бэлтгэх;

5/ ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, нөөцийн хэмжээг өөрийн зардлаар тогтоолгон, ургамлыг нөхөн сэргээх буюу нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлэх;

6/ ургамлыг нь ашиглах зорилгоор газар эзэмших, ашиглах гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

20 дугаар зүйл. Мансууруулах бодис бүхий ургамал

1. Мансууруулах бодис бүхий ургамлын жагсаалтыг байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

2. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мансууруулах бодис бүхий ургамал ашиглаж эм бэлтгэн найруулах аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгож тэдгээрийг тусгай бүртгэлд бүртгэнэ.

3. Иргэн, түүнчлэн энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад аж ахуйн нэгж, байгууллага мансууруулах бодис бүхий ургамлыг түүх, ашиглах, тарихыг хориглоно.

21 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1. Шүүгч, байгаль орчны байцаагч буюу байгаль хамгаалагч байгалийн ургамлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

1/ ургамлыг түүж бэлтгэх журам зөрчсөн, эсхүл журам, зөвшөөрөлд заасан хугацааг зөрчсөн, хэмжээг хэтрүүлэн түүж бэлтгэсэн бол хууль бусаар түүж бэлтгэсэн зүйл, олсон орлогыг хурааж зөрчил гаргасан иргэнийг 500-5000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000 төгрөгөөр торгох;

2/ энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан газар болон энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тогтоосон газар үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн бол хууль бусаар түүж бэлтгэсэн зүйл олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 5000-15000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-75000 төгрөгөөр торгох;

3/ нэн ховор ургамлыг судалгаа, шинжилгээнийхээс бусад зориулалтаар, ховор ургамлыг эм бэлтгэн найруулахаас бусад

үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан бол хууль бусаар түүж бэлтгэсэн зүйл, олсон орлогыг хураажж, зөрчил гаргасан иргэнийг 10000-20000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 75000-100000 төгрөгөөр торгох;

4/ энэ хуульд заасан журмын дагуу зохих зөвшөөрөл авалгүйгээр ургамлыг ашигласан бол хууль бусаар түүж бэлтгэсэн зүйл, олсон орлогыг хураажж, зөрчил гаргасан иргэнийг 10000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-150000 төгрөгөөр торгох.

2. Байгалийн ургамлын тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас ургамлын санд учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

22 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ХАВСРАЛТ

НЭН ХОВОР УРГАМЛЫН ЖАГСААЛТ

(монгол, латин нэрээр)

1. Ильиний аарниг	Arnica Iljinii
2. Сибирь агдаргана	Zygadenus sibiricus
3. Анхилуун агранз	Biebersteinia obora
4. Бавгарүрт агчаахай	Dictamnus dasycarpus
5. Часулаан алтандусал	Tofildia coccinea
6. Ганццэцэгт алтанзул	Tulipa uniflora
7. Цөлийн аргамжинцэцэг	Cistanche deserticolla
8. Хонин арц	Juniperus sabina
9. Навчгүй багалуур	Anabasis aphylla
10 Ноосоншилбэт багалуур	Anabasis eriopoda
11. Сайхны бамбай	Valeriana saichanensis
12. Вансэмбэрүү банздоо	Saussurea involucrata
13. Төвд баягзаваа	Lancea tibetica
14. Цагаан боролзгоно	Dasiphora lactiflora
15. Цавцагаан бөлбөө	Nympnaea candida
16. Регелийн будраа	Iljinia Regelii
17. Монгол буурцгана	Chesneya mongolica
18. Монгол бүрэлгэнэ	Viburnum mongolicum
19. Саржентийн бүрэлгэнэ	Viburnum Sargentii
20. Алтан бэрмэг	Limonium aureum
21. Шар бэрээмэг	Arnebia guttata
22. Манж гандигар	Sambucus manshurica
23. Цэдэнгийн гиш	Vicia Tsydenii
24. Ганцсудалт гишүүнэ	Rheum uninerve
25. Эгэл годил өвс	Acorus calamus
26. Уртнавчит далантовч	Androsace longifolia
27. Томнавчит дэгд	Gentiana macrophylla
28. Сэвсгэр дэгд	Gentiana pulmonaria
29. Бага жагмаа	Typha minima
30. Мавританы жамба	Malva mauritiana
31. Соёны жамъянмядаг	Trollius sajanense
32. Мурхрофтын жигд	Eiaeagnus Moorcroftii
33. Сибирь жодоо	Abies sibirica

34. Зэгэл зогдоргоно	Clematis glauca
35. Өргөн зуншилцэцэг	Majanthemum dilatatum
36. Бяцхан зууч	Cardamine parviflora
37. Банзрагчийн зүлгэлж	Swertia Banzaragczii
38. Морин зээргэнэ	Ephedra equisetina
39. Федченкогийн зээргэнэ	Ephedra Fedtschenkoae
40. Алтаргана илаархай	Solidago dahurica
41. Төв-азийн лавай	Asterthamnus centraliasiaticus
42. Шаравтар лидэр	Sophora flavescens
43. Цайвардуу могойн идээ	Sedum pallescens
44. Элсний мөнхцэцэг	Helichrysum arenarium
45. Монгол мөнххаргана	Ammopiptanthus mongolicus
46. Намхан мухарцагаан	Polygonatum humile
47. Цөлийн мүгваа	Salvia deserta
48. Алтангагнуур мүгэз	Rhodiola rosea
49. Намгийн наангил	Scheuchzeria palustris
50. Ахарэвэрт нил	Viola brachycera
51. Хоснавчит нилгэнэ	Platanthera bifolia
52. Тансаг номилгоно	Anemarrhena asphodeloides
53. Пржевальскийн нүцгэнүүр	Gymnocarpos Przewalskii
54. Хар нэрс	Vaccinium myrtillus
55. Өргөн ойм	Dryopteris dilatata
56. Навчгүй оочгоно	Epipogium aphyllum
57. Шивүүр ортууз	Oxytropis acanthacea
58. Хэврэг навчит ортууз	Oxytropis fragilifolia
59. Грубовын ортууз	Oxytropis Grubovii
60. Эгэл өмхий өвс	Peganum harmala
61. Их саадганцэцэг	Cypirpedium macranthum
62. Шар саадганцэцэг	Cypirpedium calceolus
63. Бяцхан саахууцэцэг	Nuphar pumila
64. Ганцнавчит салжир	Gueldenstaedtia monophylla
65. Буржгар сараана	Lilium martagon
66. Дагуур сараана	Lilium pensylvanicum
67. Коканд сарнай	Rosa Kokanica
68. Сийрэг сарнай	Rosa laxa
69. Томдохиурт сонгино	Allium macrostemon
70. Сармисан сонгино	Allium obliguum
71. Тагийн сөд	Sanguisorba alpina
72. Хөвдөг сумалж	Sagittaria natans

73. Ямаан сэрдэг	Saxifraga hirculus
74. Нүцгэн товьцэцэг	Mitella nuda
75. Оньт тонхуу	Chrysanthemum sinuatum
76. Говийн тост	Brachanthemum gobicum
77. Монголчуудын тост	Brachanthemum mongolorum
78. Уулын туйпланцар	Phlomis oreophila
79. Өргөннавчит тутаргана	Zizania latifolia
80. Болцуут түдэнхавх	Calypso bulbosa
81. Сибирь тэмээнхөх	Vincetoxicum sibiricum
82. Алтан тэрэлж	Rhododendron aureum
83. Адамсын тэрэлж	Rhododendron Adamsii
84. Дагуур тэрэлж	Rhododendron dahuricum
85. Ледебүрийн тэрэлж	Rhododendron Ledebourii
86. Жижигнавчит тэрэлж	Rhododendron pravifolium
87. Тэснавчит тэсмэг	Sorbaria sorbifolia
88. Ганболдын удвал	Aquilegia Ganboldii
89. Потанийн улаантулам	Incarvillea Potaninii
90. Элдэвнавчит улиас	Populus diversifolia
91. Төгрөгнавчит үстхиг	Drosera rotundifolia
92. Англи үстхиг	Drosera anglica
93. Залаархаг хавраг	Ferula ferulaeodes
94. Говийн харгана	Caragana gobica
95. Хойрго харгана	Caragana brachypoda
96. Төвд харгана	Caragana tibetica
97. Газрын хар үс	Nematonostoc flagelliforme
98. Цагааннавчит хасзул	Olgaea leucophylla
99. Хулан хойрго	Potatinia mongolica
100. Ганган хонгорзул	Centaurea pulchella
101. Мөгөөрсхэй хонгорцгоно	Rhaponticum carthamnoides
102. Кейскегийн хонхорцог	Convallaria Keiskei
103. Сүүнорхоодой хонхоодой	Codonopsis clematidea
104. Мөнгөлөг хонхотхаргана	Halimodendron halodendron
105. Кузнецовын хорс	Aconitum Kusnezoffii
106. Потанинийн хотир	Zygophyllum Potaninii
107. Алтайн хувиланга	Pedicularis altaica
108. Шарилжиннавчит хувилганга	Pedicularis abrotanifolia
109. Монгол хундгана	Adonis mongolica
110. Цагаан хүн хорс	Phvsochlaina albiflora

111. Жижиг цангис	Oxycoccus microcarpus
112. Дуулгавчин цахирам	Orchis militaris
113. Фуксийн цахирам	Orchis Fuchsii
114. Хөхөө цүнхрэг	Neottianthe cucullata
115. Камчатын цүнхүй	Neottia camtschatea
116. Цагаан цээнэ	Paeonia lactiflora
117. Тойруулгат чандганчих	Paris verticillata
118. Баруунхуурайн чихэр өвс	Glycyrrhiza squamulosa
119. Монгол чоногоно	Jurinea mongolica
120. Гиений хаврын шар	Gagea neensis
121. Монгол шардалан	Tugarinovia mongolica
122. Чулуусаг шарилж	Artemisia lithophila
123. Жанз шарилж	Artemisia tomentella
124. Алтаншар шарилж	Artemisia xanthochroa
125. Хүнсний шигмээ	Aspecilia esculenta
126. Сөөгөн шимэрс	Hedysarum fruticosum
127. Цэнгэлийн шимэрс	Hedysarum sanilense
128. Юлдэн шүүдэр ойм	Botrychium lanceolatum
129. Гурвалсан шүрүндэс	Corrallorhiza trifida
130. Балуун шивэрс	Lycopodium clavatum
131. Тагийн шивэрс	Lycopodium alpinum
132. Жижигнавчит яшил	Rhamnus parvifolia
133. Уссур яшил	Rhamnus ussuriensis

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

УСНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь усыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Усны тухай хууль тогтоомж

Усны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Усны нөөцийн сан

1. Усны нөөцийн сан нь Монгол Улсын хилийн доторхи гадаргын болон газрын доорхи ус, рашаан /цаашид "ус" гэх/-аас бүрдэнэ.

2. Байгаль дахь усны тэнцэлийг алдагдуулахгүйгээр тодорхой хугацаанд байгалиас авч болох усны дээд хэмжээгээр ашиглах боломжит усны нөөцийг тодорхойлно.

3. Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт усны бүрэлдэн бий болох, хувьсан өөрчлөгдөх зүй тогтлыг нь үндэслэн усны нөөц, үүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээ тогтоох ажлыг тухайн шатны Засаг дарга орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

4 дүгээр зүйл. Усны эрэл, хайгуул, судалгаа

1. Усны нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг эрэл, хайгуул, судалгаагаар тогтооно.

2. Улсын зэрэглэлтэй хотын төвлөрсөн ус хангамжийн усны эх үүсвэрийн нөөцийн эрэл, хайгуул, судалгааны ажлыг улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр, бусад хот, тосгоны ус хангамж, бэлчээр усжуулалтын усны эх үүсвэрийн нөөцийн эрэл, хайгуул, судалгааны ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр тус тус санхүүжүүлнэ.

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардагдах усны нөөцийн хайгуул судалгааны ажлыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Улсын зэрэглэлтэй хотын төвлөрсөн усан хангамжийн усны эх үүсвэрийн эрэл, хайгуул, судалгааны ажлын захиалгыг аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн байгууллагад өгнө.

5. Усны нөөцийн эрэл, хайгуул, судалгааг мэргэжлийн байгууллага Газрын хэвлийн тухай хуульд заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

5 дугаар зүйл. Усны хяналт-шинжилгээний сүлжээ

1. Усны хяналт-шинжилгээний сүлжээ нь усны нөөц, чанарын өөрчлөлтийг тогтоох байнгын ажиллагаатай өртөө, харуулаас бүрдэнэ.

2. Усны хяналт-шинжилгээний өртөө, харуулын тоо, байршил, шинжилгээ, хэмжилт хийх багаж хэрэгслийн төрөл болон арга зүй, хөтөлбөрийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоож мэргэжлийн удирдлагаар хангана.

3. Усны хяналт-шинжилгээний сүлжээг тоноглох, багаж хэрэгслээр хангах зардлыг улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр, сүлжээг ажиллуулах зардлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр тус тус санхүүжүүлнэ.

6 дугаар зүйл. Усны мэдээллийн сан

1. Усны мэдээллийн сан нь ус хуримтлуулах талбай, усны нөөц, чанар, тэдгээрийн өөрчлөлт, ус ашиглалтын болон хаягдал ус зайлуулахтай холбогдсон хэмжилт, ажиглалт, судалгааны тайлан, мэдээ, баримтаас бүрдэнэ.

2. Усны мэдээллийн сан дараахь үзүүлэлтээс бүрдэнэ:

1/ усны нөөц, чанарын тоо бүртгэл;

2/ усны ай сав, аймаг, нийслэлийн байгалийн усны тэнцэл;

3/ усны ай сав, аймаг, нийслэлийн аж ахуйн усны тэнцэл;

4/ ус ашиглалт, хаягдал ус зайлуулалтын бүртгэл;

5/ шаардлагатай бусад мэдээлэл.

3. Усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

7 дугаар зүйл. Усны тоо бүртгэл

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд усны эх үүсвэрийн тоо, усны нөөц, ашиглагчдад гэрээний дагуу хуваарилсан усны

хэмжээ, хаягдал усны хэмжээ, найрлагын тоо бүртгэлийг зохих шатны Засаг даргын шийдвэрээр жил бүр орон нутгийн төсвийн хөрөнгөөр, улсын хэмжээнд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр 5 жил тутам улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр мэргэжлийн байгууллага явуулна.

2. Усны тоо бүртгэл явуулах журмыг Засгийн газар тогтооно.

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны тоо бүртгэл явуулахтай холбогдуулж эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг биелүүлж, шаардагдах мэдээг өгөх үүрэгтэй.

8 дугаар зүйл. Ус ашиглалтыг зохицуулах

1. Усны нөөц нь бүрэн нөхөгдөн сэргэдэг бүс нутагт усыг бүх төрлийн зориулалтаар ашиглаж болно.

2. Усны нөөц нь бүрэн нөхөгдөн сэргэдэггүй бүс нутагт хүн амын унд ахуйн хэрэгцээ болон бэлчээрийн мал услахаас бусад зориулалтын ус ашиглалтыг аймаг, нийслэлийн буюу сум, дүүргийн Засаг дарга хязгаарлаж болно.

3. Зуугаас дээш ам. километр талбай бүхий усан сан байгуулах асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

4. Усны нөөцийн зарим хэсгийг нэг нутаг дэвсгэрээс нөгөөд шилжүүлэн урсгах, томоохон гол, мөрөнд урсацын тохируулга хийх асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

9 дүгээр зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага усыг хамгаалах, зохистой ашиглах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ усны нөөцийн улсын тоо бүртгэл хөтлөх;

2/ ус ашиглалт, хаягдал ус зайлуулалт, усны бохирдлын тайлан мэдээг жил бүр нэгтгэн дүгнэх;

3/ ус хэрэглээний хэмжээ, стандартыг боловсруулах;

4/ усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, усны хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, түүний улмаас байгальд учирсан уршгийг арилгах арга хэмжээг мэргэжлийн удирдлагаар хангах;

5/ хаягдал ус зайлуулах цэг тогтоох журмыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран баталж мөрдүүлэх;

6/ аймаг дамжин урсдаг гол, мөрний усны ашиглалтыг зохицуулах

10 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

Аймаг, нийслэлийн Засаг дарга усыг хамгаалах, зохистой ашиглах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ нутаг дэвсгэртээ ус хуримтлуулах, нөхөн сэргээх, зохистой ашиглах чанарыг нь хамгаалах, усны хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, уршгийг арилгах арга хэмжээний төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулах;

2/ сум дундын болон дүүрэг дундын ус ашиглалт, хуваарилалтыг зохицуулах;

3/ усны нөөц хомсдох, чанар нь алдагдах, бохирдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

4/ хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны болон ахуйн хэрэгцээний усаар хангах арга хэмжээ авах.

11 дүгээр зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

Сум, дүүргийн Засаг дарга усыг хамгаалах зохистой ашиглах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ нутаг дэвсгэртээ ус хуримтлуулах, нөхөн сэргээх, зохистой ашиглах, чанарыг нь хамгаалах, усны хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, уршгийг арилгах арга хэмжээний төлөвлөгөө түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах;

2/ нутаг дэвсгэртээ усны нөөцийн хуваарилалтыг зохицуулах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад усыг гэрээгээр ашиглуулах талаар шийдвэр гаргах;

3/ тогтоосон журмын дагуу хаягдал ус зайлуулах цэгийг мэргэжлийн байгууллагатай хамтран тогтоох;

4/ усны нөөц хомсдох, гол, горхи, нуур, булаг, шанд, худгийн ус ширгэх, бохирдох тохиолдолд тэдгээрийг нөхөн сэргээх, ус хуримтлуулах, гол, горхи, булаг, шандын эхийг тохижуулах, ойжуулах, ургамалжуулах;

5/ нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усны эх үүсвэрээр хангах арга хэмжээ авах;

6/ төрийн өмчийн усны барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавих, засвар үйлчилгээ хийх, өргөтгөх ажлыг улсын

төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлэх;

7/ усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг сурталчлах.

12 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх

Баг, хорооны Засаг дарга усыг хамгаалах, зохистой ашиглах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ усыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх тухай хууль тогтоомж эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ хангуулах;

2/ гол, горхи, булаг, шандийн эхийг тохижуулах, мод, суулгац тарих, ургамалжуулах, ундаргыг нэмэгдүүлэх, ширгэх, бохирдохоос хамгаалах арга хэмжээнд иргэдийг татан оролцуулж хэрэгжүүлэх;

3/ нутаг дэвсгэртээ нийтийн ашиглалтын усны ашиглалт, хамгаалалт, ариун цэврийн нөхцөлийг хангуулах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

УСЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ

13 дугаар зүйл. Усны нөөц, чанарыг хамгаалах

1. Усны тухайн эх үүсвэрийн нөөцийг ашиглахдаа байгаль орчны тэнцлийг хангахад шаардагдах хэмжээний усыг байгальд заавал үлдээнэ.

2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал экологийн онцгой ач холбогдол бүхий гол, нуур, рашаан, булаг, шандыг орон нутгийн хамгаалалтад авч болно.

3. Усны эх үүсвэр аж ахуйн үйл ажиллагааны нөлөөллийн улмаас хомсдож бохирдохоос хамгаалах зорилгоор байгуулах хамгаалалтын бүсийн заагийг газрын хөрс, чулуулгийн тогтоцыг харгалзан гаргасан мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тогтооно.

4. Төвлөрсөн ус хангамжийн усны эх үүсвэрийн орчимд 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүс тогтооно.

5. Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

6. Ус ашиглах технологи нь олон улсын жишиг болон улсын стандартад тохирохгүй үйлдвэр үйлчилгээний газар, аж ахуйн нэгжийг байгуулах, ажиллуулахыг хориглоно.

14 дүгээр зүйл. Усны нөөцийг хомсдохоос хамгаалах

1. Сум, дүүргийн Засаг дарга усны байгалийн жамаар нөхөн сэргэх, цэвэрших чадвар буурсан тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны хэмжээг шинэчлэн тогтоох, ус хуримтлуулах ажлыг зохион байгуулна.

2. Ус ашиглагч усны тухай хууль тогтоомж, усны барилга байгууламжийн техникийн нөхцөл, ашиглалтын технологийн горимыг зөрчсөнөөс усны нөөц хомсдож, чанар нь алдагдвал аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ус ашиглалтыг зогсоож, цэвэршүүлэх, нөхөн сэргээх ажлыг тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зардлаар гүйцэтгүүлнэ.

3. Ойн тухай болон Байгалийн ургамлын тухай хуульд заасан хориотой зурваст мод огтлох, үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал ашиглах, усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд батлагдсан зураг төсөл, зөвшөөрөлгүйгээр элс, хайрга авах, ашигт малтмалын орд ашиглахыг хориглоно.

4. Барилга байгууламж барих явцад урсгал усны голдирлыг өөрчлөх зайлшгүй шаардлага гарвал түүнийг байгалийн төрхөд нь буцааж оруулах, засаж тохижуулах арга хэмжээний зардлыг зураг төсөлд тусгаж хэрэгжүүлнэ.

5. Гол, мөрний усны байгалийн үндсэн голдирлыг бүрмөсөн өөрчлөхийг хориглоно.

15 дугаар зүйл. Усыг бохирдохоос хамгаалах

1. Усны эх үүсвэр, голдирол, гуу жалга, сайр болон хамгаалалтын бүсэд хог хаягдал, бохирдуулах бодис хаяхыг хориглоно.

2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж дууссан цооногоо битүүмжлэн сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэж өгнө.

3. Ашигт малтмал эрж хайх, олборлох явцад ус бүхий давхаргыг илэрвэл түүнийг бохирдохоос хамгаалах арга хэмжээ авч зохих шатны Засаг даргад мэдэгдэн усны мэдээллийн санд тусгуулна.

4. Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь малыг угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэгийг усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийн гадна урсгалын доод талд нь байрлуулж бохир усыг ариутгаж зайлуулна.

5. Аж ахуйн нэгж, байгууллага болон хот, тосгон бусад суурины оршин суугч иргэн ахуйн бохир хаях цэгээ эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу доторлож тохижуулан ашиглана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

УС АШИГЛАХ

16 дугаар зүйл. Ус ашиглах зориулалт

1. Усыг дараахь зориулалтаар ашиглана:

1/ ахуйн;

2/ үйлдвэрлэлийн.

2. Усыг орлого олох зорилгогүйгээр хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал услахад ашиглахыг ахуйн зориулалтаар ус ашиглах гэнэ.

3. Ус болон усан орчинг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд ашиглахыг үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглах гэнэ.

17 дугаар зүйл. Ус ашиглах

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахад гэрээ байгуулна.

2. Ус ашиглах гэрээг 40 хүртэл жилийн хугацаагаар байгуулж болох бөгөөд түүнийг нэг удаад сунгах хугацаа 20 жилээс илүүгүй байна.

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны эх үүсвэрийг гэрээний үндсэн дээр дундаа ашиглаж болно.

4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оршин суугаа сум, дүүрэгтээ, газар эзэмшигч өөрийн эзэмшлийн газар дахь усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах давуу эрхтэй боловч энэ нь бусдын ус ашиглах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

18 дугаар зүйл. Ус ашиглах тухай хүсэлт гаргах

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглах тухай хүсэлтээ сум, дүүргийн Засаг даргад гаргана.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтэд дараахь зүйлийг тусгана:

1/ ашиглах усны эх үүсвэр, түүний байршлыг харуулсан зураг;

2/ ус ашиглах хэмжээ, хугацаа;

3/ байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

4/ усны барилга байгууламжийн зураг төсөл;

5/ үйлдвэрлэлийн хүч чадал, техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлт.

19 дүгээр зүйл. Ус ашиглах зөвшөөрөл олгох

1. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зүйлийг хянан үзэж тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглуулах эсэх тухай шийдвэр гаргана.

2. Үйлдвэрлэлийн зориулалтаар усны нэг эх үүсвэрийг ашиглахаар хоёр буюу түүнээс дээш этгээд хүсэлт гаргавал сум, дүүргийн Засаг дарга хүсэлт гаргагчийн оршин суугаа /оршин байгаа/ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал, ус ашиглалтын зориулалт, ус ашиглалтын эдийн засгийн үр ашиг, байгаль орчинд болон усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл, төлбөрийн чадвар зэрэг нөхцөлийг харгалзан сонголт хийнэ.

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээнээс үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглуулах бохир ус нийлүүлэх зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно.

4. Улсын болон бүс нутгийн онцгой ач холбогдол бүхий томоохон үйлдвэр, аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглуулах тухай шийдвэрийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн Засгийн газар гаргана.

20 дугаар зүйл. Ус ашиглах гэрээ байгуулах

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус ашиглуулах тухай Засаг даргын шийдвэрийг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн усны мэргэжлийн байгууллагатай үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглах гэрээ байгуулна.

2. Ус ашиглах гэрээнд дараахь зүйлийг тусгана:

1/ ус ашиглах үндэслэл /зохих шийдвэр/;

2/ ус ашиглах зориулалт, хэмжээ, хугацаа;

3/ усны эх үүсвэрийн байршил, барилга байгууламжийн зураг төсөл;

4/ хаях усны хэмжээ, цэвэршүүлэх технологи, цэвэрлэгээний түвшин;

5/ усны төлөв байдал, чанарын найрлага;

6/ усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах арга хэмжээ түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ;

7/ гэрээ байгуулагч талуудын эрх, үүрэг, хариуцлага;

8/ шаардлагатай бусад зүйл.

21 дүгээр зүйл. Үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглахад тавих үндсэн шаардлага

1. Үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь шаардлагыг биелүүлнэ:

1/ ус ашиглалтын технологийн шаардлагын дагуу бохир ус цэвэршүүлэх барилга байгууламжтай байх;

2/ ус ашиглалтын технологийн дагуу цэвэршүүлэх барилга байгууламжтай байх шаардлагагүй аж ахуйн нэгж, байгууллага хаягдал усаа зайлуулах цэг тогтоолгож тээвэрлэн хаях;

3/ усыг дахин ашиглах, хэмнэлттэй зарцуулах технологи хэрэглэх;

4/ усны нөөц нь бүрэн нөхөгдөн сэргэдэггүй газар нутагт ус ашигласны төлбөрийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг мод, ургамал тарих зэрэг усны нөөцийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлэх арга хэмжээнд зарцуулах.

2. Цэвэр болон хаягдал усны тоолуургүй үйлдвэр аж ахуйн нэгжид ус ашигласны төлбөрийн хэмжээг ус ашиглах тоног төхөөрөмж, барилга байгууламжийн хүч чадал буюу нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах усны хэм хэмжээг үндэслэн тогтооно.

3. Улсын зэрэглэлтэй хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөхөд түүнээс үйлдвэрлэлийн зориулалттай усны эх үүсвэр, шугам сүлжээг тусгаарлана.

4. Загас хамгаалах байгууламжгүй болон газрын хөрсийг намагжих, давсжих, эвдрэхэд хүргэхээр усны барилга, байгууламж, усан сан, далан, суваг, нуур, цөөрөм байгуулах, ашиглахыг хориглоно.

22 дугаар зүйл. Ус ашиглагчийн эрх, үүрэг

1. Гэрээний дагуу ус ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь эрхтэй байна:

1/ усыг гэрээнд заасан хэмжээ, зориулалтаар ашиглах;

2/ хууль тогтоомж болон ус ашиглах гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлж байсан бол гэрээний хугацаа дууссан тохиолдолд усыг үргэлжлүүлэн ашиглахаар гэрээг сунгуулах.

2. Гэрээний дагуу ус ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэгтэй байна:

1/ усны нөөц, чанарыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх тухай хууль тогтоомж, гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх;

2/ ашиглаж буй усны нөөц, чанарыг хамгаалах арга хэмжээг жил бүр төлөвлөн өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх;

3/ ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөх;

4/ ашигласан болон хаягдал усны бүртгэл тайлан хөтөлж сум, дүүргийн Засаг даргад тогтоосон хугацаанд өгөх;

5/ урсгалын дээд талд орших ус ашиглагч нь усны байгалийн тэнцэл, чанарыг өөрчлөхгүй байх;

6/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээний нөхцлийн дагуу тэдгээрийг чанарын баталгаатай усаар хангах;

7/ ус татах болон бохир ус цэвэршүүлэх барилга байгууламжийг хэвийн ажиллагаатай байлгаж, засвар үйлчилгээг хугацаанд нь хийх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

23 дугаар зүйл. Усны барилга байгууламж

1. Усны барилга байгууламж өмчлөгч, эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нийтийн гэрээний нөхцлөөр бусдын усны хэрэгцээг хангах үүрэгтэй бөгөөд гэрээний үүргээ биелүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уст цэг бүхий газар эзэмшүүлсэн буюу ашиглуулсан гэрээг цуцалж болно.

2. Хүн амын төвлөрсөн усан хангамжийн зориулалттай усны барилга байгууламж төрийн өмчид байна.

24 дүгээр зүйл. Улсын хилийн ус ашиглалтыг зохицуулах

Монгол Улсын хилийн ус ашиглалтыг Монгол Улсын олон улсын гэрээ, Хилийн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.

25 дугаар зүйл. Усны хөнөөлөөс сэргийлэх

1. Усны үерт автах, тошин үүсэх, цөн түрэх, усны барилга байгууламж, эрэг голдирол эвдрэх, газрын хөрс намагжих, давсжих, газрын доорхи усны түвшин дээшлэх зэрэг усны хөнөөлөөс сэргийлэх арга хэмжээг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга зохион байгуулна.

2. Усны үерийн аюулын үед яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хөнөөлийг арилгах ажлыг Иргэний хамгаалалтын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

26 дугаар зүйл. Ус ашигласны төлбөр

1. Үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төлбөр төлнө.

2. Ус ашигласны төлбөрийн дээд, доод хэмжээ, төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх журмыг хуулиар тогтооно.

3. Ус ашигласны төлбөр, нөхөн төлбөрийн орлогын тодорхой хувийг усны нөөц, чанарыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулна.

27 дугаар зүйл. Усыг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг урамшуулах

Засаг дарга орон нутгийн төсөвт орсон усны нөхөн төлбөрийн орлогыг учирсан хохирлыг арилгахад зарцуулахаас гадна усны нөөц, чанарыг хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн, байгаль орчинд ивээлтэй технологи хэрэглэж байгаа ус ашиглагчийг урамшуулахад зориулан зарцуулна.

28 дугаар зүйл. Усны тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1. Шүүгч буюу байгаль орчны байцаагч усны тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

1/ ус ашиглалтын болон хаягдал усны бүртгэл, мэдээг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хугацаанд нь гаргаж өгөөгүй иргэнийг 1000-3000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000 төгрөгөөр торгох;

2/ энэ хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу усыг бохирдохоос хамгаалах шаардлагыг биелүүлээгүй, эсхүл усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн иргэнийг 5000-15000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-75000 төгрөгөөр торгох;

3/ ус татах болон бохир ус цэвэршүүлэх барилга байгууламжийн хэвийн ажиллагааг хангах шаардлагыг биелүүлээгүй, тэдгээрт засвар үйлчилгээ хийгээгүй, эсхүл энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан шаардлагыг зөрчсөн бол зөрчил гаргасан иргэнийг 5000-15000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 75000-100000 төгрөгөөр торгох;

4/ энэ хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6-д заасныг зөрчсөний улмаас усыг ахуйн зориулалтаар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус хангамжийг тасалдуулсан буюу эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй усаар хангасан иргэнийг 10000-20000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-150000 төгрөгөөр торгох;

5/ усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр ашигласан буюу гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан бол хууль бусаар олсон орлогыг хураож зөрчил гаргасан иргэнийг 10000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-200000 төгрөгөөр торгох;

6/ энэ хуулийн 13 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт хориглосон үйл ажиллагааг явуулсан бол хууль бусаар олсон орлогыг хураож зөрчил гаргасан иргэнийг 20000-35000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан захиргааны шийтгэлийг байгаль хамгаалагч ногдуулж болно.

29 дүгээр зүйл. Хохирлыг нөхөн төлүүлэх

1. Усны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас усны санд учруулсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

2. Нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газраас тогтоосон усны мөнгөн үнэлгээгээр тогтооно.

30 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1995 оны 4 дүгээр
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

ХИМИЙН ХОРТ БОДИСООС ХАМГААЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь химийн хорт бодис үйлдвэрлэх, экспортлох, импортлох, хадгалах, худалдах, тээвэрлэх, хэрэглэх, устгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Химийн хорт бодисын тухай хууль тогтоомж

Химийн хорт бодисын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Химийн хорт бодис, түүний ангилал

1. Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөөлөл үзүүлэх, улмаар үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй химийн бодис, бэлдмэл (цацраг идэвхт, мансууруулах болон сэтгэц заслын бодис, эмийн бэлдмэл, хүнсний нэмэлтээс бусад) нь химийн хорт бодист хамаарна.

2. Химийн хорт бодисыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, хордуулах шинж чанараар нь онцгой хортой, хортой, бага хортой гэж ангилна.

3. Тодорхой ангилалд хамаарах химийн хорт бодисын жагсаалтыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

4 дүгээр зүйл. Химийн хорт бодистой харьцах үйл ажиллагааг зохицуулах

1. Химийн хорт бодисоос хамгаалах, түүнийг ашиглах үйл ажиллагааг зохицуулах, хянах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг төрийн захиргааны төв байгууллага эрхэлнэ.

2. Төрийн захиргааны төв байгууллага химийн хорт бодисоос хамгаалах талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/ химийн хорт бодис үйлдвэрлэх, экспортлох, импортлох, худалдах, устгах, ашиглах зөвшөөрлийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад энэ хуульд заасны дагуу олгох;

2/ химийн хорт бодисоос хамгаалах, түүнийг ашиглахтай холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавьж, эрхэлсэн асуудлаараа зөвлөмж гаргах;

3/ улсын хэмжээнд хэрэглэж байгаа химийн хорт бодисын ашиглалт зарцуулалтын тайлан гаргах;

4/ химийн хорт бодисын үйлдвэрлэл, экспорт, импорт, хэрэглээний улсын бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх;

5/ ургамал хамгаалал, бордооны болон туршилтын зориулалтаар хэрэглэх агрохимийн бодисын жагсаалт, тэдгээрийн хэрэглээний хэмжээг жил бүр шинэчлэн батлах;

6/ Монгол Улсын нэгдэн орсон химийн хорт бодисын болон химийн зэвсгийн талаархи олон улсын гэрээг хэрэгжүүлэх ажлыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд эрхлэх;

7/ химийн хорт бодисын алдагдлын улмаас үндэсний аюулгүй байдал болон хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хохирол, аюул учирвал түүнийг арилгахад олон улсын байгууллагын тусламж хүсэх саналыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх;

8/ химийн хорт бодистой харьцаж ажиллагсдын мэдлэг, дадлагыг дээшлүүлэх зорилгоор сургалт зохион байгуулах;

9/ химийн хорт бодисын талаар олон улсын байгууллагатай мэдээлэл солилцох, иргэдийг мэдээллээр хангах.

3. Төрийн захиргааны төв байгууллагын дэргэд энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2, 3, 8, 9-д заасан ажлыг хэрэгжүүлэх үүрэг бүхий орон тооны бус Зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ ажиллана.

5 дугаар зүйл. Химийн хорт бодисын мэдээллийн сан

1. Төрийн захиргааны төв байгууллага химийн хорт бодисын мэдээллийн сантай байна.

2. Химийн хорт бодисын мэдээллийн сан нь олон улсын мэдээллийн сан болон түүний жишигт нийцүүлэн бүрдүүлсэн улсын мэдээллийн сангаас бүрдэнэ.

3. Химийн хорт бодисын мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

4. Химийн хорт бодисын мэдээллийн сангийн мэдээ, баримтыг аж ахуйн нэгж, байгууллагад тэдгээрийн захиалгын дагуу олгоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХИМИЙН ХОРТ БОДИСООС ХАМГААЛАХ, ТҮҮНИЙГ АШИГЛАХАД ТАВИХ ШААРДЛАГА

6 дугаар зүйл. Химийн хорт бодисоос хамгаалах

1. Химийн хорт бодис ашиглах явцад хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөөлөхөөс хамгаалах арга хэмжээг химийн хорт бодис ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн зардлаар хэрэгжүүлнэ.

2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт бодис ашиглаж үйл ажиллагаа явуулахдаа зохих хууль тогтоомж, аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горимыг дагаж мөрдөнө.

7 дугаар зүйл. Химийн хорт бодис үйлдвэрлэх, экспортлох, импортлоход тавих үндсэн шаардлага

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт бодис үйлдвэрлэх, экспортлох, импортлоход дараахь шаардлагыг биелүүлнэ:

1/ химийн хорт бодис үйлдвэрлэхдээ тухайн үйлдвэрлэлд ашиглах, шинээр гарган авах бодисын шинж чанар, нөлөөллийн талаар тодорхой мэдээлэл бэлтгэж эрх бүхий мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах;

2/ хортой, бага хортой химийн бодисыг үйлдвэрлэх, импортлоход аймаг, нийслэлийн Засаг даргаас зөвшөөрөл авах;

3/ онцгой хортой химийн бодис үйлдвэрлэх, экспортлох, импортлоход Зөвлөлөөс зохих дүгнэлт гаргуулж төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авах;

4/ химийн хорт бодис үйлдвэрлэхэд мэргэжлийн мэдлэг, дадлагатай 18-аас дээш настай хүнийг ажиллуулах.

8 дугаар зүйл. Химийн хорт бодис хадгалахад тавих үндсэн шаардлага

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт бодис хадгалахад дараахь шаардлагыг биелүүлнэ:

1/ химийн хорт бодисыг зориулалтын тусгай агуулахад тухайн бодисын онцлог шинж чанарыг нь харгалзан төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу хадгалах;

2/ химийн хорт бодис хадгалах агуулахыг химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн Засаг даргаас тогтоосон газарт байгуулах;

3/ химийн хорт бодис хадгалахдаа түүний сав, баглаа, боодол дээр нэрийг нь тод, томоор бичиж шошго зүүх;

4/ агуулахаас химийн хорт бодис алдагдвал цагдаагийн байгууллагад яаралтай мэдэгдэх;

5/ химийн хорт бодисыг түүний хорын зэрэглэл болон бусад бодистой хамт хадгалж болдоггүй шинж чанарыг харгалзан тусад нь ангилан хадгалах.

9 дүгээр зүйл. Химийн хорт бодис худалдахад тавих үндсэн шаардлага

1. Химийн хорт бодис үйлдвэрлэх, экспортлох, импортлох, ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт бодисыг худалдах эрхтэй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт бодис худалдахад дараахь шаардлагыг биелүүлнэ:

1/ химийн хорт бодис худалдах, худалдан авахдаа түүний нэр төрөл, шинж чанар, хэмжээ, зориулалт зэргийг тодорхойлж авсан, өгсөн тухай баримт үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулах;

2/ худалдсан болон худалдан авсан химийн хорт бодисын тухай ашиглалт, зарцуулалтын тайланд тусгах;

3/ химийн хорт бодисыг тусгай цэгээр дамжуулан хүнсний болон бусад төрлийн бараа, бүтээгдэхүүнээс тусад нь зөвхөн химийн хорт бодис ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад худалдах;

4/ онцгой хортой химийн бодис худалдах болон худалдан авахад төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авах.

10 дугаар зүйл. Химийн хорт бодис тээвэрлэхэд тавих үндсэн шаардлага

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт бодис тээвэрлэхэд дараахь шаардлагыг биелүүлнэ:

1/ химийн хорт бодисыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх;

2/ химийн хорт бодис тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тусгай сэрэмжлүүлэх тэмдэг тавих;

3/ химийн хорт бодис тээвэрлэхдээ асгарах, хагарч хэмхрэхээс сэргийлэн зориулалтын сав, баглаа, боодол, хайрцагт хийж, түүн дээр нэр төрөл, шинж чанарыг нь тодорхой бичих;

4/ галын аюултай, тэсрэмтгий онцгой хортой химийн бодисыг цагдаагийн байгууллагатай урьдчилан тохиролцож тогтоосон замаар тэдгээрийн хяналтын дор тээвэрлэх;

5/ химийн хорт бодис тээвэрлэсний дараа тээврийн хэрэгслийг цэвэрлэж, ариутган хоргүй болгох.

2. Химийн хорт бодисыг хүн, мал, амьтан болон бараа, бүтээгдэхүүнтэй хамт тээвэрлэхийг хориглоно.

11 дүгээр зүйл. Химийн хорт бодис устгахад тавих үндсэн шаардлага

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт бодисын хаягдал, ашиглалтын шаардлага хангахгүй болсон химийн хорт бодис устгахад дараахь шаардлагыг биелүүлнэ:

1/ химийн хорт бодисын хаягдал, ашиглалтын шаардлага хангахгүй болсон химийн хорт бодисыг устгахад тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны болон эрүүл ахуйн байцаагчаас дүгнэлт гаргуулан аймаг, нийслэлийн Засаг даргаас зөвшөөрөл авах;

2/ онцгой хортой химийн бодисыг устгахад Зөвлөлөөс дүгнэлт гаргуулж төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авах;

3/ химийн хорт бодисын хаягдал, ашиглалтын шаардлага хангахгүй болсон химийн хорт бодисыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд хоргүй аргаар устгах;

4/ химийн хорт бодисын хаягдал, ашиглалтын шаардлага хангахгүй болсон химийн хорт бодисыг сум, дүүргийн Засаг даргаас тогтоосон цэгт тогтоосон журмын дагуу устгах;

5/ химийн хорт бодисын хаягдал, ашиглалтын шаардлага хангахгүй болсон химийн хорт бодис устгах ажлыг байгаль орчны болон эрүүл ахуйн байцаагчийн хяналтын дор гүйцэтгэх.

12 дугаар зүйл. Химийн хорт бодисын хүлцэх хэмжээг тогтоох

Химийн хорт бодисын хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөхийг хүлцэх хэмжээг стандартаар тогтооно.

13 дугаар зүйл. Химийн хорт бодис ашиглах зөвшөөрөл олгох

1. Хортой, бага хортой химийн бодис ашиглаж үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авч бүртгүүлнэ.

2. Онцгой хортой химийн бодис ашиглаж үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч бүртгүүлнэ.

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт бодис ашиглах зөвшөөрөл авахдаа химийн хорт бодисын нэр төрөл, шинж чанар, хэрэглэх хэмжээ, зориулалтыг тодорхойлж зөвшөөрөл олгох байгууллага, албан тушаалтанд гаргаж өгнө.

14 дүгээр зүйл. Химийн хорт бодис ашиглахад тавих үндсэн шаардлага

1. Химийн хорт бодисыг ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь шаардлагыг биелүүлнэ:

1/ ашиглаж байгаа химийн хорт бодисын бүртгэл хөтөлж ашиглалт, зарцуулалтын тайланг сум, дүүргийн Засаг даргад жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор гаргаж өгөх;

2/ онцгой хортой химийн бодисыг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэж бүртгүүлэх;

3/ ажлын байранд стандартаар тогтоосон хэм хэмжээ болон байгаль орчинд эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлж химийн хорт бодис гаргахгүй байх;

4/ химийн хорт бодистой харьцах үйл ажиллагааг хөдөлмөр хамгааллын нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байранд явуулах;

5/ химийн хорт бодисыг ашиглах аж ахуйн нэгж, байгууллага өөрийн аюулгүй ажиллагааны дүрмийг боловсруулан нутаг дэвсгэрийнхээ байгаль орчны болон эрүүл ахуйн байцаагчаар хянуулах;

6/ гэнэтийн аюул, ослын улмаас химийн хорт бодисоос учирсан хохирол, хөнөөлийг арилгах арга хэмжээг зохих хууль тогтоомж, технологийн горимын дагуу яаралтай авч хэрэгжүүлэх;

7/ химийн хорт бодистой харьцаж ажиллагсдыг өөрийн зардлаар сургалтад хамруулж, химийн хорт бодистой харьцаж ажиллах

ослоос сэргийлэх гарсан осолд анхны тусламж үзүүлэх мэдлэг дадлага эзэмшүүлэх;

8/ химийн хорт бодисыг ашиглах үйл ажиллагаанд гарч болзошгүй ослоос сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар хэрэгжүүлэх.

2. Химийн хорт бодисыг шуудангаар илгээх, гадны хүнээр дамжуулах, биедээ авч нийтийн тээврийн хэрэгслээр зорчихыг хориглоно.

3. Химийн хорт бодис, бэлдмэлийг химийн зэвсгийн зориулалтаар үйлдвэрлэх, нөөцөлж хадгалах, хэрэглэх, бусдад дамжуулахыг хориглоно.

4. Химийн хорт бодисын нэр төрөл, шинж чанар, хэрэглэх зориулалт, аргачлал, заавар нь тодорхой бус бол түүнийг хэрэглэхийг хориглоно.

5. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нэр төрөл, шинж чанар, хэрэглэх зориулалт, аргачлал нь тодорхой бус химийн хорт бодисыг зайлшгүй хэрэглэх тохиолдолд өөрийн зардлаар эрх бүхий мэргэжлийн байгууллагаар тодорхойлолт гаргуулна.

15 дугаар зүйл. Химийн хорт бодисыг улсын хилээр нэвтрүүлэх

1. Зохих журмын дагуу авсан зөвшөөрөлгүйгээр химийн хорт бодисыг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

2. Химийн хорт бодисыг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих хяналтыг гаалийн байгууллага, эрүүл ахуйн хилийн хяналтын алба хэрэгжүүлнэ.

3. Химийн зэвсгийн зориулалттай химийн хорт бодисыг улсын хилээр нэвтрүүлэх, дамжуулан өнгөрүүлэхийг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

16 дугаар зүйл. Химийн хорт бодисын ашиглалтад тавих хяналт

1. Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлт, химийн хорт бодис ашиглах үйл ажиллагаанд тавих хяналтыг бүх шатны Засаг дарга, байгаль орчны болон эрүүл ахуйн байцаагч хэрэгжүүлнэ.

2. Олон нийтийн байгууллага нь хуулиар тогтоосон эрх хэмжээнийхээ хүрээнд химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль

тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавьж, санал хүсэлтээ холбогдох төрийн байгууллагад тавьж шийдвэрлүүлж болно.

3. Аж ахуйн нэгж, байгууллагын химийн хорт бодисыг ашиглах үйл ажиллагаа, химийн хорт бодисын ашиглалт, зарцуулалт болон химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль тогтоомж, журам, технологийн горимын биелэлтэд тэдгээрийн удирдлага дотоодын хяналт тавина.

17 дугаар зүйл. Химийн хорт бодисын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1. Шүүгч, байгаль орчны буюу эрүүл ахуйн байцаагч химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1/ химийн хорт бодисыг хүлээн авсан тухай холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй ашиглалт, зарцуулалтын мэдээ, тайланг гаргаж өгөөгүй буюу зориуд буруу мэдээлсэн иргэнийг 1000-3000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000 төгрөгөөр торгох;

2/ химийн хорт бодисоос учирсан хохирол хөнөөлийг арилгаж арга хэмжээг аваагүй, байгаль орчинд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэн химийн хорт бодис гаргасан иргэнийг 10000-20000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-75000 төгрөгөөр торгох;

3/ энэ хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт хориглосон үйл ажиллагаа явуулсан иргэнийг 15000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 75000-100000 төгрөгөөр торгох;

4/ химийн хорт бодисыг үйлдвэрлэх, экспортлох, импортлох, хадгалах, худалдах, тээвэрлэх, устгах болон түүнтэй харьцах ажиллахад тавих шаардлагыг зөрчсөн, эсхүл химийн хорт бодис ашиглахтай холбогдсон үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр явуулсан бол хууль бусаар олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 20000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-150000 төгрөгөөр торгох;

5/ химийн зэвсгийн зориулалттай химийн хорт бодисыг бусдад дамжуулсан, үйлдвэрлэсэн, нөөцөлж хадгалсан бол хууль бусаар олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 25000-5000

төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох.

2. Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөн бол гэм буруутай этгээдэд зохих хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хууль тогтоомжид заасан журмыг зөрчиж зөвшөөрөлгүйгээр ашиглаж байгаа химийн хорт бодисыг шаардлагатай тохиолдолд хураан авна.

18 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлүүлэх

Химийн хорт бодис ашиглахад тавих шаардлага, журам, технологийн горимыг зөрчиж хууль бус үйл ажиллагаа явуулсны улмаас бусдын эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

19 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 2 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 32 | Улаанбаатар хот

ЗАРИМ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙГ АЛБАН ТУШААЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Мижидийн Догсомжавыг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Агвааны Батбаярыг Хэнтий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МонголУлсын Ерөнхийлөгч П.ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 2 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 33 | Улаанбаатар хот

ЗАРИМ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Ёндонгийн Ринзааныг Увс аймгийн шүүхийн шүүгчээр, Агвааны Батбаярыг Хэнтий аймгийн шүүхийн шүүгчээр, Дамдинжавын Халзанг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Дашдэлэгийн Улааныг Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчээр, Гомбосүрэнгийн Амарыг Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчээр, Оросоогийн Зандраагийн Нийслэлийн дүүргийн 7 дугаар шүүхийн шүүгчээр тус тус томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П.ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 2 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 34 | Улаанбаатар хот

ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Дашдэлэгийн Улааныг Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчээр 6 жилийн хугацаагаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П.ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 2 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 37 | Улаанбаатар хот

Г.ДАШТҮДЭВИЙГ АЛБАН ТУШААЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын санал болгосноор Гонгорын Даштүдэвийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч П.ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 2 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 38 | Улаанбаатар хот

Ч.ДАШНЯМЫГ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГААР ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын санал болгосноор Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн даргаар Чоймжуурын Дашнямыг томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П.ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 2 дугаар сарын 23-ныөдөр | Дугаар 41 | Улаанбаатар хот

БАТЫН ГООШИД МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ГАВЬЯАТ ЭМЧ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Эрүүл мэндийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж элэг, цөсний өвчний мэс заслын эмчилгээний аргыг боловсронгуй болгож олон улсын түвшинд хүргэх, мэс засалчдыг бэлтгэж мэргэшүүлэх, мэс заслын тусламжийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Анагаах ухааны их сургуулийн мэс заслын хүрээлэнгийн захирал Батын Гоошид Монгол Улсын Хүний гавьяат эмч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П.ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 3 дугаар сарын 16-ны өдөр — Дугаар 50 — Улаанбаатар хот

ЗАРЛИГТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

"Комиссын бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1992 оны 118 дугаар зарлигийн "Монгол Улсын Ерөнхий сайдын орлогч бөгөөд Засаг захиргааны сайд" гэснийг "-Монгол Улсын шадар сайд", "-Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газрын дарга" гэснийг "Монгол Улсын Тагнуулын төв газрын дарга" гэж өөрчилж,"-Монгол Улсын Тагнуулын төв газрын дарга" гэсний дараа "-Монгол Улсын Тагнуулын төв газрын цагаатгалын тасгийн дарга", "-ЦАУЗБУК-ын дэргэдэх улс төрийн талаар хэлмэгдэгсдийн судалгааны төвийн захирал" гэж нэмж, "-Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны дарга" гэснийг хассугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч — П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 3 дугаар сарын 17-ны өдөр — Дугаар 51 — Улаанбаатар хот

ЦЭРГИЙН ДЭЭД ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Зэвсэгт хүчний ерөнхий штабын даргын орлогч хурандаа Чанцалын Магсарт хошууч генерал цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч — П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

995 оны 3 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 52 | Улаанбаатар хот

ЦЭРГИЙН ДЭЭД ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Хилийн цэргийг удирдах газрын дэд дарга хилийн цэргийн ...збын дарга хурандаа Пүрэвийн Дашид хошуучлал генерал цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1995 оны 3 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 03 | Улаанбаатар хот

Монгол Улсын Газрын тухай хууль болон Иргэний хуультай холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны дүгнэлтийг 1995 оны 3 дугаар сарын 9-ний өдөр Төрийн ордны 251 дүгээр тасалгаанд үйлдэв. Цэцийн хуралдааныг гишүүн Г. Нямдоо даргалж гишүүдэд Л. Баасан, С. Жанцан, Д. Чилхаажав /илтгэгч/, Ч. Энхбаатар нар оролцов. Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргаар цэцийн нарийн бичгийн дарга Цэндээхүү, маргагч талыг төлөөлж Монгол Улсын иргэн Д. Ламжав, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц. Шаравдорж, С. Нямзагд нар тус тус оролцов.

Монгол Улсын иргэн Д. Ламжав Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөл, түүнд холбогдуулан өгсөн тайлбартаа доорхи асуудлуудыг тавьж байна.

Монгол Улсын Газрын тухай хуулиудаар иргэдийнхээ газар өмчлөх эрхийг хуулиар хамгаалалгүй орхисон болон Улсын Их Хурлаас баталсан Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хууль болон Үндсэн хуулийн хавсралт хуулийн дараахь заалтуудыг зөрчиж байна. Үүнд:

1. "Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн ... Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд заасан хуулиудыг Улсын Бага Хурлаас тогтоосон хугацаанд 1993 онд багтаан гаргана" гэсэн заалтыг зөрчиж байна. Учир нь газар бол үл хөдлөх хөрөнгөөр бөгөөд иргэд газрыг өмчлөх эрхтэй болсноор хувийн өмч эдийн засгийн үндсэн баталгаагаар хангагдсан билээ. Иймхүү өмчлөгчийн эрхийг хамгаалах, Үндсэн хуульд заасан хэмжээнд хязгаарлах, 1990 онд хуульчлан батлагдсан газар өмчлөх эрхийг баталгаажуулсан Үндсэн хуульд заасан хэмжээнд хязгаарлахын тулд юун түрүүн Газрын тухай хуулийг гаргах ёстой байсан бөгөөд Хавсралт хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан ёсоор Улсын Бага Хурлын тогтоолын хавсралтад:

"10. Монгол Улсын Үндсэн хуульд заасан нэн тэргүүнд шаардлагатай дараахь хуулиудыг батлан гаргах" гэсэн хэсэгт Газрын тухай хуулийг 1992 оны 2 дугаар сарын 7-нд багтаан гаргахаар заажээ. Энэ үүрэг тухайлбал Газрын тухай хуулийг өмнө тэмдэглэсэн агуулгаар 1993 онд багтаан батлах үүрэг Улсын Их Хуралд шилжсэн билээ. Гэтэл Улсын их Хурлаас 1994 оны эцэст батлан гаргасан, Газрын тухай болон Иргэний хуулийн нь агуулгын хувьд иргэд газар өмчлөх эрхийг дахин устгаж байгаа учир хамгаалалгүй орхисон ба хугацааны хувьд бүтэн 2 жил гаруй хугацаа алджээ.

2. Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн ... Төр нь ... хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална гэсэн заалтыг зөрчиж байна. Монгол Улсын иргэд Монгол Улсдаа газар өмчлөх эрхтэйг Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн атал энэ эрхийг мөн чанартаа устгаж байгаа учраас хамгаалах аргагүй байдалд хүрсэн байна. Иймхүү Газрын тухай хуульд Монгол Улсын Иргэний газар өмчлөх эрхийг хамгаалахгүй орхисон болон үүнийгээ Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтаар баталгаажуулсан явдал Үндсэн хуулийн энэ заалтыг зөрчиж байна.

3. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, ... өмчлөх ... эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно гэсэн заалтыг зөрчиж байна. Учир нь Монгол Улсын иргэн үл хөдлөх хөрөнгө тухайн тохиолдолд газрыг ч өмчлөх эрхтэй болгөөд энэ эрхээ баталгаатай эдэлнэ гэж Үндсэн хуульд давхар заасаар байтал энэ эрхийг Газрын тухай хуульд хамгаалахгүй орхисон болон энэ эрхийг ямар нэг хугацаагаар устгасан тухай Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан нь Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчиж байна.

4. Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэдэд өмчлүүлж болно" гэсэн заалтыг зөрчиж байна. Учир нь хэрвээ Монгол Улсын иргэн хүсвэл газар өмчлөх эрхтэй болгөөд зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлэх хязгаарлалтыг хангахын тулд газар төрийн хамгаалалтад байна гэсэн Үндсэн хуулийн заалтын дагуу газрын аливаа хөдөлгөөнийг төрөөс бүртгэн хянах ёстой юм. Түүнээс гадна Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар ... төрийн өмч мөн" гэсэн заалтаар давхар өмчлөл гэсэн хууль

зүйн талаасаа утгагүй зүйл тусгагдаагүй юм. Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дээрх заалт чухамхүү ийм утга санаагаар батлагдсан болохыг Үндсэн хуулийн "Хүний эрх, эрх чөлөө" бүлэг дэх 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт ч давхар нотолж байгаа юм.

Улсын Их Хурал бол хууль тогтоох дээд байгууллага болохынхоо хувьд газар өмчлөх эрхийг устгасан хууль гаргах эрхтэй боловч үүнийгээ эрх зүйн соёлтой хийх үүрэгтэй билээ. Үүний тулд Үндсэн хуулинд иргэний өмчийн эрхэнд халдана гэсэн утга бүхий оорчлолт оруулахаас эхлэх ёстой гэжээ. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн С. Нямзагд, Ц. Шаравдорж нар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбар үндэслэлдээ:"...Иргэн Д.Ламжавын Үндсэн хуулийн цэцэд гаргасан гомдол, өргөдөлд дурдсан үнэлэлт дүгнэлтийг зөвшөөрөх хууль зүйн ямар ч үндэсгүй гэж үзэж байна. ... Хамгийн их бодож болоовсруулж байж, буурь суурьтай шийдвэрлэх асуудал бол газрыг хувь хүнд өмчлүүлэх эсэх тухай асуудал юм. Үндсэн хуульд Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба Улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно" гэснийг хууль зүйн хувьд хэрхэн ойлгохоос эхлэх нь зөв болов уу?

Иргэн Д. Ламжав дээрх заалтыг тайлбарлахдаа иргэнд газар өмчлүүлэхийг хоёрдмол санаагүй шийдвэрлэсэн гэснийг бид зөвшөөрөх боломжгүй гэж үзэж байна.

Үндсэн хуульд " ... газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлнэ" гээгүй, харин "... өмчлүүлж болно" гэсэн шүү дээ. Энэ 2 үг утга агуулгаараа ихээхэн ялгаатайг мартаж болохгүй. Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн "төслийг энэ удаа Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцээгүй нь нэгдүгээрт, газрын гол гол зарилцаа батлан гаргасан бусад хуулиудад багтаж тодорхойлогдсон, хоёрдугаарт газрыг иргэнд өмчлүүлэх нийгэм, эдийн засаг , сэтгэл зүйн бэлтгэл манай оронд хараахан бүрэлдээгүй, гуравдугаарт олон тумний санаа бодлыг үндэс болгож Улсын Их Хурлын чуулган энэ асуудлыг хойшлуулсан нь зөв гэж үзсэн олсон зүй зохистой шийдвэр болсон гэж үзэж байна.

Улсын Их Хурал ийм шийдвэр гаргаснаар Үндсэн хуулийг өөрчөөгүй богөөд өөрийн эрх хэмжээний хүрээнд ажилласан гэж үзэж байна. Улсын Их Хурал "иргэнд газар өмчлүүлэх тухай хууль" гаргахыг хойшлуулж, энэ асуудалд хандах бодлогоо тодорхойлсон

болохоор дараа нь гарсан зарим хуульд орсон тодорхой заалтыг ч дээрх нөхцөл байдалтай холбоотойгоор авч үзэж ойлгох ёстой.

Тухайлбал Улсын Их Хурлын 1994 оны намрын чуулганаар хэлэлцэн батлагдсан "Иргэний хуулийн" 100 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх журмыг хуулиар тогтоох хүртэл /үүнийг бид онцлон/ энэ бүлэгт заасан "газар өмчлөгч" гэдгийн дор "төр"-ийг ойлгоно гэж заасан юм. Иргэний хуульд иймэрхүү заалт оруулсан нь хуулийг хэрэглэгч болон жирийн иргэдэд түүнийг нэг мөр ойлгоход туслах зорилго агуулсныг хэлэх нь зүйтэй болов уу.

Улсын Их Хурал нь эрх хэмжээнийхээ хүрээнд аливаа асуудлыг тухайлбал, хуулийн төслийг хянан шийдвэрлэхдээ тухайн хуулиар болон асуудлын талаар шийдвэр гаргах нийгэм, эдийн засаг, улс төрийн болон бусад нөхцөл байдал бүрдээгүй, эсвэл хэрэгжих боломжгүй, эх орон ард түмний нийтлэг эрх ашиг, сонирхолд нийцэхгүй байх зэрэг шалтгаан байвал хэлэлцэхийг орхих, хойшлуулах, дахин боловсруулахыг холбогдох байгууллага, хүмүүст үүрэг болгож буцаах эрхтэй. Энэ л бүрэн эрхийн хүрээнд дээрх төсөлд хандсан болно.

Дээрх байдлаас үзэхэд Иргэний хуулийн энэ заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэсгүй. Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ дагуу шийдвэрлэсэн асуудалд хөндлөнгөөс оролцож, ийм хуулийг заавал гаргах ёстой, эсвэл хуульд ийм заалт заавал орох ёстой гэж хүчээр зүтгэх нь эрх зүйн соёлгүй, бүдүүлэг явдал гэж ойлгожбайна.

Аливаа хууль бус асуудлыг Улсын Их Хуралд тулган хүлээлгэх тулган шийдвэрлүүлэх гэсэн оролдлогыг таслан зогсоох ёстой.

Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дугаар заалт манай улсад хэрэгжиж байгаа болоод газрыг иргэдэд өмчлүүлэх асуудал нь Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "... газрыг зөвхөн Монгол Улсын иргэдэд өмчлүүлж болно" гэж заасны дагуу /өмчлүүлж болно гэдэг нь агуулгаараа өмчлүүлж ч болох өмчлүүлэхгүй ч байж болох/ манай улсад нээлттэй үлдэж байгаа юм. Үндсэн хуулийн хавсралт хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "... үүнтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд заасан хуулиудыг Улсын Бага Хурлаас батлагдсан хугацаанийн дагуу батлан гаргана" гэсэн нь үнэн. Гэтэл Үндсэн хуулийн 5, 6 дугаар зүйлүүдийг анхааралтай уншиж үзвэл "иргэнд газар өмчлүүлэх асуудлыг

агцхүү хуулиар зохицуулна" гэсэн болон ийнэрхүү агуулгатай үйл, заалт байхгүй байна" гэжээ.

Газрын тухай хууль болон Иргэний хуулийг хэлэлцсэн, Монгол лсын Их Хурлын хуралдааны протоколыг судлан үзэхэд Үндсэн уулийн цэцэд хандсан дээрх асуудлуудаар Үндсэн хууль зөрч-эн эсэхтэй нь холбогдож маргаан гарч байсан байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн төслийн элэлцүүлгийн үед 1994 оны 11 дүгээр сарын 17-ны хуралдаан дээр лсын Их Хурлын гишүүн Б. Чимэд хэлэхдээ " ... Үндсэн хуулийн элэн байгаа заалтын учрыг бид янз бүрээр мушгин тайлбарлаж олохгүй. Яагаад гэвэл Үндсэн хууль бол нэг намын сонирхлын уль биш, аль ч намын сонирхлын хууль бишээ. Бүх намуудбүх улс рийн хүчний балансыг илэрхийлдэг хууль. Ердийн хууль буюу сгал хууль бол тухайн ялсан улс төрийн хүчний сонирхлыг дагаж рч ирдэг, зарим талаараа оросоос орчуулбал дур зоргоорж болдог уль байж болдог. Тэрийг Үндсэн хуулиар хязгаарладаг ёстой юм. ндсэн хуулиа буруу тайлбарлаад мушгиад байх юм бол тэр Үндсэн уль гэж байхын хэрэггүй болж байгаа юм. ... Хуулиа элэлцүүлээд өмчлүүлэх бэлтгэлийг 5 жилийн дотор хангах, юм йдээгүй байж бэлтгэлийг хангана гэж байхгүй ..." гэжээ.

Иргэний хуулийн хэлэлцүүлгийн үед 1994 оны 11 дүгээр сарын -ны хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн Ж. Бямбадорж лэхдээ "Нямдоржийн саналаар /... иргэнд газар өмчлүүлэх тухай уль гартал "газар өмчлөгч" гэснийг төр гэж ойлгоно .../ ингээд ж болно. Энэ бол санал байх гэхдээ энэ үр дүнд хүрэхгүй, би энэ уудлыг санаачлахгүй, санаачлах хүн байх байх. Юу гэхлээр цэц эр очоод Үндсэн хуулинд төр иргэн хоёрт хоёуланд нь өмчлүүлнэ сээр байтал дан ганц төр гэвэл хэлчихвэл Үндсэн хуулийн заалт рчжээ гээд энэ заалт унана ..." гэжээ.

Мөн өдрийн хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн Ц. вуусүрэн хэлэхдээ "... иргэнд газар өмчлүүлэх тухай хууль ртал тэртээ тэргүй төр газрын эзэн гэдэг нь ойлгомжтой. Хэрвээ мдоржийн хэлж байгаагаар ерөөсөө газар өмчлөгч гэдгийг нь саад эзэмшиж ашиглаж болгоно гэвэл энэ Үндсэн хуультай рчилдөнө..." гэжээ.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн төслийг лэлцэх үеэр МАХН-ын удирдах зөвлөл, Улсын Их Хурал дахь АХН-ын бүлэг Улсын Их Хуралд албан ёсоор санал оруулж,

Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлгээс Улсын Их Хуралд оруулсан санал дүгнэлтэд "...Газрыг иргэдэд өмчлүүлэх тухай хуулийг одоо гаргахгүй бол Үндсэн хуулийн энэ тухай заалтаас ухарсан хэрэг болох уу гэсэн асуулт гардаг. Энэ талаар ухарч нөцсан юм байхгүй гэж хариулах бүрэн үндэс бий ... Газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно... гэж Үндсэн хуульд заасан нь нэг талаар газрыг ч өмчлүүлж ч болох, негоо талаар өмчлүүлэхгүй ч байж болох утга санааг адилхан илэрхийлж байгаа билээ.

... Монгол Улсад газрыг хуьд өмчлүүлэх бодит нөхцөл бололцоо бүрдээгүй байна.

"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийг гаргах шаардлагагүй гэж үзэж байна" гэжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбатаас Улсын Их Хуралд хандаж гаргасан илгээлтдээ "... Үндсэн хуульд газрыг иргэдэд өмчлүүлж болно гэж заасан нь үндэсний ашиг сонирхолд бүрэн нийцэж байгаа юм. Зарим нам хэсэг бүлгийн үзэл баримтлал саналыг үндэсний ашиг сонирхлоос, түүнийг хуульчлан баталгаажуулсан Үндсэн хуулиас дээгүүр тавих эрх бидэнд байхгүй ..." гэжээ.

Иргэн Д. Ламжав Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцох тайлбарлахдаа: Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтуудыг Газрын тухай хуулиудаар иргэдийнхээ газар өмчлөх эрхийг хуулиар баталгаажуулаагүй орхисон болон Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт зөрчсөн гэсэн нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзаж байна. Үндсэн хуулиар шийдчихсэн асуудлыг шийдэгдээгүй мэтээр Улсын Их Хурал үзэж байгаа нь харамсалтай байна гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц. Шаравдорж Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцож хэлэхдээ: "... Монгол Улсын иргэний газар өмчлөх эрхийг хязгаарласан, хойшлуулсан зүйл байхгүй. Газар өмчлөх эрх нээлттэй байгаа бөгөөд иргэн, газар өмчлүүлэх тухай хууль гартал л иргэдийн газар өмчлөх эрх хязгаарлагдмал байгаа гэж үзэж болно.

Улсын Их Хурал иргэнд газар өмчлүүлэх асуудлыг хойшлуулахдаа соёл иргэншлийн асуудлыг болон Монголын төрөсөнх түүхэнд газрыг өмчлүүлж байсан явдал байхгүй байгаа

Одоогийн дагаж мөрдөж байгаа Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан ёсоор Монгол Улсын иргэд газар өмчлөх үндсэн эрхтэй болохыг Цэцийн хуралдаанд явцад санал нэгтэй нотолсныг тэмдэглэж байна.

Улсын Их Хурал хууль тогтоох эрх мэдлийнхээ дагуу Монгол Улсын иргэнд газар омчлуулэх асуудлыг тусгай хуулиар зохицуулахаар шийдвэрлэхдээ иргэний газар өмчлөх эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, Газрын болон Иргэний хуульд заасныг үндэслэсэн байна.

Энэ нь Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд омчлуулж болно", Газрын хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Иргэдэд газар омчлуулэхтэй холбогдсон харилцааг зохих хуулиар зохицуулна" гэсэн заалтуудаар батлагдаж байна.

Иймд Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Монгол Улсын иргэнд газар омчлуулэх журмыг хуулиар тогтоох хүртэл энэ бүлэгт заасан "газар өмчлөгч" гэснийг "төр" гэж сэлгоно" гэсэн заалтыг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын иргэнд газар омчлуулэх тухай асуудлыг хуулиар зохицуулах тухай заалт Монгол Улсын Үндсэн хуульд байхгүй бөгөөд Улсын Бага Хурлаас 1993 онд батлаан батлан гаргах хуулиудын жагсаалтад Монгол Улсын иргэнд газар омчлуулэх тухай хууль бий. Монгол Улсын Газрын тухай хууль орсон байна. Иймд Улсын Их Хурал Үндсэн хуульд заасан Иргэний газар өмчлөх эрхийг үгүйсгэсэн, түүнчлэн Үндсэн хуулийн хэвлэлд хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Газрын тухай хуулиудаар иргэдийнхээ газар өмчлөх эрхийгхуулиар хамгаалалгүй орхисон нь Үндсэн хуулийн 16-р зүйл, Үндсэн хуулийн бусад заалтыг зөрчнө гэсэн иргэн Д. Ламкавын гомдлын шаардлага тодорхойгүй байгаа учраас иргэн Д. Ламжавын энэ талаарх хүсэлтийг хүлээн авах үндэслэлгүй тул Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс магадлал гарган шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэв.

Монгол улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон дүгнэлт гаргах нь:

Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2, дугаар зүйлийн 3, 16 дугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн Хавсрал хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудыг зөрчөөгүй байна гэж үзсүгэй.

ДАРГА
ГИШҮҮД

Г. НЯМДОО
Л. БААСАН
С. ЖАНЦАН
Д. ЧИЛХААЖАВ
Ч. ЭНХБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 2 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 25 | Улаанбаатар хот

Ажилгүйдэл, ядуурлын байдалд улсын хэмжээний үзлэг явуулах тухай

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 1995 оны ндсэн чиглэлийн 22 дахь хэсэгт заасан зорилтыг хэрэгжүүлэх орилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ажилгүйдэл, ядуурлын байдалд энэ оны 4 дүгээр сарын 5-нд багтаан энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан журмын агуу улсын хэмжээний үзлэг явуулж дүнг энэ оны эхний хагаст асгийн газарт танилцуулахыг Хүн амын бодлого, хөдөлмөрийн ам /Э. ГОМБОЖАВ/, Улсын статистикийн газар /Б. ЦЭНД-ЮУШ/-т даалгасугай.

2. Аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/ ажилгүйдэл, ядуурлын байдалд үзлэг явуулж дүнг нь 5 гаар сарын 1-ний дотор Хүн амын бодлого, хөдөлмөрийн яаманд үүлэхийн хамт хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх, килгүйдэл, ядуурлыг бууруулах талаар орон нутагт зохион йгуулсан ажил, үр дүнгийн талаархи тайланг жил бүр 12 гаар сарын 15-ны дотор Хүн амын бодлого, хөдөлмөрийн яаманд үүлж байсугай;

б/ хүн амын ажилгүйдэл, ядуурлын байдалд хийсэн үзлэгийн нг үндэслэн орон нутгийнхаа нөөц боломжийг ашиглан жижиг, нд үйлдвэр хөгжүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, имсгэнэ тариалах, байгалийн баялаг ашиглах зэргээр энэ тогтоо-ын 2 дугаар хавсралтад зааснаас цөөнгүй ажлын байр шинээр й болгох, иргэд хувиараа хөдөлмөр эрхлэх, өрхийн аж ахуй гжүүлэх хөдөлгөөнийг дэмжиж өрнүүлэх тодорхой ажил зохион йгуулж, энэ оны эцэс гэхэд ажилгүйдлийг тухайн аймаг, нийс-лийн хөдөлмөрийн нөөцийн 5 хувиас хэтрүүлэхгүй байх арга мжээг авсугай;

в/ ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улам эрчимжүүлж, олон улсын санхүүгийн байгууллагаар хандивлагч орнуудын зээл, тусламж, жижиг үйлдвэр хөгжүүлэх болон ажил эрхлэлтэд туслах сангаас орон нутагт хуваарилан олгож байгаа хөрөнгийг ашиглаж ажилгүй, ядуу иргэдийг мэлжуулах, зам, гүүр, барилга байшин засварлах, худаг малтах, хашаа барих, хадлан тэжээл бэлтгэх зэрэг олны хүч шаардагдсан цаг үеийн ажилд тэднийг эргэн оролцуулах замаар орхийн орлогыг нь нэмэгдүүлэхэд тус дэмжлэг үзүүлж ажилласугай.

Монгол Улсын Ерөнхий сайд П. ЖАСРАЙ

Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд Э. ГОМБОЖАВ

Засгийн газрын 1995 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АЖИЛГҮЙДЭЛ, ЯДУУРЛЫН БАЙДАЛД УЛСЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Үзлэгийн зорилго нь УИХ-ын 1994 оны 82 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын эдийн засаг нийгмийн хөгжлийн 1995 оны үндсэн чиглэл"-ийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлж, ядуу амьдралтай өрх, иргэд, хөдөлмөр эрхлээгүй байгаа хүн ам, ажилгүйчүүдийн бүртгэлийг үнэн зөв гаргах, ядуурал, ажилгүйдлийн шалтгааныг нарийвчлан тогтоох, хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлж орхийн орлогыг нэмэгдүүлэх арга зам, нөөц бололцоог судлан тогтооход оршино.

Хоёр. Зохион байгуулалтын асуудал

2. Аймаг нийслэлд улсын үзлэгийг явуулах, ур дүнг гаргах, тайлагнаж, үзлэгийн мөрөөр авах арга хэмжээг төлөвлөх үүрэг бүхий орон нутгийн комиссыг аймаг, нийслэлийн Засаг даргын орлогчоор ахлуулан аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд ажиллуулна.

3. Орон нутгийн комисс нь сум, дүүрэг, баг, хороодод үзлэг зохион байгуулах ажлыг хариуцах бөгөөд засаг захиргаа, олон нийтийн байгууллагын ажилтнуудаас бүрдэнэ.

4. Үзлэг зохион байгуулах ажилд баг, хорооны Засаг дарга, хэсгийн ахлагч, байрын олон нийтийн зөвлөлийн дарга, идэвхтэн сонгуульчныг оролцуулна.

5. Улсын үзлэг зохион байгуулах ажлыг Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам, Улсын статистикийн газар зохион байгуулалт, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

6. Үзлэг явуулахад хэрэглэгдэх бүртгэл, судалгаа, мэдээний маягтын загварыг Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам боловсруулан гаргаж орон нутагт хүргүүлнэ.

Гурав. Улсын үзлэг явуулах, мэдээ тайлан гаргах

7. Ажилгүйдэл, ядуурлын байдалд хийх улсын үзлэгийн зорилго, ач холбогдол, үзлэгийг зохион байгуулах арга, хэлбэрийн талаар тов, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилж, иргэдийг идэвхтэй оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээг урьдчилан авсан байна.

8. Өрхийн бүртгэлийг үндэслэн хөдөлмөрийн насны буюу хөдөлмөрийн чадвартай боловч ажил, хөдөлмөр эрхлээгүй хүмүүс, гүүнчлэн ядуу айл, өрхийн хүмүүстэй нэг бүрчлэн уулзаж, амьдрал байдалтай нь танилцах замаар үзлэг явуулна.

9. Үзлэгийн явцад тухайн айл өрхөд амьдарч буй хөдөлмөрийн насны буюу хөдөлмөрийн чадвартай боловч ажил, хөдөлмөр эрхлээгүй хүний ажилгүй байгаа бодит шалтгааныг тогтоох зорилгоор нарийн бүртгэл судалгаа гаргана.

10. Хөдөлмөрийн насны буюу хөдөлмөрийн чадвартай бөгөөд хөдөлмөрийн биржид бүртгэгдэн ажил идэвхтэй эрж байгаа, зорийгоо болон гэр бүлээ тэжээх орлого нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэхгүй байгаа хүмүүсийг ажилгүйчүүдийн бүртгэл мэдээнд хамруулна.

11. Албан ёсоор ажил эрхлээгүй боловч хувийн малаа маллах, ганзагын наймаа хийх, гэрээрээ жижиг үйлдвэрлэл эрхлэх, тариа, гогоо тариалах, үйлчилгээний цэг ажиллуулах зэргээр Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш орлоготой хүмүүсийг хувиараа хөдөлмөр эрхлэгчид гэж үзнэ.

12. Тодорхой хөдөлмөр эрхлээгүй, сарын орлого нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага боловч ажил хөдөлмөр эрхлэхийг хүсэхгүй байгаа хүмүүсийг "ажилгүй хүн" гэж үзэхгүй, харин хөдөлмөр эрхлээгүй хүн гэж үзнэ.

13. Ядуу гэж бүртгэгдсэн айл, өрх бүрийн орлого, орлого олох боломжтой өмч хөрөнгө, гэр бүлийн гишүүдийн чадавхи, амьдралын байдалтай биечлэн танилцсаны үндсэн дээр жинхэнэ ядуу амьдралтай өрх, иргэдийг тодорхойлж, бүртгэнэ.

14. Ядуу өрх, иргэдийг тодорхойлохдоо Засгийн газраас тогтоосон амьжиргааны баталгаат доод түвшинг үндсэн шалгуур болгоно. Гэхдээ өрхийн орлогод цалин, тэтгэвэр, тэтгэмж зэрэг албан ёсны мөнгөн орлогыг тооцохын хамт орлого олж болох үндсэн хөрөнгө, түүнээс олох орлого, тухайлбал хувийн мал, газар тариалан, бусад аж ахуй, арилжаа наймаа, хувьцааны ашиг зэргээс олох албан бус орлогыг харгалзан амьдралаа тэтгэх боломжийг тооцож үзнэ.

15. Ядуу өрх иргэдийг тодорхойлох шалгуурыг тогтооход орон нутгийн онцлогийг харгалзан хэдэн малтай, хичнээн хэмжээний орлоготой байхад амьдралын наад захын хэрэгцээгээ хангах боломжтойг аймгийн зөвлөл тооцож саналаа бэлтгэж үзлэгийн дүнтэй хамт ирүүлнэ.

16. Ядуу, нэн ядуу өрх, иргэдийг тодорхойлоход орлогоос гадна өрхийн гишүүдийн байдал, албан ёсны асран хамгаалах хүнтэй эсэх зэрэг нэмэлт шалгууруудыг хэрэглэж болно. Хоол хүнс, орон байр, хувцасны хүрэлцээ хангамж, эрүүл мэндийн байдал, хөдөлмөрийн чадвар зэрэг амьдралын бүхий л дүр төрхөөрөө нэн дорой байдалд аж төрж буй өрх, иргэдийг нэн ядуу өрх, иргэдэд хамааруулж тэдгээрийн дотроос орох оронгүйгээс тэнүүчлэн яваа болон байнга гуйлга гуйж амиа зогоож байгаа нийгмийн асрамжид авах зайлшгүй шаардлагатай иргэдийг тусад нь бүртгэнэ.

17. Орон нутгийн комиссууд үзлэгийн дүн, тайланг 5 дугаар сарын 1-ний дотор Хүн амын бодлого, хөдөлмөрийн яаманд ирүүлнэ. Үзлэг явуулсан тухай тайланд ядуурал, ажилгүйдлийн гол шалтгаан, ажилгүйдэл ядуурлыг бууруулах талаар тухайн орон нутагт

цаашид авах арга хэмжээний тухай саналыг тодорхой тусгасан байна.

18. Орон нутгийн комисс үзлэгийн мөрөөр ядуурал, ажилгүйдлийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган аймаг, нийслэлийн Засаг даргаар батлуулна.

19. Ядуурал ажилгүйдлийн байдалд улсын хэмжээнд явуулсан үзлэгийн дүнг Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам, Улсын статистикийн газар хамтран гаргаж дүгнэлт, саналын хамт энэ оны эхний хагаст багтаан Засгийн газарт танилцуулна.

20. Улсын үзлэг явуулахад шаардагдах зардлыг орон нутгийн төсвөөс гаргана.

Засгийн газрын 1995 оны 25 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

1995 ОНД АЖИЛГҮЙЧҮҮДЭД ЗОРИУЛАН ОРОН
НУТГИЙНХАА НӨӨЦИЙГ ДАЙЧЛАН ШИНЭЭР БИЙ
БОЛГОХ АЖЛЫН БАЙРНЫ ТОО

N	Аймаг, нийслэл	Орон нутгийн нөөц дайчлан шинээр бий болгох ажлын байрны тоо
1	Архангай	1260
2	Баян-өлгий	1530
3	Баянхонгор	700
4	Булган	500
5	Говь-алтай	660
6	Дорноговь	200
7	Дорнод	870
8	Дундговь	330
9	Завхан	1295
10	Өвөрхангай	970
11	Өмнөговь	200
12	Сүхбаатар	630
13	Сэлэнгэ	300
14	Төв	1600
15	Увс	500
16	Ховд	410
17	Хөвсгөл	1650
18	Хэнтий	810
19	Дархан-уул	300
20	Улаанбаатар	2790
21	Орхон	340
22	Говьсүмбэр	160
	Бүгд	18015

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 2 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 27 | Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1994 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 178 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтыг энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтын ёсоор тус тус шинэчлэн батлсугай.

2. Тогтоолын 10 дугаар зүйлийн "в" заалтыг "в", "г" заалт болгон дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

в) төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламж, угсрагдсан тоног төхөөрөмжийг Өмч хувьчлалын комиссын шийдвэрээр худалдаж, түүний орлогыг Өмч хувьчлалын санд оруулж байх;

г) төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын техник хэрэгсэл, аж ахуйн эд хогшлыг худалдсаны орлогыг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын дансанд оруулж, хөрөнгө оруулалтын эх үүсвэр болгон ашиглаж байх;"

3. Сангийн яам /Э. БЯМБАЖАВ/-д даалгах нь:

а) "Өмч хувьчлалын комиссын шийдвэрийн дагуу хувьчлагдсан, түүнчлэн татан буугдсан буюу дампуурсан, шинээр байгуулагдсан, нэрээ өөрчилсөнтэй нь холбогдуулан төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын харьяалал, төрийн төлөөллийг өөрчлөх асуудлыг холбогдох яам, тусгай газар болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай тохиролцон шийдвэрлэж бүртгэн, дүнг хагас жил тутам Засгийн газарт танилцуулж байсугай;

б) төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын тайлан, тэнцэл гаргах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд нь дүн шинжилгээ хийх, санхүүгийн баримтын шалгалт хийх үүрэг бүхий нягтлан бодох бүртгэлийн хөндлөнгийн хяналтын системийг

1995 оны 1 дүгээр улиралд багтаан бий болгох арга хэмжээг авсугай.

4. Төрийн өмчийн оролцоогүй, хувьчлагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагын дотоод зохион байгуулалтыг өөрчлөхийн хамт урт болон богино хугацааны бизнес төлөвлөгөөтэй, хөндлөнгийн буюу мэргэжлийн хяналттай ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч мөрдүүлэхийг Засгийн газрын Өмч хувьчлалын комисс (Л. ЭНЭБИШ)-т даалгасугай.

5. Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамны Залуучуудын газрын харьяа соёл үйлчилгээний "Залуус" төв, Усан спорт, сургалтын бассейны хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс тэдгээрийн орлогоос давсан зарлагыг хянан тооцож, залуучуудын байгууллагын мэдэлд байсан өмч, хөрөнгийн эзэмшлийн асуудлыг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд төсвөөсөө санхүүжүүлж байхыг нийслэлийн Засаг дарга (Ц. БААСАНЖАВ)-д даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1992 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 28 дугаар тогтоолын 9 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд П. ЖАСРАЙ

Сангийн сайд Э. БЯМБАЖАВ

Засгийн газрын 1995 оны 27 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БОЛОН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД ХАРЬЯАЛАГДАХ ТӨРИЙН ӨМЧИЙН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

1. Байгаль орчны яам

а/ улсын үйлдвэрийн газрууд:

1. Хэвлэлийн "Орчлон" компани
2. "Нүхт" компани
3. "Халиун буга" төв

б/ төсөвт байгууллагууд:

4. Нислэгийн цаг уурын төв
5. Багаж үйлдвэрлэл, хэмжил зүйн товчоо
6. Байгаль орчны шинжилгээний төв лаборатори
7. Дархан болон тусгай хамгаалалтын газрын захиргаад
8. Мэдээлэл, тооцооллын төв
9. "Хурын шим" төв
10. Ус, цаг уурын эрдэм шинжилгээний хүрээлэн
11. Усны бодлогын хүрээлэн
12. Газрын бодлогын хүрээлэн
13. Ой, ан судлалын хүрээлэн
14. Говийг хөгжүүлэх төслийн төв

2. Батлан хамгаалах яам

а/ улсын үйлдвэрийн газрууд:

1. Барилгын цэргийн ангиуд
2. Цэргийн худалдааны анги, байгууллагууд
3. Цэргийн үйлдвэр, худалдааны "Зэв" концерн
4. Цэргийн дүрэмт хувцасны "Бөртэ" компани
5. Цэргийн хэвлэлийн "Шувуун саарал" компани
6. Цэргийн авто тээврийн 026 дугаар анги
7. Цэргийн зэвсэг, техникийн засварын "Сэргэлт" компани
8. Ахмад дайчдын "Халамж" компани
19. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах, уурхайн эдэлбэрийн талбайн хэмжээг өөрчлөх тухай өргөдлийг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 180 хоногийн өмнө зөвшөөрөл олгосон байгууллагад хандаж гаргана. Өргөдлийн загвар, маягтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

20. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах, уурхайн эдэлбэрийн талбайн хэмжээг өөрчлүүлэхээр гаргасан өргөдөлд дор дурдсан материалыг хавсаргана:

а/ хугацаа сунгуулах үндэслэл, ордыг ашиглах нөөцийн хэмжээний тооцоо;

б/ уурхайн эдэлбэрийг түрээслэх гэрээний үндсэн нөхцөлийн биелэлтийн талаархи түрээслүүлэгчийн дүгнэлт;

в/ уурхайн эдэлбэрийн талбайн шинэчилсэн зураг, газар эдэлбэрийн өөрчлөлтийг зөвшөөрсөн тухай эрх бүхий байгууллагын шийдвэр;

г/ байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, зардалд орох өөрчлөлтийн тооцоо, дүгнэлт.

21. Анх тусгай зөвшөөрөл олгосон байгууллага зөвшөөрлийн хугацааг сунгуулах, уурхайн эдэлбэрийн талбайн хэмжээг өөрчлүүлэх талаар гаргасан өргөдөл, холбогдох материалыг хүлээн авч шаардлагатай нөхцөлд уурхайн эдэлбэрийг түрээслүүлэх гэрээг шинэчлэн хийлгэж ордын үлдсэн нөөцийг ашиглах хугацаагаар нэг удаа хууль тогтоомжид заасан хугацаанд багтаан сунгах, уурхайн эдэлбэрийн талбайн хэмжээг өөрчлөх шийдвэрийг гаргана.

Тав. Тусгай зөвшөөрөл эзэмшигч эрх үүргээ бусдад шилжүүлэх

22. Орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уул зөвшөөрөл болон түүний дагуу байгуулсан гэрээгээр авсан эрх, хүлээсэн үүргийг тусгай зөвшөөрлийг олгосон төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусад этгээдэд шилжүүлэх буюу эрх, үүргийг өөрчилсөн ямар нэгэн гэрээ байгуулахыг хориглоно.

23. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дампуурсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хэрэг хариуцах чадваргүй болсон, татан буугдсан тохиолдолд тусгай зөвшөөрөл анх олгосон төрийн захиргааны байгууллага уул тусгай зөвшөөрлөөр олгосон эрхийг бусдад шилжүүлэхээр шийдвэрлэж болно.

24. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх тухай өргөдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигч ба шилжүүлэн авах этгээд хамтран гаргаж тусгай зөвшөөрөл анх олгосон эрх бүхий байгууллагад ирүүлнэ. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэхээр гаргах өргөдлийн загвар, маягтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

25. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх тухай хамтарсан өргөдөлд дараахь бичиг баримтыг хавсаргана. Үүнд:

а/ тусгай зөвшөөрлийг шилжүүлэх үндэслэл, шалтгаан, тайлбар;

б/ тусгай зөвшөөрлийг эзэмшигч ба шилжүүлэн авах этгээдийн эрхэлж буй үйл ажиллагааны талаархи мэдээлэл;

в/ тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авч буй этгээдээс уурхайн эдэлбэрийн түрээсийн гэрээнд тусгагдсан үүргийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүлээн авч байгаа тухай албан ёсны мэдэгдэл;

г/ тусгай зөвшөөрлийг эзэмшигч ба шилжүүлэн авч буй этгээдийн хооронд байгуулах гэрээ хэлцлийн төсөл.

26. Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх тухай хамтарсан өргөдөл, эрх үүргийг шилжүүлэн авах тухай мэдэгдлийг анх уг зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллага хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор шийдвэрлэж хариу мэдэгдэнэ.

Засгийн газрын 1995 оны 28 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛ ХИЙХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.Энэхүү журмаар хайгуул хийх тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлийг хүлээн авах, бүртгэх, хянан шийдвэрлэх болон шалгаруулалт явуулах үйл ажиллагааг зохицуулна.

2. Эрх бүхий байгууллагаас олгосон хайгуулын тусгай зөвшөөрөлгүйгээр аливаа хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт хайгуулын ажил явуулахыг хориглоно. Харин ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч ашиглаж буй ордынхоо уурхайн эдэлбэрийн талбайд жигүүрийн болон гүний хэсэг, бусад хүдрийн биетэд хайгуул болон ашиглалтын хайгуулын ажил явуулахад хайгуулын тусгай зөвшөөрөл авахгүй.

3. Уурхайн үйлдвэр нь хаагдсан, эзэмшигч байхгүй байгаа уурхайн овоолгод ашигт малтмалын хайгуул хийх ажлыг энэхүү журмаар зохицуулна.

4. Улсын төсвөөр санхүүжүүлэх геологи хайгуулын ажил явуулахад энэхүү журмыг мөрдөхгүй бөгөөд түүнийг Монгол Улсын Их Хурлаас баталсан жил бүрийн төсвийн хүрээнд багтаан геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ хэрэгжүүлнэ.

5. Гадаад орны Засгийн газар, пүүс, компани, олон улсын байгууллагын буцалтгүй тусламжийн хүрээнд уг ашигт малтмалын ордыг хожим ашиглах давуу эрх эдлэхгүй нөхцөлөөр явуулах геологи, хайгуулын ажилд энэхүү журмыг мөрдөхгүй.

Хоёр. Ашигт малтмалын хайгуул хийх тусгай зөвшөөрөл

6. Төрийн эрх бүхий байгууллагаас ашигт малтмалын орд, илрэл, талбайд хайгуул хийх эрх олгосон гэрчилгээг тусгай зөвшөөрөл гэнэ.

7. Стратегийн болон тусгай ашигт малтмалын хайгуул хийх тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага; ердийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллагатай албан ёсоор зөвшилцсөний үндсэн дээр аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно.

8. Ашигт малтмалын хайгуул хийх тусгай зөвшөөрөл олгосныг нотлох гэрчилгээний маягтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд батална.

Гурав. Ашигт малтмалын хайгуул хийх талбай, орд, илрэлийг зарлах

9. Төрийн захиргааны төв байгууллагаас дотоодын болон гадаадын аж ахуйн нэгж /хуулийн этгээд/-д ашигт малтмалын хайгуул хийлгэх талбай, орд, илрэлийн жагсаалтыг тухай бүр гаргана.

10. Ийнхүү жагсаалт гаргасны дараа хэрэв уг талбай, орд, илрэл нь улсын тусгай хамгаалалттай газрын хилийн цэсэд оршиж байвал Монгол Улсын Их Хуралд; улсын тусгай хэрэгцээний газрын хилийн цэсэд оршиж байвал Засгийн газарт тус тус өргөн мэдүүлж зөвшөөрөл авна. Хэрэв орд, илрэл, талбай нь аймаг, нийслэлийн тусгай хэрэгцээний газрын цэсэд байвал аймаг, нийслэлийн Засаг дарга нараас албан ёсны саналыг нь бичгээр авна.

11. Улсын Их Хурал, Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан жагсаалтыг судлан үзээд уг талбай, орд, илрэл нь улс, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн ашиг сонирхол хийгээд, түүх соёлын дурсгал, ард түмний зан үйлд харшлах болон хүндэтгэх бусад шалтгаантай гэж үзвэл тэнд ашигт малтмалын хайгуул хийлгэхээс татгалзаж болно. Энэхүү тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага уг талбай, орд, илрэлийг жагсаалтаас хасна.

12. Төрийн захиргааны төв байгууллага нь Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаас албан ёсоор зөвшөөрсөн талбай, орд, илрэлийн жагсаалтыг төр, засгийн сониноор дамжуулан нийтэд зарлан мэдээлнэ.

Дөрөв. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөл хүлээн авах, шийдвэрлэх

13. Энэхүү журмын 12-т заасны дагуу нийтэд зарлан мэдээлсэн ашигт малтмалын талбай, орд, илрэлд хайгуул хийхийг сонирхсон Монгол Улсын аж ахуйн нэгж /хуулийн этгээд/, Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж /гадаадын хуулийн этгээд/ өргөдлөө төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт гаргана.

14. Нийтэд зарлан мэдээлснээс бусад талбай, орд, илрэлд өөрийн хөрөнгөөр хайгуул хийх хүсэлтэй хуулийн этгээд энэ тухай өргөдлөө төрийн захиргааны төв байгууллага болон аймаг,

нийслэлийн Засаг даргын Тамгын газарт гаргаж болно. Энэхүү тохиолдолд өргөдлийг хянан хэлэлцэж шийдвэр гаргах хүртэл хугацаанд уг талбай, орд, илрэлд өөр өргөдөл хүлээн авахгүй.

15. Ийнхүү өргөдөл гаргахдаа тухайн хуулийн этгээд өөрийн албан ёсны хаяг, хуулийн этгээдийн гэрчилгээ, эрхэлдэг үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүүгийн болон боловсон хүчний хангамжийн талаар тусгасан байна. Өргөдлийн загвар маягтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд батална.

16. Мөн өргөдөлд хайгуулын ажил гүйцэтгэх урьдчилсан гэрээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (төсөл) зэрэг баримт бичгийг хавсаргасан байна. Эдгээр баримт бичгийн загварыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд батална.

17. Тухайн хуулийн этгээдийн өргөдлийг төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хүлээн авааД хуулийн шаардлага хангасан эсэхийг тогтооно. Хуулийн шаардлага хангаагүй тохиолдолд уг өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор буцаана.

18. Хуулийн шаардлага хангасан өргөдлийг төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бичиг хэргээр бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүлээн авсанд тооцно.

19. Хэрэв өргөдлөө гаргасан хуулийн этгээдэд ашигт малтмалын хайгуул хийх тусгай зөвшөөрөл олгох бололцоотой гэж шийдвэрлэвэл төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь хайгуулын ажил гүйцэтгэх урьдчилсан гэрээний төслийн саналыг бичгээр өгнө. Уг гэрээний саналд хайгуул хийх талбайн байршил, хэмжээ болон газар зүйн солбицлыг тодорхой заасан байна.

20. Хайгуулын ажил гүйцэтгэх урьдчилсан гэрээг нэг талаас төрийн захиргааны төв байгууллагын хайгуулын ажил эрхэлсэн нэгж ба аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсийн дарга, нөгөө талаас албан ёсны хүсэлтээ гаргасан хуулийн этгээдийн дарга, захирал нар бичгээр байгуулна.

21. Хуулийн этгээдийн өргөдлийг албан ёсоор хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногт багтаан шийдвэрлэж зөвшөөрсөн тохиолдолд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд болон аймаг, нийслэлийн Засаг даргаас хайгуулын ажлын тусгай зөвшөөрөл олгоно.

22. Ашигт малтмалын хайгуул хийхийг сонирхогч хуулийн этгээд нь төрийн захиргааны төв байгууллагаас хугацаа зааж тодорхой талбай орд, илрэлийн жагсаалтыг нийтэд зарлан мэдээлсэн хугацаанд өргөдлөө гаргана. Дурдсан хугацаанд өргөдөл ирээгүй бол төрийн захиргааны төв байгууллага хугацааг сунгаж болно. Харин энэ журмын 14-т заасны дагуу өргөдлөө гаргаж байгаа бол хугацаа харгалзахгүй.

Тав. Шалгаруулалт явуулах замаар тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах

23. Төрийн захиргааны төв байгууллагаас жил бүр нийтэд зарлан мэдээлсэн талбай, орд, илрэлд хайгуул хийх сонирхолтой хуулийн этгээдэд хайгуул хийх тусгай зөвшөөрөл олгохдоо өрсөлдүүлэн шалгаруулах зарчим баримтална.

24. Өргөдлийг хянан үзэж санал боловсруулахдаа дараахь үндсэн үзүүлэлт болон шалгуурыг харгалзан үзнэ. Үүнд:

а/ тухайн өргөдөлд заасан орд, илрэл, талбайд урьд олгосон тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байгаа эсэх;

б/ тухайн орд, илрэл, талбай хууль тогтоомжоор хориглосон газар байгаа эсэх;

в/ тухайн талбайд урьд өмнө зөвшөөрөл авааД тодорхой хүчин зүйлээс хамааран шийдвэрлээгүй орхисон эсэх;

г/ өргөдөл ирүүлсэн дараалал;

д/ төрийн захиргааны төв байгууллагаас зарласан жагсаалтад тухайн өргөдөлд заасан орд, илрэл орсон эсэх.

25. Хайгуул хийх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл хүлээн авах, түүнийг хянан санал боловсруулах ажлыг төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын мэргэжлийн холбогдох газар, хэлтэс хариуцан боловсруулж геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайдын болон аймаг, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

26. Хайгуул хийх тусгай зөвшөөрлийг өрсөлдүүлэн шалгаруулж олгохдоо дараахь үндсэн үзүүлэлт буюу шалгуурыг харгалзана:

а/ хайгуулын ажил гүйцэтгэх урьдчилсан төсөл;

б/ байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /төсөл/;

в/ сонирхогч этгээдийн мэргэжлийн болон техник технологийн түвшин;

г/ ашигт малтмалын төрөл, онцлогтой холбогдсон бусад үзүүлэлт.

27. Өрсөлдөгчдийн боловсруулсан төсөл өөр хоорондоо адил байгаа нөхцөлд өргөдөл хүлээн авсан дарааллыг харгалзан үзнэ.

28. Ашигт малтмалын хайгуул хийх тусгай зөвшөөрөл олгохдоо геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд тушаал болон аймаг, нийслэлийн Засаг дарга захирамж гаргаж, уг тусгай зөвшөөрөлд гарын үсгээ зурна.

29. Ийнхүү тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрийн хөрөнгөөр ашигт малтмалын хайгуул хийх эрх эдэлнэ.

30. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын "Ашигт малтмалын тухай хууль"-д заасан хугацаа, нөхцөлөөр энэхүү эрхийг эдлэх бөгөөд мөнхүү хуульд заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулж болно.

31. Тусгай зөвшөөрлийг цуцлахдаа зөвхөн хуульд заасан үндэслэлийг баримтална.

Зургаа. Хайгуулын ажил гүйцэтгэх гэрээ байгуулах

32. Хайгуулын ажил гүйцэтгэх гэрээг тусгай зөвшөөрөл олгосон төрийн захиргааны байгууллага болон хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондоо байгуулна.

33. Хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрөл авсан өдрөөс хойш 180 хоногийн дотор гэрээ байгуулж ажлаа эхэлнэ.

34. Гэрээ байгуулалгүйгээр хайгуулын ажил эхлэхийг хориглоно.

35. Хайгуулын ажил гүйцэтгэх гэрээ болон түүнд хавсаргах баримт бичгийн загвар, маягтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд батална.

Долоо. Тусгай зөвшөөрлийн болон хайгуулын талбай эзэмшсэний хураамж төлөх

36. Хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хураамжийг тусгай зөвшөөрөл олгогчид төлнө.

37. Хайгуулын талбай эзэмшсэний хураамжийг нутаг дэвсгэр нь харьяалагдах сум, дүүргийн төсөвт төлнө.

38. Гадаадын хуулийн этгээдээс тусгай зөвшөөрлийн хугацаанд ам. дөрвөлжин км талбай тутамд жил бүр 0,3 америк доллар, эхний сунгалтын дараа жил бүр 0,6 америк доллар, хоёрдахь сунгалтын дараа жил бүр 1,2 америк доллар байхаар бодож талбай эзэмшсэний хураамж авна.

39. Монгол Улсын хуулийн этгээдээс авах талбай эзэмшсэний тусгай зөвшөөрлийн хураамжийг энэ журмын 38 дугаар зүйлд валютаар заасан хэмжээг тухайн үеийн ханшаар үндэсний валютад шилжүүлэн тооцож тогтооно.

40. Хайгуулын талбай эзэмшсэний хураамж авахдаа тухайн үеийн инфляцийн түвшингээс хамааруулан итгэлцүүр хэрэглэж болно.

Найм. Тусгай зөвшөөрөл эзэмшигч эрх, үүргээ бусдад шилжүүлэх

41. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эрх, үүргээ бусдад шилжүүлэхдээ зөвхөн Монгол Улсын "Ашигт малтмалын тухай хууль"-д заасан үндэслэлүүдийг баримтална.

42. Аливаа этгээд Монгол Улсын ашигт малтмалын тухай мэдээллийг ашиг орлого олох зорилгоор төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад худалдахыг хориглоно.

43. Аливаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл олгогчийн зөвшөөрөлгүйгээр орд газрыг бусдад хууль бус аргаар шилжүүлэхийг хориглоно.

Ес. Хайгуулын ажлын төрийн хяналт

44. Аливаа хуулийн этгээд ашигт малтмалын хайгуул хийх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хайгуулын ажил гүйцэтгэх гэрээний хамт геологи уул уурхайн улсын хяналтын байгууллагад албан ёсоор бүртгүүлнэ.

45. Геологи, уул уурхайн улсын хяналтын байгууллагад албан ёсоор бүртгүүлэлгүйгээр хайгуулын ажил эхлэхийг хориглоно.

Арав. Маргаан шийдвэрлэх

46. Ашигт малтмалын хайгуул хийх тусгай зөвшөөрөл авахаар гаргасан өргөдлийг хүлээн авах, хянан хэлэлцэх явцад гарсан маргааныг хоёр тал шийдвэрлэж эс чадвал гомдлоо геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн сайд болон аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлнэ.

47. Сайд болон Засаг даргын гаргасан шийдвэр Монгол Улсын хууль тогтоомжид харшилж байна гэж үзвэл Монгол Улсын Засгийн газарт тавьж болно.

48. Монгол Улсын Засгийн газрын уг шийдвэрийг Монгол Улсын хууль тогтоомжид харшилж байна гэж үзвэл гомдлоо шүүхээр шийдвэрлүүлнэ.

Засгийн газрын 1995 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙСЭН ХАЙГУУЛЫН АЖЛЫН ЗАРДЛЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Ашигт малтмалын тухай хуулийг мөрдөх хүртэл хугацаанд төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг шинэчлэн тогтооход энэхүү журмыг мөрдөнө.

2. Төсвийн хөрөнгөөр хийсэн урьдчилсан ба нарийвчилсан хайгуулын зардлыг энэхүү аргачлалаар шинэчлэн тогтоож, уг орд газрыг ашиглахаар тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжээр улс, орон нутгийн төсөвт төлүүлж байна.

Хоёр. Хайгуулын ажлын зардлыг шинэчлэн тогтоох

3. 1991 оноос өмнөх хугацаанд төсвийн хөрөнгөөр хийсэн эрэл үнэлгээ, хайгуулын объектуудын тайланд тусгагдсан хайгуулын ажлын анхны зардал тухайн объектын зардлыг шинэчлэн тогтоох үндэс болно.

4. Засгийн газрын 1991 оны 20 дугаар тогтоолыг үндэслэн 1991 оноос өмнөх хугацаанд төсвийн хөрөнгөөр хийсэн эрэл үнэлгээ хайгуулын объектуудын анхны зардлын цалин, түүнтэй адилтгах бүрэлдэхүүн хэсгийг 2,0 дахин, бусад материаллаг зардлыг 1,75 дахин нэмэгдүүлэн тооцно.

Хайгуулын ажлын зардлын доторхи цалин, түүнтэй адилтгах бүрэлдэхүүн хэсгийг нийт зардлын 25 хувиар, материаллаг зардлыг 75 хувиар бодож дараахь томъёогоор хайгуулын ажлын зардлыг 1991 оны түвшинд шинэчлэн тогтооно:

ХАШЗ'=/ХААЗх0,25х2,0/+/ХААЗх0,75х1,75/

ХАШЗ -Засгийн газрын 1991 оны 20 дугаар тогтоолын дагуу 1991 оны түвшинд шинэчлэн тогтоосон хайгуулын ажлын зардал

ХААЗ -Геологийн судалгааны ажлын тайланд тусгагдсан хайгуулын ажлын анхны зардал.

5. Энэ журмын 4-т заасан аргачлалын дагуу тооцсон хайгуулын ажлын зардлыг 1991 оноос хойшхи хугацаанд гарсан валютын ханшны өөрчлөлтийн итгэлцүүрээр нэмэгдүүэн өнөөгийн нөхцөл дэх хайгуулын шинэчилсэн зардлын хэмжээг тодорхойлно. Тухайлбал:

ХАШЗ -Хайгуулын ажлын шинэчилсэн зардал; К-1991 оноос хойшхи валютын ханшны өөрчлөлтийн итгэлцүүр (1995 оны байдлаар 10,0 болно) гэвэл ХАШЗ=ХАШЗ'хК болно.

Гурав. Хайгуулын ажлын зардлыг төсөвт оруулах

6. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр урьдчилсан ба нарийвчилсан хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ашигт малтмалын ордыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын ажлын зардлыг энэхүү журмын 2 дахь хэсэгт заасан аргачлалаар тооцож тогтоосон хэмжээгээр тухайн ордыг ашиглах хугацаанд төсвийн орлогод төлнө.

7. Ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг төсөвт нөхөн төлөх төлбөрийн хэмжээг дараахь аргачлалаар тооцон борлуулалтын орлогоосоо төлж байна. Үүнд:

R-хайгуулын ажлын зардлыг төсөвт нөхөн төлөх төлбөрийн хэмжээ, төгрөгөөр,

Б-тайлант хугацаанд олборлон боловсруулсан ашигт малтмалын биет хэмжээ

Н-ашиглалтын нийт хугацаанд олборлох нөөцийн биет хэмжээ

ХАШЗ'-хайгуулын ажлын шинэчилсэн зардлын нийт хэмжээ, төгрөгөөр.

$$R = \frac{ХАШЗ}{Н} \times Б$$

8. Төсвийн хөрөнгөөр хийсэн ашигт малтмалын ордын хайгуулын зардлын нөхөн төлбөрийг улсын төвлөрсөн төсөвт төлнө.

9. Ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг төсөвт төлөх төлбөрийн тооцоог улирал, жилийн эцсийн тайлан тэнцэлд тусган харилцагч татварын албадтай хийнэ.

Дөрөв. Бусад асуудал

10. Энэ журмын дагуу төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг нөхөж төлөх төлбөрийг хугацаанд нь төлөөгүй, мэдээ тайланг гаргаж өгөөгүй, худал мэдээлж тайлагнасан буруутай албан тушаалтанд татварын байцаагч хуульд заасан торгууль оногдуулна.

11. Төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх, төлбөр төлөгчийн илүү төлснийг буцаан олгох, дутууг нь нөхөн төлүүлэх тухай асуудал болон төлбөртэй холбогдсон гомдлыг Монгол Улсын Татварын ерөнхий хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

12. Энэ журмын хэрэгжилтэд Сангийн яам, Улсын татварын ерөнхий газар хяналт тавина.

Засгийн газрын 1995 оны 28 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТАЛААР ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ БҮРЭН БИЕЛҮҮЛЭХИЙН БАТАЛГАА БОЛГОЖ БАРЬЦААЛСАН ХӨРӨНГИЙГ ХУРИМТЛУУЛАХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмыг ашигт малтмалын хайгуул хийх болон орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхийн баталгаа болгож мөнгөн хөрөнгийн барьцаа гаргах, барьцаалсан мөнгөн хөрөнгийг хуримтлуулах, зарцуулах үйл ажиллагаанд зохицуулахад дагаж мөрдөнө.

2. Ашигт малтмалын хайгуул хийх болон орд ашиглах зөвшөөрөл авахыг хүссэн аж ахуйн нэгж, байгууллага нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлж болох сөрөг нөлөөг ашиглалтын явцад арилгах арга хэмжээг тогтоосон хэм хэмжээ, стандартын дагуу бүрэн тодорхойлох зорилгоор техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд холбогдох мэргэжлийн байгууллагаар байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэнэ.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн ашигт малтмалын хайгуул хийх, олборлох үедээ ухсан газрыг дарж тэгшлэх, хөрсийг нь нөхөн сэргээх, хайгуулын талбай, уурхайн эдэлбэр, түүний орчинд (цаашид "орчин" гэх) үзүүлэх сөрөг нөлөөг арилгах арга хэмжээ, түүнд шаардагдах зардлыг тодорхойлсон иж бүрэн төдөвлөгөөг жил бүр боловсруулж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон аймаг, нийслэлийн байгууллагатай санал тохиролцон тухайн шатны Засаг даргаар батлуулж хэрэгжүүлнэ.

Хоёр. Байгаль орчныг хамгаалах үүргийн гүйцэтгэлийг хангах

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн төлөвлөгөөт үүргээ бүрэн биелүүлэхийн баталгаа болгож байгаль орчныг хамгаалах арга хэмжээний жил бүрийн төлөвлөгөөт зардлын 50-иас доошгүй хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг ажил эхлэхийн өмнө тухайн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт жил бүр барьцаалан шилжүүлнэ.

5. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар байгаль орчныг хамгаалах үүргийг хангах талаар дараахь арга хэмжээ авна:

а) тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж үүргээ бүрэн биелүүлсэн бол гүйцэтгэсэн ажилд нь ногдох хэсгийг эзэмшигчид буцаан олгох;

б) тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй эсвэл дутуу биелүүлсэн бол учруулсан хохирлыг нөхөн төлүүлж барьцаалсан мөнгөн хөрөнгийг бүтнээр нь буюу биелүүлээгүй ажилд нь ногдох хэсгийг улсын орлого болгох;

в) тусгай зөвшөөрөл эзэмшигчид байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд заасан үүргээ хугацаанд нь биелүүлэх, дутуу ажлаа гүйцээж хийх шаардлага тавьж, гүйцэтгэлийг тооцож байх.

6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээний гүйцэтгэлийн хэмжээг тогтоож, барьцаалсан мөнгөний хэдэн хувийг буцаан олгох, эсвэл улсын орлого болгох, хохирлыг төлүүлэх асуудлыг геологи, уул уурхайн болон байгаль орчны хяналтын байцаагчийн акт, дүгнэлтийг үндэслэн тухайн сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ.

7. Барьцаалсан мөнгөн хөрөнгийг улсын орлого болгосон нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээс болон барьцаалсан хөрөнгөөр нөхөгдөөгүй үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй бөгөөд тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн хөрөнгөөрөө санхүүжүүлэн хүлээсэн үүргээ заавал биелүүлсэн байна.

Гурав. Барьцаалсан мөнгөн хөрөнгийг хуримтлуулах, зарцуулах

8. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн барьцаалсан мөнгөн хөрөнгийг хуримтлуулах данстай байх бөгөөд уг хөрөнгийг буцаан олгох, хохирлыг нөхөн төлүүлэх, улсын орлого болгох зэргээр зарцуулахдаа холбогдох тооцоог нарийвчлан хөтөлнө.

9. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлт болон барьцаалсан мөнгөн хөрөнгийн хуримтлуулалт, зарцуулалтын тайланг улирал тутам гаргаж, жилийн эцэст өр авлагын журмаар тооцоо нийлж, өр авлагыг ондоо багтаан барагдуулна.

10. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газраас тусгай зөвшөөрөл эзэмшигчийн барьцаалсан мөнгөн хөрөнгийг төсвийн алдагдлыг нөхөх болон зориулалт бусаар зарцуулахыг хориглоно. Иймэрчил гаргасан тохиолдолд гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол геологи, уул уурхайн болон байгаль орчны хяналтын улсын байцаагч хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Дөрөв. Маргаан шийдвэрлэх

11. Байгаль орчныг хамгаалах үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгон мөнгөн хөрөнгийн барьцаа гаргах, барьцаалсан мөнгөн хөрөнгийг хуримтлуулах, зарцуулах явцад гарсан маргааныг хоёр тал шийдвэрлэж эс чадвал гомдлоо геологи, уул уурхайн болон байгаль орчны асуудал эрхэлсэн сайд, аймаг, нийслэлийн Засаг даргад гаргана.

12. Сайд болон Засаг даргын шийдвэр нь Монгол Улсын хууль тогтоомжид харшилж байна гэж үзвэл гомдлоо шүүхээр шийдвэрлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 2 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 29 | Улаанбаатар хот

Журам батлах тухай

Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шударга бус өрсөлдөөнийг хориглох, хянах, зохицуулах ажлыг зохион байгуулах журмыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а) шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай Монгол Улсын хууль, энэхүү журмыг хэрэгжүүлэх үүргийг Засаг даргын Тамгын газрын тодорхой ажилтанд хариуцуулан ажиллуулсугай;

б) нутаг дэвсгэртээ байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд судалгаа хийлгэж, тухайн зах зээлд дангаар ноёрхогч буюу давамгайлах байдалтай байгаа, эсвэл тэр байдлаа алдсанд тооцогдох аж ахуйн нэгжийн талаар дүгнэлт гаргуулж тухай бүр шүүхээр тогтоолгон нийтэд мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажилласугай;

в) энэхүү журмын дагуу аж ахуйн нэгж, иргэд, олон нийтийн байгууллагаас гаргасан санал, гомдлыг үндэслэн шударга бус өрсөлдөөнийг хориглох, таслан зогсоох арга хэмжээг шуурхай авч байсугай.

3. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүргийг хариуцан гүйцэтгэх нэгжийг цалингийн сандаа зохицуулан зохион байгуулж ажиллуулахыг Үндэсний хөгжлийн газар (Ч. УЛААН)-т зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд — П. ЖАСРАЙ

Монгол Улсын сайд бөгөөд
Үндэсний хөгжлийн газрын дарга — Ч. УЛААН

Засгийн газрын 1995 оны
29 дүгээр тогтоолын хавсралт

ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨНИЙГ ХОРИГЛОХ, ХЯНАХ, ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1. Засгийн газар, түүний эрх олгосон байгууллагуудаас "Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай" Монгол Улсын хуулийн дагуу өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгжээс үйл ажиллагаагаа явуулах явцад гарсан шударга бус үйл ажиллагааг хориглох, хязгаарлах, хянах, зохицуулах ажлыг зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө.

2. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх явцад хяналт тавих, гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж дүгнэлт гаргах, шударга бус өрсөлдөөнийг хориглох, хязгаарлах талаар шийдвэр гаргуулах, хэрэгжилтийг зохион байгуулах үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газар, Үндэсний хөгжлийн газар, бүх шатны Засаг даргын Тамгын газар хариуцан гүйцэтгэнэ.

Хоёр. Дангаар ноёрхогч болон давамгайлах байдалтай аж ахуйн нэгжийг тогтоох

3. Аж ахуйн нэгжийн дангаар ноёрхогч болон зүй ёсны дангаар ноёрхогч эсвэл давамгайлах байдалтай болохыг түүнчлэн тэр байдлаа алдсаныг тогтоох судалгааг улсын хэмжээний зах зээлд Үндэсний хөгжлийн газар; тухайн орон нутгийн зах зээлийн хүрээнд аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцан гүйцэтгэнэ.

4. Үндэсний хөгжлийн газар болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар (цаашид "зохицуулагч байгууллагууд" гэнэ) тухайн зах зээлд дангаар ноёрхогч болон зүй ёсны дангаар ноёрхогч, эсвэл давамгайлах байдалтай байгаа аж ахуйн нэгжийн талаархи судалгааг энэхүү журамд хавсаргасан хүснэгтүүд (хүснэгт N1,2)-ийн дагуу гарган дүгнэлт хийж тухайн зах зээл дээр дангаар ноёрхогч болон зүй ёсны дангаар ноёрхогч, эсвэл давамгайлах байдалтайг зохих шатны шүүхийн байгууллагаар тогтоолгон, түүнийгээ жил бүр тодотгож байна.

5. Аж ахуйн нэгжийн давамгайлах, дангаар ноёрхох болон зүй ёсоор дангаар ноёрхох байдалтайг тогтоохдоо шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулинд заасан шалгуур үзүүлэлтийг үндэс болгоно.

6. Зохицуулагч байгууллагууд аж ахуйн нэгжийн зах зээлд үйлчлэх байдлыг тогтоох судалгааг явуулж, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулах зорилгоор дараахь мэдээллийг байгууллага, аж ахуйн нэгжээс гаргуулан авна. Үүнд:

а) албан ёсоор:

-статистикийн албан ёсны мэдээлэл (тухайн жилд үйлдвэрлэж борлуулсан бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ, экспорт, импортын дүн)-ийг Улсын статистикийн газраас авах бөгөөд мэдээлэл авах журам, үзүүлэлтийг Улсын статистикийн газартай тохирно;

-аж ахуйн нэгжээс тухайн жилд үйлдвэрлэсэн, экспортод гаргасан буюу импортолсон бараа (нэр, төрөл, тоо хэмжээгээр)-ны талаархи мэдээлэл.

б) шаардлагатай тохиолдолд:

-үнийн зөвшлийн комиссоос үнийн түвшин, нийтлэг жишгийн талаархи зөвлөмж, чиглэл болон тухайн зах зээлд дангаар ноёрхогч болон давамгайлах байдалтай аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүний үнэ, үйлчилгээний тарифын талаархи судалгаа;

-татвар гаалийн байгууллагаас аж ахуйн нэгжийн тухайн жилд борлуулсан, экспортод гаргасан буюу импортолсон барааны хэмжээ, байгуулсан гэрээ хэлцэл;

-аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний өртөг зардал, үнэ тариф, ажиллагчдын цалин, хөдөлмөрийн бүтээмж, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн талаархи нэмэлт судалгаа, мэдээлэл.

Гурав. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах

7. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомжийн биелэлтэд Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам, тусгай газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Үнийн зөвшлийн комисс, татвар, гааль, цагдаагийн байгууллага тус тусын чиг үүргийн дагуу хяналт

тавих бөгөөд харилцан мэдээлэл солилцох, санал, үндэслэл гаргуулах, шаардлагатай үзлэг, шалгалтыг хамтран явуулах, энэ ажилд хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах олон нийтийн байгууллага, иргэдийг тэдэнтэй тохиролцон оролцуулах, зөрчил дутагдлыг илрүүлж шуурхай арилгах арга хэмжээ авч байна.

8. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын гаргасан шийдвэр нь шударга бус өрсөлдөөнийг хориглохтой холбогдсон хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд Хууль зүйн яам хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах талаар Үндэсний хөгжлийн газартай хамтран ажиллана.

9. засгийн газрын болон аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх үнийн зөвшлийн комисс нь тухайн зах зээлд дангаар болон зүй ёсны дангаар ноёрхогч, давамгайлах байдалтай аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүний үнэ, үйлчилгээний тарифыг бүртгэж, хууль зөрчсөн эсэхэд хяналт тавих бөгөөд илэрсэн зөрчлийг арилгах талаар зохицуулагч байгууллагуудтай хамтран ажиллана.

10. Бүх шатны татварын албад аж ахуйн нэгжийг бүртгэхдээ дараахь асуудалд онцгой анхаарч хяналт тавьж хэрэгжүүлнэ. Үүнд:

-шинээр үүсч байгаа аж ахуйн нэгжийг бүртгэхдээ Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 7 дугаар зүйлд заасныг харгалзан үзэж байх;

-давамгайлах байдалтай аж ахуйн нэгжүүд өөр хоорондоо нэгдэх хүсэлт тавибал тэдгээрийн зорилго нэгдсэний дүнд зах зээлд үзүүлэх нөлөөг тогтоож, Хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасантай нийцүүлэх, шаардлагатай бол энэ талаар зохицуулагч байгууллагуудаар дүгнэлт гаргуулах.

11. Шударга бус өрсөлдөөнийг хориглохтой холбогдсон хууль тогтоомж зөрчсөн талаар гарсан санал, гомдлыг Үндэсний хөгжлийн газар болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрууд хүлээн авч үзлэг, судалгаа хийж, шалгаж дүгнэлт гарган 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

12. Үндэсний хөгжлийн газар улсын хэмжээний зах зээлд дангаар ноёрхогч, давамгайлах байдалтай байгаа нь тогтоогдсон аж ахуйн нэгж, байгууллагатай холбоотойгоор гарсан санал, гомдлыг хүлээн авч мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах

буюу холбогдох шалгалт, судалгаа явуулсны үндсэн дээр 21 хоногийн дотор шийдвэрлэнэ.

13. Зохицуулагч байгууллагууд шалгалт, судалгааны дүнд буруутай нь тогтоогдсон аж ахуйн нэгжид хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагааг таслан зогсоох, гэрээгээ бүрэн буюу хэсэгчлэн цуцлах болон биелүүлэхээс татгалзах, зөрчил гарахаас өмнөх байдлыг сэргээн тогтоохыг шаардаж, зөрчил, алдааг засуулах арга хэмжээг тодорхойлсон зөвлөмж өгнө. Уг аж ахуйн нэгж нь 7 хоногийн дотор зөвлөмжийг хүлээж авах эсэхээ зохицуулагч байгууллагуудад албан ёсоор мэдэгдэнэ.

14. Зөрчил гаргасан аж ахуйн нэгж, байгууллага зөвлөмжийг хүлээж авсан бол түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон шийдвэр гаргана. Уг шийдвэрт зөрчлийг арилгахад чиглэгдсэн арга хэмжээ, харилцан хүлээх үүрэг, хариуцлага, биелүүлэх хугацаа тодорхой тусгагдсан байвал зохино. Зөвлөмж хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор түүний дагуу авсан арга хэмжээгээ зохицуулагч байгууллагад албан ёсоор мэдэгдэнэ.

15. Хууль зөрчсөн этгээд зөвлөмжийг хүлээн авахаас татгалзвал зохицуулагч байгууллага уг асуудалтай холбогдох баримт, үндэслэл, мэргэжлийн дүгнэлтээ шүүхэд шилжүүлж нэхэмжлэл гаргана.

Онцгой тохиолдолд зохицуулагч байгууллага зөвлөмж гаргалгүйгээр шууд үндэслэл материалыг бүрдүүлж торгууль, шийтгэвэр ногдуулах талаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

16. Үндэсний хөгжлийн газар дангаар ноёрхох болон давамгайлах байдлаа хууль бусаар ашиглаж байгаа нь тогтоогдсон аж ахуйн нэгжийг задалж шударга өрсөлдөөн бий болгох, шинээр үүсч байгаа өрсөлдөгчийг дэмжих арга хэмжээг макро эдийн засгийн бодлого, зохицуулалтын арга хэлбэрээр дамжуулан хэрэгжүүлнэ.

Зүй ёсны дангаар ноёрхогчийн талаар өөрсдийн хийсэн судалгаа дүгнэлт, Засгийн газрын дэргэдэх үнийн зөвшлийн комиссын гаргасан зөвлөмж, чиглэл болон ирсэн санал, мэдээлэлд үндэслэн шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлаар санал, үндэслэл боловсруулан Засгийн газарт оруулж шийдвэрлүүлж байна.

17. Зохицуулагч байгууллагууд шударга бус өрсөлдөөнийг хориглохтой холбогдсон хууль тогтоомжийн талаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудын дунд сургалт явуулах, сурталчилгаа хийх, гаргасан шийдвэрээ нийтэд мэдээлэх, аж ахуйн нэгж, иргэдэд зөвлөлгөө өгөх ажлыг зохион байгуулна.

Дөрөв. Хуулийг хэрэгжүүлэх явц дахь ажлын уялдаа холбоо

18. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагууд шаардлагатай үед тэдгээрт харьяалагдах төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллага, түүнчлэн төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн зах зээлд үйлчилж байгаа байдал, шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомжийн хүрээнд үйлдвэрлэл, ажил, үйлчилгээгээ хэрхэн явуулж байгаа тухай тайлан, өрсөлдөөнийг дэмжих, ноёрхох үйл ажиллагааг хязгаарлах талаар дүгнэлтийг Үндэсний хөгжлийн газарт ирүүлж байна.

19. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрууд шударга бус өрсөлдөөнийг хориглох хууль тогтоомж тухайн орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа тухай тайлан, цаашид авах арга хэмжээний талаар саналаа эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн төсөлд тусган тогтоосон хугацаанд Үндэсний хөгжлийн газарт ирүүлж байна.

20. Мэргэжлийн хяналтын байгууллагууд, үнийн зөвшлийн комисс болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах олон нийтийн байгууууллагууд, тэдгээрийн ажилтнууд албан үүргээ гүйцэтгэх явцад иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хууль бус үйл ажиллагаа явуулж байгааг илрүүлсэн тухай бүрт энэ талаар зохицуулагч байгууллагуудад шуурхай мэдээлж, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч байна.

21. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн шударга бус өрсөлдөөнийг хориглохтой холбогдсон хууль тогтоомжийг зөрчсөн үйл ажиллагаанаг илрүүлсэн, үүний улмаас эрх ашиг нь хөндөгдөж байгаа болон хөндөгдөж болох тухай асуудлаар санал, гомдлоо аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт бичгээр ирүүлэх ба тэр нь зөрчлийн талаар аль болох тодорхой, үнэн зөв баримт нотолгоотой байвал зохино.

22. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрууд улсын хэмжээний зах зээлд дангаар ноёрхогч болон давамгайлах байдалтай нь тогтоогдсон аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбоотой санал, гомдлыг Үндэсний хөгжлийн газарт тавьж шийдвэрлүүлнэ.

23. Шударга бус өрсөлдөөнийг хориглохтой холбогдсон хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагааг хянах талаар зохицуулагч байгууллагын ажилтан дараахь эрх эдэлнэ. Үүнд:

-тухайн хэрэгт холбоотой бизнесийн байгууллага, ажлын байруудад санхүүгийн бүртгэл, гэрээ хэлэлцээр болон бусад баримт бичгүүдтэй танилцах;

-санхүүгийн бүртгэлүүд болон бусад холбогдол бүхий баримт бичгийг эзэмшигч хүнээс үзүүлэхийг шаардах, судлахаар авах, шаардлагатай бол хувилан авч хадгалах;

-тухайн хэрэгт холбогдох хүмүүс болон гэрчүүдээс сонирхсон зүйлээ асууж танилцах, илтгэл үндэслэл бичүүлж авах;

-мэргэжлийн хяналт шалгалтын байгууллагууд, үнийн зөвшлийн комисс болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн ажилтнуудыг тэдэнтэй тохиролцон хяналтын ажилд оролцуулах.

24. Зохицуулагч байгууллагууд гаргасан шийдвэрээ санал гомдол тавьсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд мэдэгдэнэ.

25. Төр, засгийн байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагаас шударга бус өрсөлдөөнийг хориглохтой холбогдсон хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэр гаргасан, мөн аймаг, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийг хүлээн авах боломжгүй буюу энэ асуудлыг уг зөвлөлийн хурлаар шийдвэрлэх эрх зүйн үндэсгүй гэж үзвэл энэ тухай санал, гомдлыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, олон нийтийн холбогдох байгууллага Үндэсний хөгжлийн газарт тавина.

26. Яам, тусгай газрын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга шударга бус өрсөлдөөнийг хориглохтой холбогдсон хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэр гаргасан бол Үндэсний хөгжлийн газар тухайн шийдвэрийг хүчингүй болгуулах саналаа Хууль зүйн яамаар хянуулан зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

Нударга оус орсөлдөөнийг хориглох, хянах, зохицуулах журмын хавсралт

Хүснэгт № 1

АЖ АХУЙН НЭГЖИЙН ДАВАМГАЙЛАХ (ДАНГААР НОЁРХОГЧ) БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

19... он

Д/Д	Аж ахуйн нэгж, түүний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Тухайн аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний нийлүүлэлт /үйлдвэрлэлтээс экспортоо хасаад/	Тухайн бүтээгдэхүүний нийт нийлүүлэлт /нийт үйлдвэрлэлтээс экспорт хасч импортыг нэмэд/	Аж ахуйн нэгжийн нийлүүлсэн бүтээгдэхүүний нийт тухайн бүтээгдэхүүний нийлүүлэлтэд эзлэх хувийн жин / Х /

Хүснэгт № 2

ЗҮЙ ЕСИЙН ДАНГААР НОЁРХОГЧИЙН СУДАЛГАА

19... он

Д/Д	Аж ахуйн нэгж, түүний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Үйлдвэрлэлийн хүч чадал	Тухайн бүтээгдэхүүний нийт хэрэгцээ *	Үйлдвэрлэлт	Хэрэгцээ, хангалтын түвшин	Борлуулалтын нийт орлого /сая. төг/	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний		Тайлбар, дүгнэлт
								бор-луу-лал-тын дүн	бүрэн эрийн өртөг	

* Нийт хэрэгцээ гэдэгт судалгаа явуулах бүй тухайн (улсын болон орон нутгийн) зах зээлийн (хүн амын) хэрэгцээг авч үзнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 2 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 30 | Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, гадаад орнуудын Засгийн газрын хооронд эдийн засаг, худалдаа, соёл, шинжлэх ухаан, технологийн талаар хамтран ажиллах Засгийн газар хоорондын комиссын монголын хэсгүүдийн ажлыг нэгтгэн зохицуулах комиссын дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Монгол Улсад зохиогдох Засгийн газар хоорондын комиссын хуралдааны зардлыг уг комиссын Монголын хэсгийн даргын тэргүүлэн удирдаж байгаа яам, тусгай газрын тухайн жилийн гадаад арга хэмжээний төсөвт; Засгийн газрын хоорондын комиссын хуралдаанд оролцохоор гадаадад явах төлөөлөгчдийн зардлыг төлөөлөгчийн ажиллаж байгаа яам, тусгай газрын тухайн жилийн гадаад арга хэмжээний төсөвт тус тус тусган санхүүжүүлж байхаар тогтоосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд П. ЖАСРАЙ

Монгол Улсын Шадар сайд Ч. ПҮРЭВДОРЖ

Засгийн газрын 1995 оны
30 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ГАДААД ОРНУУДЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХООРОНД ЭДИЙН ЗАСАГ, ХУДАЛДАА, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТАЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН КОМИССЫН МОНГОЛЫН ХЭСГҮҮДИЙН АЖЛЫГ НЭГТГЭН ЗОХИЦУУЛАХ КОМИССЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Засгийн газар, гадаад орнуудын Засгийн газрын хооронд эдийн засаг, худалдаа, соёл, шинжлэх ухаан, технологийн талаар хамтран ажиллах Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгүүдийн ажлыг нэгтгэн зохицуулах комисс /цаашид "Засгийн газар хоорондын комиссын монголын хэсгүүдийн ажлыг зохицуулах комисс" гэж нэрлэх/ нь эдийн засгийн гадаад харилцаа, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын Засгийн газрын болон Засгийн газрын бус комисс, хороодын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, эдгээр комисс, хороодын шугамаар тохиролцсон арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг нэгтгэн зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус Засгийн газрын байгууллага /ажлын алба/ мөн.

2. Засгийн газар хоорондын комиссын монголын хэсгүүдийн ажлыг зохицуулах комисс нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, хууль тогтоомжийн холбогдох бусад акт, энэ дүрмийг удирдлага болгоно.

3. Комисс гишүүдтэй байна. Комиссын гишүүдийг Монгол Улсын Засгийн газар батална.

4. Засгийн газар хоорондын комиссын монголын хэсгүүдийн ажлыг зохицуулах комисс нь эрх хэмжээнийхээ асуудлаар Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн тогтоол, хуралдаанаасаа протокол гаргаж, тэдгээрийн биелэлтийг зохион байгуулж хангуулна.

5. Засгийн газар хоорондын комиссын монголын хэсгүүдийн ажлыг нэгтгэн зохицуулах комисс нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

Жоёр. Засгийн газар хоорондын комиссын монголын жэсгүүдийн ажлыг зохицуулах комиссын үүрэг, эрх

6. Засгийн газар хоорондын комиссын монголын хэсгийн ажлыг зохицуулах комисс дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/ гадаад орнуудтай эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн талаар хамтран ажиллах Засгийн газар хоорондын болон Засгийн газрын бус комисс, хороодын монголын хэсгүүдийн үйлажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрийн хуралдааны шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;

б/ Засгийн газар хоорондын болон Засгийн газрын бус комисс, хороодын хуралдаанаар хэлэлцэх асуудлуудын талаар чиглэл өгч бэлтгэлийг хангуулах ажил зохион байгуулах;

в/ Засгийн газар хоорондын комиссын хэмжээнд тохиролцсон шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх ажил хариуцсан хүмүүсийн сонсголыг хуралдаанаараа хэлэлцэж, удирдамж чиглэл өгөх;

г/ Засгийн газар хоорондын комиссын хуралдаанд ажил хэрэгч хүмүүсийг оролцуулах, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхтэй холбогдсон асуудлаар тэднээс тавьж байгаа саналыг судалж дүгнэлт, чиглэл гаргах.

7. Засгийн газар хоорондын комиссын монголын хэсгүүдийн ажлыг зохицуулах комисс дор дурдсан эрх эдэлнэ:

а/ Засгийн газар хоорондын болон Засгийн газрын бус комисс, хороодын монголын хэсгүүдийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг холбогдох яам газруудтай тохиролцсоны үндсэн дээр томилох;

б/ комиссуудын хуралдааныг хийх хугацаа, хэлэлцэх асуудлыг хянан үзэж зохицуулах хуралдаанд оролцох төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг яам газруудын саналыг үндэслэн шийдвэрлэх;

в/ комисс, хороодын хуралдааны шийдвэрийн биелэлтийг яам, газруудаар гаргуулж, үр дүнг хэлэлцэн, авах арга хэмжээний талаар холбогдох яам, газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт үүрэг өгөх;

г/ яам, газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас эрхэлсэн ажлын хүрээндээ холбогдсон асуудлаар лавлах материал гаргуулан авах.

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ:

Ерөнхий эрхлэгч	Н.Ринчиндорж
Нарийн бичгийн дарга	Сан. Жаргалсайхан
Гишүүд	Т.Баасансүрэн
	Ч.Бавуу
	Б. Ганбат
	Б. Янжинлхам
Техник редактор	Т. Сарантуяа
Уншиж хянасан	Сан. Жаргалсайхан
	Б. Янжинлхам

Манай хаяг: Улаанбаатар-12, Төрийн ордон
Утас 322838

Үйлдвэрт шилжүүлсэн 1995 оны 5-р сарын 13-нд. Өрөлтөд 1995 оны 5-р сарын 18-нд. Хэвлэлтэд 1995 оны 6-р сарын 8-нд. Цаасны хэмжээ 30x42см. Хэвлэлийн хуудас 13,0. Хэвлэсэн тоо 4720 ширхэг.